Харилцан ойлголцоход тулгардаг саадын нэг болох Өмнөд, Умардын хэлний асуудлыг тайлб арлахад түгээмэл хэрэглэдэг нэр томьёо нь “хэлний ондоошил” юм. Энэ нь хуваагдсанаас х ойш хуримтлагдсан үгийн сан, дуудлага, хэл зүй, бичлэг болон хэлний хэрэглээний ялгааг ил эрхийлэхэд тохиромжтой, бодит байдлыг тусгасан хэллэг мөн. Гэхдээ хоёр талын хэл мөн ч анараараа өөр хэл болсон мэт сэтгэгдэл төрүүлж болзошгүй учир болгоомжтой хэрэглэх ёс той. Хоёр талын хэлний ялгаа бүх салбарт ижил хэмжээнд илэрдэггүй. Өдөр тутмын хэл, үн дсэн хэл зүйд нийтлэг шинж нь өндөр хэмжээнд хадгалагдсан байхад захиргаа, хууль, эдийн засаг, шинжлэх ухаан, технологи, эрүүл мэнд, боловсрол зэрэг мэргэжлийн салбарт түүхийн явцад нэлээд ялгаа хуримтлагджээ. Иймд энэхүү илтгэлийн гарчигт “ондоошил” гэдэг үг хэр эглэсэн ч хоёр талын хэлийг зөвхөн адил, эсвэл өөр гэсэн хоёрын аль нэгээр тодорхойлохы н оронд “бүтцийн нийтлэг суурин дээр салбар, түвшин бүрийн ялгаа жигд бус давхарлан хур имтлагдаж, тэр ялгаа нь бодит хэрэглээнд илэрч буй байдал” гэж ойлгох шаардлагатай.

Харилцан ойлголцоход саад болдог илүү суурь шалтгаан нь хэлний ялгаа өөрөө гэхээсээ хо ёр тогтолцоонд амьдарч буй хэл хэрэглэгчид уг ялгааг хэрхэн тайлбарлаж, үнэлж байгаад ч оршино. Өмнөдөд Умардын хэлийг хуучирсан, хөшүүн, эсвэл улс төрийн нөлөөгөөр бохирдс он хэл хэмээн шоглон дүрслэх хандлага байдаг. Умардад ч Өмнөдийн хэлийг харь үг хэт ол ноор холилдсон “хутгалдсан хэл”, бохирдсон хэл гэж тодорхойлж ирсэн. Ялангуяа Умардад 2023 онд баталсан «Пён-яны соёлын хэлийг хамгаалах тухай хууль» нь Өмнөд маягийн үг хэ ллэг, ярих хэв маягийг хэлний жам ёсны хувилбар бус, төрийн тогтолцоо, соёлд заналхийлж буй, няцаан хориглох зүйл гэж үздэг. Энэ бол нэн харамсалтай хэрэг юм.

Энэхүү илтгэл өмнө нь ч олонтоо хөндөгдөж байсан дараах асуудлуудаас эхэлнэ. Нэгдүгээрт, Ө мнөд, Умардын хэл юугаараа нийтлэг, хэр зэрэг өөр болсон, тэр ялгаа нь бодит харилцаанд хэр хэн нөлөөлж байна вэ? Хоёрдугаарт, нэг хэлийг заадаг «Korean» болон «한국어 хангүго · 조선어 чо сөно» гэсэн нэрсийн харьцааг хэрхэн тайлбарлах вэ? Гуравдугаарт, албан ёсны хэл болох Өмн

---

2) 2018 оны есдүгээр сард Пён-яны Огнюгван зоогийн газарт болсон өдрийн зоогийн үеэр Умардын Эх орныг энх тайвнаа р нэгтгэх хорооны дарга Ри Сон Гвон Өмнөдийн бизнес эрхлэгчдэд “Хүйтэн гоймон хоолойгоор тань давж байна уу?” гэ ж хэлсэн хэмээн мэдээлэгдсэн. Энэ үгийг үнэхээр хэлсэн эсэхээс үл хамааран уг тохиолдлыг хоёр талын хэлний хэрэгл ээний ялгааны төлөөлөх жишээ болгон дурдах нь бий. https://www.donga.com/news/article/all/20181030/92643123/1

өдийн утга зохиолын хэл Умардын соёлын хэлний нийтлэг суурь болон хэм хэмжээний тэгш бус байдлыг хэрхэн үзэх вэ? Дөрөвдүгээрт, Өмнөд, Умардын хэл бичгийн дүрмийг нэгтгэхийн тулд юуг бодолцох ёстой вэ? Эдгээр асуудалд тулгуурлан, хоёр талын хэлний нэгдмэл байдлыг хангах эцсийн үр дүнг зорьж, нийтлэг солонгос хэл буюу Korean-ы бодит байдал, цаашдын чиглэл ийг өргөн хүрээнд, ерөнхий байр сууринаас авч үзэхийг хүсэж байна.

2. ‘Ондоошил’-ын бодит байдал: Юу нь, хэр зэрэг өөр, эсвэл адил байна вэ?

Өмнөд, Умардын хэлний ондоошил нь хэлний зөвхөн нэг нэгж, нэг түвшинд бий болсон, эсвэл явагдсан үзэгдэл биш. Энэ бол манай хэлний авиа зүй, бичлэг, үгийн сан, хэл зүй, хэлэхүй, хэлний хэрэглээ болон хэлэнд хандах хандлагад өөр өөр хурд, эрчмээр хуримтлагдсан нийлмэл өөрчлөлт юм. Иймээс хоёр талын хэлний ялгааг үгийн сан хэдэн хувиар зөрж байна, дүрмийн хэдэн заалт өөр байна гэсэн тоон хэмжүүрээр дангаар нь авч үзэж болохгүй. Өмнөд, Умардын хэл үндсэн хэл зүй, гол үгийн сангаараа өргөн хүрээнд нийтлэг боловч дээр дурдсан хэлний нэгж, хэрэглээний нөхцөлд нэлээд ялгаатай байгаа нь ялгаа нь жигд бус болохыг харуулдаг. Хоёр талын хэлний ялгаа ийнхүү жигд бус илэрч буйг бид бодит байдалд ажиглаг ддаг “ондоошил” гэж ойлгож байна.

Нэгдүгээрт, авиа зүйн салбарын ялгаа нь авианы тогтолцоог бүхэлд нь хамрахаасаа илүү зарим эгшиг, гийгүүлэгчийн авианы утга, ханз гаралтай үгийн эхний авиаг хэрхэн дуудах, аялга, я рианы хэмнэлд тод илэрнэ. Жишээлбэл, ‘어머니’ (өмөни), ‘걱정’ (көкчөн) зэрэг үгэнд орсон ‘ㅓ’ (ө) эгшгийг хоёр талын хэлэгчид бага зэрэг ялгаатай дууддаг. Мөн Өмнөдөд ханз гаралтай үгийн эхний ‘ㄹ’ (р/л) болон зарим ‘ㄴ’ (н)-ийг гээн ‘노동 (нодон) · 역사 (ёкса) · 여자 (ёжа) · 예절 (ежоль)’ гэж дууддаг бол Умардад эх дуудлагад ойр ‘로동 (родон) · 력사 (рёкса) · 녀자 (нёжа) · 례절 (режоль)’ хэлбэрийг зөв дуудлага болгон тогтоосон. Үүний дагуу Өмнөдийн ‘여행 (ёхэн) · 이론 (ирон) · 연락 (ёллак)’ нь Умардад ‘려행 (рёхэн) · 리론 (рирон) · 련락 (рёллак)’ гэж дуудагдана. Түүнчлэн Умардын соёлын хэлэнд ‘례절’ (режоль)-ийг [레절 (рэжоль)] гэж дуудах зэргээр ‘ㅖ’ (е)-г [ㅔ (э)]-д ойртуулан дуудах хандлага нь дуудлагын дүрэмд туссан байдаг. Эдгээр ялгаа нь хэл яриаг танил бус санагдуулж, сэтгэл зүйн хувьд зайтай мэт мэдрэмж төрүүлнэ.

Хоёрдугаарт, бичлэгт тулгуурласан хэл бичгийн дүрэмд үгийн эхний авианы дүрэм, нийлмэл үгийн заагт ㅅ (с) үсэг бичих дүрэм, үгийн хэлбэрийн бичлэг, үгийг салгаж бичих дүрмийн ялгаа тод харагдана. Өмнөдийн ‘양심 (яншим)/낙원 (нагвон)/노인 (ноин)’-ийг Умардад ‘량심 (рянши м)/락원 (рагвон)/로인 (роин)’ гэж бичнэ. Өмнөдөд ‘바닷가 (падатка)/콧소리 (котссори)/하룻밤 (харуппам)’ гэх мэтээр нийлмэл үгийн заагийн ㅅ (с)-ийг бичдэг бол Умардад зарчмын хувьд бичдэггүй учир ‘바다가 (падага)/코소리 (косори)/하루밤 (харубам)’ гэж бичдэг. Үйлийн нөхцөл залгахад ч Өмнөдийн ‘되어 (твэө) · 개어 (кэө)’ нь Умардад ‘되여 (твэё) · 개여 (кэё)’ гэсэн бичлэгтэй. Үгий

г салгаж бичихэд Өмнөдөд ‘할 수V있다 (халь сү∨итта)/먹고V있다 (мөкко∨итта)/세V명 (сэ∨мён)’ гэж бичдэг байхад Умардад ‘할수V있다 (хальсү∨итта)/먹고있다 (мөккоитта)/세명 (сэмён)’ гэж бичих зэргээр утгын нэг нэгж гэж үзсэн бүтцийг нийлүүлж бичих хүрээ нь өргөн байдаг. Хоёр талын хэл хэрэглэгчид ижил өгүүлбэрийг уншиж ойлгоход томоохон бэрхшээлгүй боловч өөр сдөө бичих, хайлт хийх, хэлний хөмрөг зэрэг хэлний өгөгдөл бүрдүүлэхэд эдгээр ялгаа шууд саад болдог.

Гуравдугаарт, үгийн сан бол ялгаа хамгийн ил тод, өргөн хүрээнд илэрдэг салбар юм. Нэг зүйлийг өөр өөр үгээр нэрлэсэн өөр хэлбэртэй, ижил утгатай үгсийн харьцаа, хэлбэр нь ижил боловч утга, хэрэглээний хүрээ нь өөр болсон ижил хэлбэртэй, өөр утгатай үгсийн харьцаа, зөвхөн нэг талд нь байдаг соёлын онцлогтой үгс зэрэг үүнд хамаарна. Эдгээрээс бодит таша а ойлголт төрүүлдэг нь танил бус үгнээс илүү танил мэт харагдах үг байдаг. Учир нь мэдэхгүй үг асуулт, тайлбар шаардуулдаг бол мэддэг гэж бодсон үг буруу дүгнэлтэд хүргэдэг. Умардад ‘일없다’ (ирөбта)-г “зүгээр”, “асуудалгүй” гэсэн утгаар хэрэглэх, эсвэл Өмнөдийн ‘전세’ (чөнсэ), ‘스펙’ (сыпэк), ‘서비스’ (собисы) нь зах зээлийн тодорхой тогтолцоо, ахуй соёлын ойлголтыг урьдчилан шаарддаг зэрэг жишээнээс зөвхөн тольд дүйцүүлэн тайлбарлах замаар утгыг бүрэн дамжуулахад бэрх байдгийг бид туршлагаараа мэднэ.

Өмнөдийн ‘주스 (жүсы)/프리킥 (пырикик)/투피스 (түписы)’ буюу жүүс, хөлбөмбөгийн чөлөөт цохилт, хоёр хэсэг хувцасны хослолд харгалзуулан Умардад ‘과일단물 (кваильданмуль)/벌차기 (польчаги)/나뉜옷 (нанвин-от)’ зэрэг солонгосчилсон үгийг хэрэглэх зөв хувилбар болгон санал болгожээ. Ахуй амьдрал, төр, нийгмийн тогтолцоотой холбоотой үгийн санд ч ‘휴대전화 (хюдэчөнхва)/손전화 (сончөнхва)’, ‘주차장 (жүчажан)/차마당 (чамадан)’, ’주민등록증 (жүминдыннокчын)/공민증 (конминчын)’ зэрэг өөр өөр нэр хэрэглэдэг. Өмнөдөд хуваагдсанаас хойш англи гаралтай харь үгийг олноор авсан бол Умардад харь үг болон ойлгоход хэцүү ханз гаралтай үгийг үүгуул үгээр сольж, эсвэл орос хэлээр дамжсан үгийг авч хэрэглэжээ. Ялангуяа мэдээллийн технологи, эрүүл мэнд, захиргааны салбарт харилцан дүйх үгийг нь мэдэхгүй бол зөвхөн хам сэдвээс утгыг таахад бэрх тохиолдол цөөнгүй.

Дөрөвдүгээрт, хэл зүйн ялгаа нь үгийн сан, хэлэхүйн хэвшлийн ялгаатай харьцуулахад харьцангуй хязгаарлагдмал. Нэр үгийн нөхцөл, үйл үгийн нөхцөлийн тогтолцоо, үгийн дараалал, хүндэтгэлийн хэлбэр, цаг, үйлдэгдэх болон үйлдүүлэх хэвийн хэл зүйн бүтцийн ихэнх нь хоёр талд нийтлэг. Гэхдээ Өмнөдийн хэл зүйд нэр үгийн нөхцөл, үйл үгийн нөхцөлийг ялгадаг бол Умардын хэл зүйд эдгээрийг ‘то’ (토) гэсэн ангилалд нэгтгэдэг тул хэл зүйг тайлбарлах тогтолцоонд зарим ялгаа бий. Бодит өгүүлбэрийн хувьд ч Умардын албан бичгийн найруулгад “문제를 해결할 데 대하여 토의하였다” (Асуудлыг шийдвэрлэх тухай хэлэлцэв) гэх мэт тодотгол гишүүн тэй бүтэц харьцангуй элбэг байхад Өмнөдөд “문제 해결 방안을 논의하였다” (Асуудлыг шийдвэрлэх арга замыг хэлэлцэв) гэх мэт нэр үгэнд төвлөрсөн илэрхийллийг илүүд үзэх нь бий.

Тавдугаарт, утгын салбарт ижил хэлбэр өөр өөр нийгмийн болон хам сэдвийн утгатай болох үзэгдэл ажиглагдана. Өмнөдөд ‘동무’ (тонмү) нь бага насны найз, хамт тоглодог хүүхдийг заа

даг бол Умардад хувьсгалын эгнээнд хамт буй хүнийг дотноор дуудах нийгмийн хандсан нэр болдог. '소행' (сохэн) нь Өмнөдөд ихэвчлэн '괘씸한 소행' (жигшүүрт үйлдэл) гэх мэтээр сөрөг утгатай хэрэглэгддэг бол Умардад '아름다운 소행' (сайхан үйл хэрэг) гэх мэт эерэг үйлдлийг чааж болно. '신사' (шинса) нь Өмнөдөд боловсролтой, боловсон эрэгтэй хүнийг хэлдэг байхад Умардын тольд хуучин нийгмийн ихэмсэг, бардам хүнийг заасан сөрөг утгыг нь онцлох нь бий. Ийнхүү нийгмийн утгын ялгаа хуримтлагдсанаар үгийн хам сэдвийн утгад ч ялгаа гардаг. Эцэст нь, хэлэхүй ба хэлний хэрэглээний ялгаа бодит харилцааны явцад зөрчил үүсгэх магадлал өндөр боловч үгийн сангийн ялгаатай харьцуулахад хангалттай судлагдаагүй байна. Хүнийг дуудах, нэрлэн заах, хүндэтгэн ярих, мэндлэх, танилцуулах, хүсэлт тавих, татгалзах, талархах, уучлал гуйх, хошигнох, дуугүй байх арга хэлбэрт тухайн нийгмийн хүмүүсийн харилцааны дэг, сэтгэл хөдлөлөө илэрхийлэх хэм хэмжээ шингэсэн байдаг. Хэлсэн зүйлийн мэдээллийн агуулга зөв байсан ч харилцааны утгыг зөрүүлж ойлговол ойлголцол бүтэлгүйтэж болно.

Жишээлбэл, Өмнөдөд өдөр тутам хэрэглэдэг '선생님' (сонсэнним), 'OO 씨' (ши) болон албан тушаалаар нь дуудах хэлбэрүүд, Умардын '동무' (тонму), '동지' (тонжи) болон хариуцсан ажил үүргээр нь дуудах хэлбэрүүд нь хэрэглээний хүрээ, харилцаанд илэрхийлэх далд утгаараа ялгаатай. Иймээс үгийн утгыг нь мэдсэн ч дотно эсвэл зайтай хандсаныг өөр өөрөөр тайлбарлаж болно. Хүсэлт тавихад ч '이것을 해주십시오' (Үүнийг хийж өгнө үү) гэх мэт шууд илэрхийлэл ийг нэг нийгэмд тодорхой, хариуцлагатай яриа гэж хүлээн авч болох боловч өөр нөхцөлд '해주실 수 있습니까' (Хийж өгч болох уу?) гэх мэт зөөлрүүлсэн хэллэгтэй харьцуулан тушаасан, дарамталсан мэт ойлгож болно. Татгалзахдаа '안 됩니다' (Болохгүй) гэж боломжгүйг нь тодорхой хэлэх, '조금 어려울 것 같습니다' (Арай хүндрэлтэй байх шиг байна) гэж сөрөг утгыг тойруулан илэрхийлэх хоёр арга ч үнэнч шулуун байдал, эелдэг ёсны тухай өөр өөр үнэлэлт төрүүлдэг.

Дээр дурдсанчлан, Өмнөд, Умардын хэл нь хэлний тогтолцооны түвшинд "харилцан ойлголцох боломжгүй хоёр хэл" биш. Харин түүхийн хувьд нэг хэлт хамт олны дотор хоёр хэм хэмжээ, хоёр албан ёсны хэлний орчин удаан хугацаанд зэрэгцэн оршиж, хэлний нэгж бүрд ялгаа хуримтлагдсан байдал гэж үзэх нь зохистой. Энэ утгаараа бүтцийн нийтлэг шинж өндөр байгаа нь нэгдмэл байдлыг хангах боломжийг баталдаг ч тэр боломж нь харилцан саадгүй ойлголцох баталгаа үргэлж болдоггүй. "Ондоошил" хэмээн нэрлэж буй зүйл нь улс тус бүрд ал бажсан утга зохиолын хэлний түвшинд илэрдэг бодит хэрэглээний ялгааг тодорхойлж байна. Гэвч түүхэн нийтлэг хэлний тогтолцоо буюу ланг(langue) нь нэг учраас «бид ижил хэлээр ярьдаг» гэсэн итгэл нь тайлбарлах, лавлан нягтлах шаардлагыг дутуу үнэлэхэд хүргэж, харин ч харилцан ойлголцоход саад болж байна.Харилцан ойлголцлын энэ саад нь ондоошлын гол асуудал юм.

3. Нийтлэг хэлний асуудал: Хангүго юу, чосөно юу?

Өмнөд, Умардын хэлний нэгдмэл байдлыг хэлэлцэхийн тулд эхлээд нийтлэг хэл (共通語, common language) болон албан ёсны хэл (公用語, official language)-ийг ялгаж ойлгох хэрэгтэй. Бидний хувьд нийтлэг хэл гэдэг нь Өмнөд, Умардын хэлний хамт олон буюу хэл хэрэглэгчди йн соёл, түүхийн хувьд хамтран эзэмшдэг, харилцан ойлголцох боломжтой үндэстний хэл б олох хангүго, чосөно юм.[3] Харин албан ёсны хэл гэдэг нь төрийн байгууллага, хууль, захирг аа, боловсрол, нийтийн хэвлэл мэдээлэлд албан ёсоор хэрэглэгддэг, институцчилсэн эсвэл бичгээр журамлан тогтоосон хэлийг хэлнэ. Өмнөд, Умардын иргэдийн хэрэглэдэг хэл гарал, бүтцийн үүднээс нэг хэлэнд хамаарах боловч хуваагдсанаас хойш хоёр улсын албан ёсны хэ лний тогтолцоо, хэлний бодлогын хүрээнд Өмнөдөд “утга зохиолын хэл” (표준어), Умардад “с оёлын хэл” (문화어) гэсэн ялгаатай хэлийг албан ёсны хэлний хэрэглээний жишиг болгон мөр дөж байна. Иймд “хэл нэг” гэж тунхаглаад энэ ялгарлыг арилгаж чадахгүй. Гэхдээ хоёр улс ын тогтолцоо оршин буй бодит байдалд захирагдан, нийтлэг хэлний өв болон харилцан ойлг олцох өндөр боломжийг нь үгүйсгэж ч болохгүй.

Үүнтэй уялдан хангүго, чосөно гэсэн нэрийн асуудал аяндаа тавигдана. Чөлөөлөлтийн дара ах эхэн үе хүртэл Өмнөдөд ч ‘조선어’ (чосөно), ‘조선말’ (чосөнъмаль) гэсэн нэр өргөн хэрэглэгд эж байсан боловч засгийн газар байгуулагдсаны дараа ‘한국어’ (хангүго), ‘한국말’ (хангүгмаль) улсын хэмжээний нэршил болон тогтжээ. Умардад ‘조선어’ (чосөно), ‘조선말’ (чосөнъмаль)-ыг албан ёсны нэр болгон тогтоосон. Гэвч ‘조선어’ (чосөно)-г зөвхөн Умардын хэлтэй адилтгах н ь оновчтой биш. Хятадын солонгос үндэстний нийгэм, Японд суугаа солонгосчуудын зарим бүлэг ч үүнийг үндэстнийхээ хэлний нэр болгон хэрэглэдэг. Иймээс ‘한국어’ (хангүго) гэсэн нэ р олон улсад илүү өргөн тархсан ч ‘조선어’ (чосөно) нэрийн түүхэн үндэс, өнөөдөр түүнийг хэ рэглэж буй бүлэг хүмүүсийг үгүйсгэж болохгүй. Энэ асуудал түүхэн нийтлэг шинж ба улс төр ийн хуваагдлыг хураангуйлан харуулдаг.

Солонгос хэлний толиудын тайлбараас ч эдгээр нэрд хандах өнцгийн ялгаа харагдана. Зар им толь ‘조선어’ (чосөно)-г түүхэн нэр, эсвэл Умард болон хилийн чанад дахь солонгосчууды н хэлний нэр хэмээн ялган тайлбарладаг бол Хангыл судлалын холбооны толь бүтээх улам жлалд ‘한국어’ (хангүго)-тай ижил утгат харьцаагаар тусгадаг. Эхнийх нь хуваагдсанаас хой ших хэрэглээний хүрээг, дараагийнх нь түүх, гарал үүслийн хувьд нэг болохыг онцолж байн а. Ланг(langue)-т тулгуурласан хэлний тогтолцоогоор авч үзвэл хоёр нэр нэг хэлийг заана. Харин улсын албан ёсны хэлний тогтолцоо, нийгмийн хэрэглээний хүрээгээр авч үзвэл өөр өөр хэм хэмжээт хэл, улс тус бүрийн утга зохиолын хэлний хоёр хувилбар (national standard varieties) юм. Олон улсад хэрэглэдэг Korean гэдэг нэр хоёр нэршлийг хамруулж болох ч зөвх өн англи нэр хэрэглэснээр зөрчил арилчихгүй. Нэгдмэл байдлыг хангах зорилго нь аль нэг н

3) Өмнөд, Умардын хэл хэрэглэгчдээс гадна хилийн чанад дахь солонгос диаспорагийн хэлний хувилбаруудыг ч нийтлэг х элэнд хамруулан үзэж болно. Америк, Британи, Австрали, Сингапурын англи хэл нь тус тусын хувилбартай боловч нийт лэг англи хэлийг хуваалцдагтай адил юм.

эрийг ялагч болгон тогтооход бус, нэр тус бүрийн түүх, түүнийг хэрэглэдэг бүлэг хүмүүсийг хүлээн зөвшөөрөхөд оршино.

4. Албан ёсны хэл болох стандарт хэл(утга зохиолын хэл) ба с оёлын хэл : нийтлэг шинж ба тэгш бус тал

Өмнөдийн стандарт хэл (표준어, пёжүно), Умардын соёлын хэл (문화어, мүнхвао) нь улс тус бүр дээ албан харилцаанд хэрэглэхээр дүрэм, журмаар баталгаажуулсан, нийтээр дагаж мөрдө х хэлний жишиг юм. Өмнөдийн стандарт хэл нь зарчмын хувьд «боловсролтой хүмүүсийн өр гөн хэрэглэдэг орчин цагийн Сөүлийн хэл»-г жишиг болгодог бол Умардын соёлын хэлийг П ён-яны хэлэнд тулгуурлан, хувьсгалч шинж, ард түмний шинжийг тусгахаар боловсруулсан, нийтээр дагаж мөрдөх хэлний жишиг хэмээн тайлбарлаж иржээ. Хоёулаа нутгийн аялгуунд тулгуурлан бүс нутгийн хүрээнээс давсан харилцааны жишиг тогтоож, сургуулийн боловср ол, хэвлэл мэдээлэл, хэвлэн нийтлэх ажил, захиргаагаар дамжин түгсэн гэдгээрээ үүргийн х увьд нийтлэг. Түүнчлэн 1933 оны “Хангыл үсгийн зөв бичих дүрмийн нэгдсэн хувилбар” боло н орчин үеийн үндэстний хэлний хэм хэмжээг тогтоох ажлын ололтыг хоёулаа түүхэн чухал сууриа болгодог. Үүнийг цаашид Өмнөд, Умардын хэл бичгийн дүрмийг нэгтгэх түүхэн үндэ слэл болгон ашиглаж болох учир онцгой ач холбогдолтой.

Тиймээс стандарт хэл ба соёлын хэлийг тус тус Сөүл, Пён-яны аялгууны жам ёсны үргэлжл эл төдий гэж ойлгож болохгүй. Өмнөдийн стандарт хэлэнд Сөүлд бодитоор хэрэглэгддэг хэ лний бүх хэлбэр багтдаггүй. Умардын соёлын хэл ч Пён-яны уугуул хэлийг тэр чигээр нь авс ан зүйл биш. Хоёулаа төрөөс тодорхой нутгийн хэлэнд тулгуурлан хэлбэрүүдийг сонгож, зас варлан, хэлний эрх бүхий хэм хэмжээ болгож, бичгээр журамласан үр дүн юм. Иймээс аль н эг талын хэлийг «манай жинхэнэ хэл» хэмээн туйлын зөвд тооцож, нөгөө талын хэлний дүрэ м, жишгийг нутгийн аялгууны гажуудал эсвэл буруу тогтоосон дүрэм гэж үзэх нь Өмнөдийн стандарт хэл, Умардын соёлын хэл бүрэлдэн тогтсон үйл явцын утга учрыг үл анзаарсан хэр эг юм.

Хоёр албан ёсны хэлний ялгаа нь хэлний дүрэм, жишиг тогтоох зорилго, чиглэлд ч илэрдэг. Өмнөдөд хэлний бодит хэрэглээний өөрчлөлтийг тусгах, стандарт хэлний зэрэгцээ хувилба руудыг зөвшөөрөх, харь үг хүлээн авах зэргээр хэлний дүрэм, жишгийг бодит хэрэглээтэй н ь тогтмол нийцүүлж ирсэн. Умардад төрөөс зохистой гэж үзсэн хэлбэрийг сонгон түгээх ши нж нь илүү хүчтэй байсан бөгөөд үг хэллэгийг эх хэлний үгээр сольж оноохын зэрэгцээ үгий н санг үзэл суртлын үүднээс хянахыг ч чухалчилдаг. Сүүлийн үед Өмнөд маягийн яриаг няца ан хориглох бодлого эрчимжиж, соёлын хэлийг албан харилцааны жишиг хэл төдийгүй туха йн тогтолцооны хэлний маргаангүй ноёрхлыг баталгаажуулах бэлгэдэл хэмээн тодорхойлж байна. Иймээс хоёр талын хэлний дүрэм, жишгийг хэлбэрийн хувьд шууд дүйцэх тэгш хосло

л гэж үзэхэд бэрх. Өмнөдийн хангуго, Умардын чосөнъо нь түүхэн нийтлэг хэлний тогтолцоо нд тулгуурладаг боловч хуваагдсанаас хойш өөр өөр хэлний бодлого, дүрэм, жишиг тогтоох үйл явцыг туулснаар стандарт хэл (표준어, пёжүно), соёлын хэл (문화어, мунхвао) хэмээх улс т ус бүрийн албан ёсны жишиг болсон хэлний хоёр хувилбар болон тогтжээ. Ийнхүү “нийтлэг хэлний тогтолцоо, хоёр улсын хэлний дүрэм жишиг, хэлний бодит хэрэглээний олон хэлбэр” гэсэн түвшин хоорондын харьцаа үүссэнээр хэлний бодит нөхцөл дэх хоёр талын тэгш бус б айдал улам гүнзгийрчээ.

Хоёр талын хэлний тэгш бус байдал нь хэлний нөөц тархах, хэрэглэгдэх үйл явцаас ч харагд ана. Өмнөдийн нийтийн соёл, цахим агуулга дэлхий дахинд түгэхийн хэрээр түүний үг хэллэ гтэй танилцах боломж өссөн. Солонгосын соёлын давалгаа, солонгос соёлын нөлөөгөөр Ха нгүго-ны олон янзын илэрхийлэл өргөн тархаж байна. Зарим улс бүр өөрийн хэлний тольд с олонгос үгийг харь үг болгон оруулж байна.[4] Харин Умардын хэлний судалгааны хэрэглэгдэ хүүнтэй танилцах боломж хязгаарлагдмал байна. Үүнээс шалтгаалан нөгөө талын хэлний дү рэм, жишгийг сурах ачаалал хоёр талд ижил биш. Умардаас гарч ирсэн иргэд Өмнөдийн ал бан ёсны хэлний жишиг болсон стандарт хэл болон солонгос хэлэнд нэгэнт шингэсэн харь үгсийг богино хугацаанд эзэмших шаардлагатай болдог. Харин Өмнөдийн сурагчид болон нийт хэл хэрэглэгчид Чосөно маягийн хэллэгийг ойлгохын тулд тусгайлан дадлага хийж, хүч ин чармайлт гаргадаггүй. Гагцхүү хоёр талын хэлний ялгааг таньж мэдэх, ойлгох зорилгоор сургалтын хүрээнд суралцаж, дадлага хийх төдий байдаг.

Өмнөд, Умардын хэлний нэгдсэн дүрэм, жишгийг бий болгохын тулд эдгээр нийтлэг шинж, т эгш бус байдлыг хамтад нь харгалзах ёстой. Нэгдсэн стандарт хэлийг эхэлж сонгон тогтоох оос илүүтэй Өмнөдийн стандарт хэл, Умардын соёлын хэлний зөвшөөрөгдсөн хэлбэрүүдийг холбох нийтлэг тогтолцоо бүрдүүлэх нь бодитой. Хамтран толь зохиох, нэр томьёоны өгөгдл ийн сан байгуулах явцад Өмнөд, Умардын хэлбэрийг зэрэгцүүлэн үзүүлж, хэрэглэгдэх бүс ну таг, салбар, цаг үе, хэрэглээний хэв маяг буюу регистр(使用域, register)[5] зэргийг тэмдэглэх х эрэгтэй. Мөн үнэн зөв, тодорхой байх нь чухал нийтийн харилцааны хэлэнд хоёр тал харилц ан ойлгоход хялбар үг хэллэг, зэрэгцүүлэн бичих аргыг урьтал болгох ёстой. Харин уран зох иол, өдөр тутмын хэл, нутгийн хэлний хүрээнд хэлний хувилбаруудын олон янз байдлыг ара й өргөн хүрээнд хүлээн зөвшөөрөх хэрэгтэй. Энэ үүднээс хэлний нэгдмэл байдлыг хангах нь харилцан ойлголцох нийтлэг суурийг өргөжүүлэх ажил бөгөөд үүнийг хэлийг нэг хэвд оруул ахтай ялгаж ойлгох шаардлагатай гэсэн байр суурийг хэлний бодлогын түвшинд хуваалцах хэрэгтэй.

---

4) 2026 оны байдлаар «Оксфордын англи хэлний толь» (Oxford English Dictionary, OED)-д солонгос гаралтай 64 орчим үг л атин үсгээр бичигдэн бүртгэгдсэн байна. Тухайлбал, ramyeon, haenyeo, seonbae, bingsu, jjimjilbang, ajumma, officetel зэр эг үг бий. Гэхдээ эдгээр үг тольд орсон нь англи хэлээрх бичвэрүүдэд тогтмол хэрэглэгдэж, англи хэлэнд харь үг болон нэвтэрснийг илэрхийлэхээс биш, тухайн бичлэгийг зөв бичих жишиг хэлбэр болгон тогтоосон гэсэн үг биш юм.

5) Ярьж, бичиж буй нөхцөл, харилцагч, зорилго, харилцах арга хэлбэрээс хамааран сонгон хэрэглэдэг хэлний хувилбар ю м. Нэг хүн ч нөхцөлөөсөө шалтгаалан өөр өөр үг хэллэг, хэл зүйн хэлбэр, ярих хэв маяг хэрэглэдэг.

5. Хэл бичгийн дүрмийг нэгтгэх асуудал

5.1. Зөв бичих дүрэм ба цахим эрин үеийн хэрэгцээ

Өмнөд, Умардын зөв бичих дүрэм нь хангыл хэмээх нэг бичгийн тогтолцоо болон бүтээврий н хэлбэрийг хадгалан бичих зарчимд тулгуурладаг. Өөр өөр бичиг хэрэглэдэг хэлний жишээ тэй харьцуулахад хэлний дүрэм, жишгийг харилцан нийцүүлж, тохиролцоход шаардагдах за рдал нь харьцангуй бага. Гэвч өмнө дурдсанчлан хоёр талд үгийн эхний авианы дүрэм, нийл мэл үгийн заагт ㅅ (с) үсэг бичих дүрэм, зарим бүтээвэр болон үйлийн нөхцөлийн бичлэг, үги йг салгаж бичих дүрэм, цэг тэмдгийн хэрэглээний ялгаа хуримтлагдсан байна. Өмнөдөд үги йн эхний авианы дүрмийн дагуу '여행 (ёхэн)/여자 (ёжа)/역사 (ёкса)/노동 (нодон)' гэж бичдэг бол Умардад '려행 (рёхэн)/녀자 (нёжа)/력사 (рёкса)/로동 (родон)' гэх мэтээр үгийн эхний 'ㄹ' (р/л), 'ㄴ' (н)-ийг хадгалж бичдэг. Нийлмэл үгийн заагийн ㅅ (с)-ийг мөн Өмнөдийн дүрмийн дагуу тод орхой нөхцөлд бичдэг бол Умардын дүрэмд бичихийг зөвшөөрсөн хүрээ нь хязгаарлагдмал. Үгийг салгаж бичих тухайд Умардад нэг ойлголт эсвэл нэг нийлмэл нэгж гэж үзсэн хэсгүүди йг харьцангуй өргөн хүрээнд нийлүүлэн бичих хандлагатай тул Өмнөдийн уншигчдад нэлээд урт нийлсэн хэлбэр мэт санагдах нь бий.

Эдгээр ялгаа нь мэдээллийн, хиймэл оюуны эрин үеийн цахим орчинд бүр ч том саад болдог. '노동' (нодон), '로동' (родон)-ийг зөвхөн тус тусдаа тэмдэгтийн дараалал гэж боловсруулбал хайлты н үр дүн нь тусдаа гарна. Мөн үгийг салгаж бичсэн зааг нь ялгаатай өгүүлбэрүүдийг автоматаар харгалзуулан зэрэгцүүлэх, бүтээврээр задлан шинжлэхэд нарийвчлал нь буурна. Иймээс хэлний дүрэм, жишгийг нэгтгэх ажлыг нэг бичлэг сонгон тогтоохоос өмнө ялгаатай бичлэгүүдийг хооро нд нь хөрвүүлж, ижил ойлголттой холбох хайлтын толь, зэрэгцүүлсэн хэлний хөмрөг болон задл ан шинжилгээний нөөц бүрдүүлэх хүрээнд ч өргөжүүлэн авч үзэх шаардлагатай.

Өмнөд, Умардын хэл бичгийн дүрмийг зохицуулах, нэгтгэх ажлын дарааллыг харилцан ойлг олцлын хэрэгцээ хэр тулгамдсан, хэрэглэгчид хүлээн авах боломжтой эсэх, техникийн хувь д тохиролцож болох эсэхийг баримжаа болгон хэлэлцэх шаардлагатай. Тэмдэгтийн код, эрэ мбэлэх арга, тоо, нэгж, цэг тэмдэг, хайлтын хөрвүүлэлтийн дүрэм зэрэг харьцангуй хялбар т охиролцох зүйлсийг эхэлж цэгцэлж болно. Үгийн эхний авианы дүрэм, нийлмэл үгийн заагт ㅅ (с) үсэг бичих дүрэм шиг удаан хугацааны хэлний дадал, хэлний өөрийн онцлогийн тухай ухамсартай холбогдсон зүйлсийн хувьд аль нэг талын хэлбэрийг шууд халахаас илүү хэд хэ дэн бичлэгийг зөвшөөрч, харилцан лавлагаа өгөн, урт хугацаанд хэлэлцэх нь тохиролцоонд хүрэхэд дөхөм. 《Солонгос үндэстний хэлний их тайлбар толь》-ийг бүтээх явцад нийтлэг тал ыг нь эхэлж тусгаж, ялгаатай зүйлсийг харилцан хэлэлцэж нийцүүлж ирсэн арга барилыг хэ лний дүрэм, жишгийг үе шаттайгаар нэгтгэх ажлын бодит туршлага хэмээн өндрөөр үнэлж болно.

5.2. Харь үг ба солонгосчлох нь

Харь үг нь хоёр талын олон улсын харилцаа, ахуй соёлын ялгааг хамгийн хурдан илэрхийлд эг салбар юм. Өмнөдөд «Харь үгийг бичих дүрэм»-ийн дагуу хэлэнд орсон харь үг, гадаадын хүн, газар орны нэрийг бичдэг бол Умардад эдгээрийг голчлон «Гадаад үгийг бичих дүрэм»-ээр зохицуулдаг. Тус дүрэм нь ялангуяа гадаад хүний нэр, газар орны нэр зэрэг оноосон нэр ийг эх хэлний дуудлагад ойр бичихэд анхаардаг. Чосөнъ хэлэнд нэгэнт орж хэвшсэн харь үг энд «Гадаад үгийг бичих дүрэм»-ийг зарчмын хувьд хэрэглэхгүй гэдгээрээ ч Өмнөдөөс ялга атай.

Хамгийн тод ялгаа нь хамжих болон шүргэх гийгүүлэгчийг бичих аргад илэрдэг. Өмнөдөд харь үгийн хамжих гийгүүлэгчийг тэмдэглэхдээ чанга гийгүүлэгчийн үсэг хэрэглэхгүй байх зарчим баримталдаг бол Умардад тухайн авианы эх хэлэн дэх дуудлагын чангаралтыг тусган, чанга гийгүүлэгчийн үсгийг харьцангуй өргөн хэрэглэж ирсэн. ‘버스 (пөсы)/뻐스 (ппөсы), 보트 (поты)/뽀트 (ппоты), 리어카 (риөка)/리야까 (риякка), 몽타주 (монтажү)/몽따쥬 (монттажю)’ зэрэг нь үүний жишээ юм. ‘컴퓨터 (көмпюто)/콤퓨터 (компюто), 텔레비전 (тэллэбижөн)/텔레비죤 (тэллэбижён), 디자인 (дижаин)/데자인 (дэжаин)’ зэрэг үгийн эгшгийг хангыл үсгээр тэмдэглэх арга ч ялгаатай. Гэхдээ Өмнөд, Умард аль аль нь одоо хэрэглэж буй хангыл үсгийг ашиглан, тухайн үгийн эх хэлэн дэх дуудлагыг өөрийн хэлний авианы тогтолцоонд нийцүүлэн буулгах үндсэн зарчмыг баримталж байна.

Харь үгийн бичлэгийг үгийн сангийн үүднээс авч үзвэл Өмнөд нь англи хэл голлосон олон улсын үгс, барааны нэр, нийтийн соёл, мэдээллийн технологийн нөлөөг өргөнөөр хүлээн авсан. Умард ч орос, англи зэрэг олон хэлнээс үг авч хэрэглэсэн боловч бие даасан үндэстний хэл бүрдүүлэх болон үг хэллэгийг эх хэлний үгээр сольж оноох бодлогын дагуу уугуул үг, эсвэл утгыг нь тайлбарласан нэр томьёог идэвхтэй бүтээж ирсэн. Харь үг нэвтэрсэн цаг үе, дамжин орсон зам нь өөр байсан учир нэг зүйлийг нэг талд англи гаралтай харь үгээр, нөгөө талд орос гаралтай харь үг, эсвэл орчуулсан үгээр нэрлэх тохиолдол бий болсон.

Тиймээс “Өмнөдөд харь үг, Умардад эх хэлний үгээр сольсон үг хэрэглэдэг» гэж хоёр туйл болгон үзэх нь[6] бодит байдлыг хялбарчилсан хэрэг юм. Умардын шинжлэх ухаан, технологи, спортын үгэнд ч харь хэлний бүрэлдэхүүн бий. Өмнөдөд ч эх хэлний үгээр сольж оноосон үг хэрэглэдэг. Шинэ технологийн нэр томьёог зөвхөн аль нэг талын одоогийн дүрэм жишгээр шийдэхэд бэрх. Иймд харь үгийг нэг мөр болгохдоо хэлний цэвэр байдлаас илүү олон улсад таньж ойлгох боломж, солонгос хэл буюу Korean-ы тогтолцоонд нийцэх байдал, ойлголтын

---

6) Зайрмагийг Умардад ‘얼음보숭이’ (орымбосүни) гэж нэрлэдэг гэх ойлголт нь Умардын соёлын хэлний тухай түгээмэл таа ойлголтын нэг. Өмнөдийн ‘아이스크림’ (аисыкырим)-д дүйх Умардын үг нь ‘에스키모’ (эсыкимо) юм. Хоёр тал хоёулаа харь үг хэрэглэж байна. ‘얼음보숭이’ (орымбосүни) нь 1981 онд Умардын «Орчин цагийн солонгос (Чосөнъ) хэлний толь»-ийн хоёрдугаар хэвлэлд орсон боловч бодит хэрэглээнд хэвшээгүй бөгөөд 1992 оны «Солонгос (Чосөнъ) хэлний их тайлбар толь»-ийн толгой үгээс хасагджээ. Харин ‘에스키모’ (эсыкимо) нь орос хэлний эскимо гэдэг үгийн нөлөөгөөр бий болсон, анх шоколадан бүрхүүлтэй иштэй зайрмагийг зааж байгаад ерөнхийдөө зайрмагийг нэрлэх утгаар өргөжиж, 2006 оны «Солонгос (Чосөнъ) хэлний их тайлбар толь»-д орсон үг юм.

нарийвчлал, бодит хэрэглээнд тохиромжтой эсэхийг харгалзах ёстой.
Мэргэжлийн нэр томьёог нэгтгэхдээ аль салбарыг тэргүүнд авч үзэхийг ялган тогтоох хэрэг тэй. Анагаах ухаан, эм бэлдмэл, гамшиг, харилцаа холбоо, үйлдвэрлэлийн аюулгүй байдлын салбарт нэр томьёог буруу ойлгох нь амь насанд аюул учруулж, хүний эрхийг зөрчихөд хүрг эж болзошгүй. Иймээс эдгээр салбарт ойлголтын дүйцлийг тогтоох, ижил утгат нэр томьёог бүртгэн зохицуулах нь юу юунаас илүү яаралтай ажил юм. Хамтын нэр томьёоны санд бичлэ гт туссан дуудлагын ялгаанаас гадна ойлголтын хамрах хүрээ, гарал хэл, хэрэглэгдэх салба р, жишээ өгүүлбэрийг хамтад нь бүртгэх ёстой. Аль нэг талын үгийг шууд хасахын оронд үнд сэн хувилбар, хэрэглэхийг зөвшөөрсөн хувилбар, утгыг нь тайлбарлан илэрхийлсэн хувилба рыг ялгаж, аль ч хувилбараар нь хайж олох боломж бүрдүүлэх нь бодитой. Урт хугацаанд Өмнөд, Умардын болон хилийн чанад дахь солонгос судлаачид шинэ үгийг хамтран цуглуулж, хянан хэлэлцэх нээлттэй нэр томьёоны өгөгдлийн сан байгуулах шаардлагатай.

5.3. Латин үсгээр галиглах нь ба олон улсад таньж ойлгох боломж

Латин үсгээр галиглах нь дотоодод унших асуудлаас илүү олон улсын тээвэр, газрын зура г, шуудан, эрдэм шинжилгээний мэдээлэл, цахим хайлтад нөлөөлдөг. Өмнөдөд 2000 онд ни йтэд зарласан «Солонгос хэлийг латин үсгээр галиглах дүрэм»-ийг нийтийн хэрэглээний би члэгийн жишиг болгож байна. Харин Умардын «Чосөнъ хэлийг латин үсгээр галиглах дүрэм » нь Маккюн–Райшауэрын (McCune–Reischauer) тогтолцоонд тулгуурласан галиглах уламжл ал,[7] Умардын соёлын хэлний дуудлага, авианы хувирал, Умардын газар орны болон хүний н эрийг бичих дадлыг тусган галигийн тогтолцоогоо бүрдүүлж иржээ. Үүнээс шалтгаалан хоё р талд Geumgangsan/Kŭmgangsan, Pyeongyang/Pyongyang, Amnokgang/Amrokgang, Jeollado/ Jŏllado гэх мэт өөр өөр зарчимтай бичлэг хэрэглэгддэг. Хүний нэрийн бичлэг нь хувь хүний с онголт, гэр бүлийн уламжлал, паспорт, эрдэм шинжилгээний үйл ажиллагаан дахь нэрийн за лгамж хэрэглээтэй холбоотой тул нэг дүрмийг бүгдэд ижил хэрэглэхэд бүр ч бэрх.
Латин үсгээр галиглах асуудал зөвхөн авианы мэдээллийг үнэн зөв тэмдэглэхээр хязгаарла гдахгүй. Олон улсад хэвшсэн газар орны болон байгууллагын нэр, одоогийн өгөгдлийн санта й залгамж холбоотой байх шаардлага, хэрэглэгчид дөхөм байх байдал, эрдэм шинжилгээни й галигийн нарийвчлал хоорондоо зөрчилдөж болно. Иймээс нэг галигийг шууд эцэслэн тог тоохын оронд зориулалтаар нь ялгасан зарчим хэрэгтэй. Олон улсын тээвэр, газрын зураг, ш ууданд хайлтаар харилцан олдох боломж, хэвшсэн хэрэглээг, эрдэм шинжилгээний галигт э х хэлбэрийг сэргээн тогтоох боломжийг, хүний нэрд тухайн хүний тогтмол хэрэглэж ирсэн б ичлэгийг урьтал болгох ёстой.

---

7) Энэ тогтолцоонд тулгуурлан өөрчилсөн галигийг Өмнөдөд ч хэрэглэж байгаад 2000 онд албан ёсны латин галигийг од оогийн «Солонгос хэлийг латин үсгээр галиглах дүрэм»-ээр сольж, батлан тогтоосон.

Цахим эрин үед практик ажлын хувьд Өмнөд, Умардын галиг, олон улсад хэвшсэн бичлэгийг холбосон харьцуулсан өгөгдлийн санг эхэлж байгуулах хэрэгтэй. Нэг газар, эсвэл хүний нэр ийн бүх бичлэгийн хувилбарыг хайлтын үг болгон зөвшөөрч, тус бүрийг нь тухайн газар, эсв эл хүнийг ялган таних нэг стандарт таних кодтой холбовол дүрмийн ялгаанаас болж мэдээл эл тасалдахыг багасгаж болно. Латин галигийн асуудалд олон улсын байгууллага, гадаадын судлаачид зуучлан оролцох боломж өргөн байдаг учир Өмнөд, Умардын хамтарсан судалга аг сэргээхэд хамгийн ойрын, бодит хэрэгцээтэй сэдэв ч болж болох юм.

6. Дүгнэлт: Ялгааг даван туулж, Өмнөд, Умардын хэлний нэгдм эл байдлыг хангах тухай санал

Өмнөд, Умардын хэл нь хуваагдсанаас хойш өөр өөр төрийн тогтолцоо, хэлний бодлого, бол овсрол, хэвлэл мэдээллийн орчинд тус тусдаа өөрчлөгдөж ирсэн. Гэвч ийнхүү ялгаатай болс он нь хоёр талын хэл бүтцийн хувьд холбоогоо тасалсан гэсэн үг биш. Учир нь Өмнөд, Умард ын хэл бичгийн тогтолцоо, үндсэн хэл зүй, суурь үгийн сан, түүхэн уламжлалаараа нийтлэг ю м. Иймээс Өмнөд, Умардын хэлний нэгдмэл байдлыг хангах хэлний бодлогын чиглэлийг тодо рхойлохдоо хоёр талын хэлийг бүрэн ижил, эсвэл аль хэдийн тусдаа хэл болсон гэж урьдчил ан үзэж болохгүй. Харилцан ойлголцох боломж өндөр боловч салбар бүрд харилцааны саад бэрхшээл мөн зэрэгцэн оршиж буй бодит байдлыг үндэс болгох ёстой.

Мөн хоёр талын хэлний харьцаанд төр, нийгмийн тогтолцоо болон соёлын тэгш бус байдал бий. Өмнөд нь даяаршил, цахим хэвлэл мэдээллийн орчинд англи зэрэг харь хэлний бүрэлд эхүүнийг хурдтай авч хэрэглэсэн бол Умард нь төрөөс удирдан хэрэгжүүлдэг хэлний бодло гоор хэл цэвэршүүлэх үзэлд (linguistic purism)[8] тулгуурлан уугуул үгийг эрхэмлэх чиглэл бар имталж, соёлын хэлний дүрэм, жишгийг тууштай мөрдүүлж ирсэн. Өмнөдийн утга зохиолын хэл, Умардын соёлын хэл хоёулаа орчин үеийн үндэстний хэлний дүрэм, жишгийг тогтоож и рсэн түүхээс эхтэй боловч өөр өөр улс төрийн төв, хэлний хэм хэмжээг тогтоох эрх мэдэлд тулгуурлан бүрэлджээ. Энэ үүднээс нийтлэг шинжийг сэргээхийн зэрэгцээ Өмнөд, Умардын хэлний ялгаа түүхэн явцад хэрхэн бүрэлдсэн болон өнөөгийн бодит байдлыг хүлээн зөвшөө рч, харилцаанд шууд саад учруулдаг ялгааг танин мэдсэний үндсэн дээр хэлний нэгдмэл ба йдлыг хангах ажлыг үе шаттай хэрэгжүүлэх шаардлагатай.

Тиймээс Өмнөд, Умардын хэлний нэгдмэл байдлыг хангах бодлогын зорилгыг “бүрэн боловс руулсан нэг хэм хэмжээ”-г богино хугацаанд батлан тогтоохоос “харилцан ойлголцлыг тогтв ортой хангах тогтолцоо” бүрдүүлэх чиглэлд шилжүүлэх ёстой. Аль нэг талын хэлний хэм хэм

8) Харь хэлний элемент болон тогтсон дүрэм, жишигт нийцэхгүй хэлбэрийг хасаж, хэлний өөрийн онцлог, цэвэр байдлыг хадгалахын тулд үг хэллэгийг засаж боловсруулан, харь хэлний элементийг уугуул үгээр солихыг зорьдог хэлний бодл огын ойлголт юм. Үүнийг «хэл цэвэршүүлэх үзэл» гэж ч нэрлэдэг. Харин зарим талаар шүүмжлэлтэй хандсан байр суур инаас «хэлний цэвэр ариун байдлыг эрхэмлэх үзэл» гэсэн нэршил мөн хэрэглэгддэг.

жээг нэгдсэн хэлний жишиг болгон сонгож, нөгөө талд мөрдүүлэх арга нь нэгтгэхээс илүүтэй уусгахтай ойр юм. Энэ нь хялбар ажил биш бөгөөд нэгтгэхэд урт хугацаа шаардагдах боловч Өмнөдийн утга зохиолын хэл, Умардын соёлын хэл, мөн хангуго, чосөнъо хэмээх хэлний түүх эн үндэслэл, тогтолцооны бодит байдлыг хүлээн зөвшөөрч, хоёр талын зөвшөөрөгдсөн хэлбэ рийг харилцан хүндэтгэх хамтын лавлах тогтолцоо бүрдүүлэх хэрэгтэй.

Хэлний хэм хэмжээг зохицуулж, тохиролцох ажлыг харилцаанд үүсэж болох эрсдэлийн түвш ин, тохиролцоонд хүрэх боломжид тулгуурлан үе шаттай хэрэгжүүлэх шаардлагатай. Цахим технологи, хиймэл оюуны эрин үед тэмдэгтийн код, эрэмбэлэлт, тоо, нэгж, цэг тэмдэг, хайлт ын хөрвүүлэлт зэрэг техникийн хувьд харилцан нийцүүлэн ажиллуулах боломж өндөртэй чиг лэлийг цэгцлэх нь нэгтгэх ажлын тэргүүлэх зорилт болох учиртай. Түүнчлэн эмнэлгийн тусла мж үйлчилгээ, гамшиг, зам тээвэр, хууль эрх зүй зэрэг буруу ойлголцох нь амь нас, эрхэд нөл өөлөх салбарын нийтийн хэрэглээний нэр томьёог хамтран бүрдүүлэх хэрэгтэй. Харь үг, мэрг эжлийн нэр томьёог олон улсын хэмжээнд таньж ойлгох боломж, бодит хэрэглээнд хэр нийц эж байгааг харгалзан зохицуулж, тохиролцоонд хүрэхийн төлөө ажиллах ёстой. Үгийн эхний авианы дүрэм, нийлмэл үгийн заагт ㅅ (c) үсэг бичих дүрэм, үгийг салгаж бичих дүрэм зэрэг х элээрээ өөрийн онцлогийг илэрхийлэх ухамсар, хэвшсэн хэрэглээний нөлөө ихтэй асуудлаар нэгдсэн хувилбар тогтоох гэж яарахаас илүүтэй зэрэгцээ бичлэгийг зөвшөөрөх, нэг хэлбэрээ с нөгөөг харилцан лавлах боломжийг хамтад нь авч үзэх хэрэгтэй.

Ийм бодлогыг тогтвортой хэрэгжүүлэхэд улс төрийн нөхцөл байдлын өөрчлөлтөд ганхахгүй хамтын ажиллагааны суурь хэрэгтэй. Өмнөд, Умардын хэл шинжээчдийн байнгын зөвлөлдө х байгууллагыг түшиглэн багш, орчуулагч, мэдээллийн технологийн мэргэжилтэн, мөн эмнэ лэг, хууль эрх зүй, гамшиг зэрэг салбарын нэр томьёоны мэргэжилтнүүд оролцсон олон түв шний, цогц хамтын удирдлагын тогтолцоо бүрдүүлэх ёстой. Шаардлагатай бол, бүр тодруул бал, байгуулах нь зүй ёсны хэрэг гэж үзэн, улсын хэмжээнд “Өмнөд, Умардын хэлний нэгдм эл байдлыг хангах хороо”-г санаачлан байгуулах хувилбарыг ч идэвхтэй авч үзэх хэрэгтэй. Үүний зэрэгцээ аль хэдийн бүтээж дуусгасан《Солонгос үндэстний хэлний их тайлбар толь》-ийг бүтээх явцад хуримтлуулсан, хоёр талын тохиролцсон эх, хэлний хөмрөг, бичлэг болон хэлбэрийн материалыг хэлний хамтын дэд бүтэц болгон өвлөн ашиглаж, өмнөх тохиролцоог шалгаж, дахин нягтлах ёстой. Хиймэл оюун болон хайлт, орчуулга, ярианы технологийг ч Ум ардын хэллэгийг алдаа гэж дүгнэдэг, хэлний хэм хэмжээг тулган тогтоох эрх мэдлийн хэрэг сэл бус, Өмнөд, Умардын хэлний хувилбаруудыг тэгш шударгаар тайлбарлаж, харилцан яри лцахад туслах хэрэгсэл байхаар боловсруулах ёстой.

Хэлний ялгаа нь улс төрийн сөргөлдөөн, соёлын онцлогийн тухай ухамсар, нийгмийн зөрчил тэй холбогдох үед харилцааны саад бэрхшээлийг арилгахад хэцүү болдог. Гэвч хүний хэлни й эрхийн үүднээс Умардаас гарч ирсэн иргэдийг хэлийг нь засаж залруулах ёстой хүмүүс гэ ж бус, хоёр талын хэл, соёлыг холбох зуучлагч гэж үзэх хандлага ч нэн шаардлагатай. Бидн ий зорьж буй Өмнөд, Умардын хэлний нэгдмэл байдлыг хангах ажил нь зөв бичих дүрэм, мэ

ргэжлийн нэр томьёо зэргийг цэгцлэх хэлний бодлогын бодит үйл ажиллагаа мөн бөгөөд үү ний зэрэгцээ нөгөө талын хэлийг гутаан үзэх, хэлийг илүү, дутуу гэж үнэлэх хандлага, улс төрийн дайсагнал, соёлын өрөөсгөл ойлголтыг бууруулах нийгэм, соёлын үйл явцтай хамт өрнөх ёстой нь тодорхой. Иймээс харилцан адил байх зарчимд тулгуурлан нэгтгэх, зэрэгцээ хэм хэмжээг зөвшөөрч, шилжилтийн үеийн нэгтгэлийг хэрэгжүүлэх, нэгдсэн хэм хэмжээний түүхэн шалгуурыг тохиролцох, боловсролоор дамжуулан албан ёсны хэлний талаарх ойлголтыг нэмэгдүүлэх зэргийг Өмнөд, Умардын хэлний нэгдмэл байдлыг хангах үндсэн чиглэл болгох хэрэгтэй.

Өмнөд, Умардын хэлний нэгдмэл байдлыг хангах хүчин чармайлт нь улс төрийн нэгдлийн дараа эхлүүлэх ажил бус, харилцаа тасарсан үед ч тасралтгүй бэлтгэж байх ёстой энх тайвны суурь бөгөөд зайлшгүй хийх ажил юм. Нэгдмэл байдлыг хангана гэдэг нь нэг нэгнийхээ хэлийг арилгаж, нэг дуу хоолой болгох бус, өөр өөр дуу хоолой нөгөө талдаа хүрч чадах замыг нээх явдал юм. Өмнөд, Умардын хэлэнд шингэж ирсэн өөр өөр дурсамжийг хүндэтгэн, боогдсон урсгалыг нэг нэгээр нь нээх үед хэл нь зааг тогтоох хана бус, хүн хүнийг холбох гүүр болох юм. Korean(солонгосчууд/солонгос хэл) нэг билээ.

Ашигласан материал

Кан Бо Сөнъ (강보선). 2011. «Солонгос хэлний сурах бичигт орсон Умардын үгсийг шүүмжлэн авч үзэх нь — 2007 онд шинэчилсэн сургалтын хөтөлбөрийн дагуу зохиосон дунд сургуулийн хоёрдугаар ангийн солонгос хэлний сурах бичгийг судлах нь». «Солонгос хэлний боловсрол судлал» (국어교육학연구), № 42. Солонгос хэлний боловсрол судлалын холбоо, 215–240-р тал.

Кан Бо Сөнъ (강보선). 2020. «Нэгдлийн эрин үед бэлтгэх солонгос хэлний боловсролын өнөөгийн байдал ба зорилт». «Сөнчхөн хэл бичиг» (선청어문)№ 47. Сөүлийн их сургуулийн Солонгос хэлний боловсролын тэнхим, 109–138-р тал.

Кан Бо Сөнъ (강보선). 2025. «“Утга зохиолын хэлний сургалт”-д илэрсэн Умард Солонгосын үгийн сангийн сургалтын онцлог ба Өмнөд, Умардын нэгдэлд өгөх санаа». «Солонгос хэл судлал» (한국어학), № 109. Солонгос хэл судлалын холбоо, 1–49-р тал.

Квон Жэ Ил (권재일). 2004. «Манай хэлний ирээдүй ба Өмнөд, Умардын хэлний нэгдмэл байдлыг хангах арга зам». «Манай хэл бичиг» (우리말글) № 31. Манай хэл бичиг судлалын холбоо, 1–27-р тал.

Квон Жэ Ил (권재일). 2014. «Өмнөд, Умардын хэлний үгийн санг нэг мөр болгох нь». Сөүл: Сөүлийн их сургуулийн хэвлэл, соёлын хүрээлэн.

Квон Жэ Ил (권재일). 2015. «Хуваагдлын 70 жилийн Өмнөд, Умардын хэл». (지식의 지평, жишигый жипхён). Тэү сан, 1–17-р тал.

Квон Жэ Ил (권재일). 2018. «Өмнөд, Умардын харилцан ойлголцолд мэргэжлийн нэр томьёог нэгтгэх шаардлага ба чиглэл». (새국어생활, сэгуго-сэнхваль), № 28. Солонгосын Үндэсний хэлний хүрээлэн, 9–26-р тал.

Квон Жэ Ил (권재일). 2025. «Өмнөд, Умардын хэлний ялгааг даван туулах нь ба Солонгос үндэстний хэлний их тайлбар толь-ийг бүтээх ажил». (나라사랑, нарасаран), № 134. Весоль холбоо, 11–40-р тал.
Ким Мин Сү (김민수). 1985. «Умард Солонгос дахь эх хэлний судалгаа». Сөүл: Корё их сургуулийн хэвлэлийн газар.
Ким Мин Сү (김민수). 2003. «Өмнөд, Умардын хэлний нэгдмэл байдал ба албан ёсны хэл». «Манай хэл бичиг» (우리어문, уриомун), № 20. (우리어문학회), 5–21-р тал.
《Солонгос үндэстний хэлний их тайлбар толь》 бүтээх Өмнөд, Умард Солонгосын хамтарсан төслийн хороо. 2026. «Толь зохиох ажлын явц». https://gyeoremal.or.kr/gyeore/progress.php
И Гван Гю (이관규). 2021. «Өмнөд, Умард Солонгосын хэл бичгийн дүрмийн хувьсал ба зорилт». Сөүл: Корё их сургуулийн хэвлэл, соёлын хүрээлэн.
И Сан Хёк (이상혁). 2011. «Умард Солонгосын чосөнъ хэл судлалын онцлогийн тухай — "Чосөнъ хэл судлалын цуврал бүтээл" (2005), "Хэл шинжлэлийн судалгааны өгүүллийн заалт толь" (2006)-д тулгуурах нь». (어문논집), № 64. Үндэстний хэл бичиг судлалын холбоо, 137–161-р тал.
И Сан Хёк (이상혁). 2011. «Хилийн чанад дахь солонгосчууд, гадаадын иргэдэд зориулсан солонгос хэлний сургалт ба Өмнөд, Умардын хэлний асуудал — Солонгос хэлний нэгдсэн сургалтын хэрэглэгдэх үүн зохиох саналыг голлон авч үзэх нь». (한말연구), № 28. Солонгос хэл судлалын холбоо (한말연구학회), 231–252-р тал.
И Сан Хёк (이상혁). 2020. «Умард Солонгосын хэлний бодлогын харьцуулсан шинжилгээ ба түүнийг тайлбарлан бичихэд гарсан өөрчлөлтийн тухай — "Солонгосын Хөдөлмөрийн намын бодлогын түүх: Хэлний салбар" (1973), "Солонгосын Хөдөлмөрийн намын хэлний бодлогын түүх" (2005)-ийг голлон авч үзэх нь». (어문논집), № 90. Үндэстний хэл бичиг судлалын холбоо, 95–124-р тал.
И Сан Хёк (이상혁). 2024. «Хангуго ч, чосөно ч адилхан бидний хэл». (한글 새소식), № 626. Хангыл судлалын холбоо, 8–9-р тал.

И Сан Хёк

Хансөн их сургуулийн Олон улсын боловсон хүчин бэлтгэх сургуулийн Солонгос хэл, соёлын боловсролын тэнхимийн профессор.『Манай хэл үндэсний хэл болсон замнал』(хамтын бүтээл),「Умард Солонгосын хэлний бодлогын харьцуулсан шинжилгээ ба түүнийг тайлбарлан бичихэд гарсан өөрчлөлтийн тухай」,「Умард Солонгос дахь Хүнминжөным судлалын ололт ба хэтийн төлөв — Чөлөөлөлтийн дараах үеэс 2000-аад он хүртэлх судалгааны үр дүнг голлон авч үзэх нь」зэрэг бүтээлийн зохиогч.

Хэлэлцүүлэг 1

｢Өмнөд, Умардын хэлний 'ондоошил'-ын бодит байдал ба харилцан ойлголцоход тулгарч буй саад-ялгааг дав ан туулж, Өмнөд, Умардын хэлний нэгдмэл байдлыг ха нгах тухай санал｣ илтгэлийн хэлэлцүүлэг



Жү Ён Хүнъ Солонгос үндэстний хэлний их тайлбар толь

И Сан Хёк багшийн илтгэлээс их зүйл сурлаа. Ондоошлыг «хэр зэрэг өөр болсон бэ?» гэхээс илүү «тэр ялгаа нь харилцан ойлголцолд хэрхэн нөлөөлж байна вэ?» гэж авч үзсэн нь гүн сэ тгэгдэл төрүүлэв. Өмнөд, Умардын хэлийг нэг үү, хоёр уу гэж зааглахын оронд нийтлэг тогто лцоон дээр түвшин бүрийн ялгаа давхарлан оршиж байна гэж үзсэн нь толь бүтээдэг хүний хувьд надад онцгой таатай санагдсан.

Би 2011 оноос Солонгос үндэстний хэлний их тайлбар толь-ийг Өмнөд, Умард хамтран зохи ох төсөлд ажиллаж, хоёр талын үг хэллэгтэй шууд харьцан толь бүтээж ирсэн. Тиймээс тан ы илтгэлд дурдсан «ондоошил» толь бүтээх бодит ажилд ямар байдлаар илэрдгийг бодож үзлээ. Хоёр тал хамтран толь зохиоход танил бус үгнээс илүү танил үг хэцүү байх үе бий. '맥주' мэгжү буюу шар айраг тийм жишээ байсан. Хамтарсан хуралд Өмнөдийн тал мэгжүг «ийм, т ийм шинжтэй согтууруулах ундаа» гэж тайлбарлан бичиж очсон юм. Гэтэл Умардын тал «Би д шар айргийг согтууруулах ундаа биш, сэрүүцүүлэх ундаа гэж нэрлэдэг» хэмээн санал зөр сөн. Өмнөд нь согтууруулах ундаа, Умард нь сэрүүцүүлэх ундаа гэж үзсэнээр утгын тайлбар ын эхлэлээс л зөрсөн хэрэг. Таны хэлсэнчлэн мэдэхгүй үг бие биеэсээ асуухад хүргэдэг бол мэддэг үг асуух шаардлагагүй мэт санагдуулдаг. Адилхан 'мэгжү'-гийн тухай ярьж байгаа ч тал бүр өөрийгөө зөв гэж үзсэн тул санал зөрөхөөс аргагүй байлаа. Хэрэглээний жишээ сонг оход ч үүнтэй төстэй зүйл болсон. Яньбяний нэг романы хэсгийг жишээ болгон санал болгох

од Умардын толь зохиогч уг бүтээлээс толийн хэрэглээний жишээ авах нь зохистой эсэхэд э ргэлзэж байв. Нэг бүтээлийн тухайд «тольд оруулж болох бичвэр мөн үү?» гэсэн үнэлэлт нь өөр байсан юм. Ийнхүү утгын тайлбарт юуг голлох, хэрэглээний жишээг ямар шалгууруар с онгох, тухайн үгийг ямар өнцгөөс харах нь хүртэл ялгаатай учир ялгааг олохоос илүү тэр нь чухам ямар ялгаа болохыг тайлбарлахад хавьгүй их хугацаа ордог. Ийм туршлага хуримтла гдах тусам Өмнөд, Умардын хэлний ондоошил нь зөвхөн үгийн ялгаа бус, юуг хэрхэн хэлж, о йлгож ирсний ялгаа юм байна гэж бодогддог.

Энэ утгаараа “үгийг нь ойлгож байгаа ч утга, санаа зорилгыг нь заримдаа зөрүүлж ойлгодо г” гэсэн таны тайлбартай онцгой санал нийлж байна. 《Солонгос үндэстний хэлний их тайлба р толь》-ийг бүтээх нь Өмнөдийн толь, Умардын толийг зүгээр нийлүүлэх ажил байгаагүй. Хэ лний өөр өөр бодит байдлыг нэг тольд хэрхэн тайлбарлаж, холбох вэ гэдгийг хамтран эргэц үүлэх ажил байсан гэж боддог. Тиймээс илтгэлд санал болгосон “хамтын лавлах тогтолцоо” -нд анхаарал хандуулж байна. Өмнөд, Умардын хэлний нэгдмэл байдлыг хангах нь нэн дару й нэг хэм хэмжээ тогтоох ажил биш юм бол толь ч аль нэг талыг жишиг болгож, нөгөө талыг түүнд тулгуурлан тайлбарлах аргаас гарах шаардлагатай. Жишээлбэл, ‘노동 нодон’, ‘로동 родо н’(хөдөлмөр), ‘여행 ёхэн’, ‘려행 рёхэн’ (аялал) шиг бичлэг нь өөр үгийн нэгийг хасахаас илүү хо ёр бичлэг байдаг гэдгийг, мөн хоорондынх нь харьцааг үнэн зөв харуулах нь чухал. Цаашлаа д хэлбэр нь адил ч утга, хэрэглээний нөхцөл өөр байвал тэр ялгааг нь ч үзүүлэх ёстой. Тольд чухал нь аль нэгийг нь улаанаар дарж хасах бус, “энэ хоёр юугаараа өөр, тэгсэн атлаа хэрхэ н холбогдож байна вэ?” гэдгийг харуулах явдал гэж бодож байна.

Цахим болон хиймэл оюуны эрин үеийн хэлний нэгдмэл байдлын тухай хэсэг ч толь бүтээх а жилтай шууд холбогдож санагдсан. Толийн хэлний мэдээлэл одоо хайлт, орчуулга, яриа тан их, бүтээврийн задлал зэрэг хэлний технологийн нөөц болж байна. Тиймээс ‘노동 нодон’, ‘로동 родон’-ийг хэрхэн холбох нь бичлэгийн асуудал байхаасаа өмнө өгөгдлийн асуудал юм. Хий мэл оюун ч өгөгдөлд бүртгэсэн харьцаа, ялган ангилсан аргын нөлөөнд ордог. Аль илэрхийл лийг үндсэн хэлбэр, алийг нь хоёрдогч гэж үзэх нь зөвхөн толийн редакцын сонголт биш, ца ашид технологи хоёр талын хэлийг хэрхэн ойлгохтой холбоотой. Энэ асуудал хэвлэмэл толь д ч төдийлөн өөр биш. Аль нэг талын үгэнд ямар тэмдэглэгээ хийж, хаана байрлуулах нь хэр эглэгч тухайн үгийн байр суурийг хэрхэн ойлгохтой холбоотой байдаг. Эдгээрийг бодолцон г урван зүйл асуухыг хүсэж байна.

Нэгдүгээрт, “ондоошил” гэсэн нэр томьёоны тухай асуулт юм. Энэ үг хоёр талын хэл тусдаа хэл болсон мэт сэтгэгдэл төрүүлж болзошгүй тул болгоомжтой хэрэглэх ёстой ч өнөөгийн х элний бодит байдлыг тайлбарлахад хэрэгтэй ойлголт гэдгийг та илтгэлдээ хэлсэн. Ийм тэнц вэртэй хандлагатай би ч санал нийлж байна. 《Солонгос үндэстний хэлний их тайлбар толь》-д нийгэм, эдийн засаг, улс төр, соёл, эрдэм шинжилгээний онцлогийг тусгасан үгэнд «Өмнө дөд нэрлэдэг үг», «Умардад нэрлэдэг үг» гэх мэт тэмдэглэгээ хийх нь бий. Үүнийг нөгөө тал ын тогтолцоо, соёлыг харилцан хүндэтгэсэн утгын тайлбар гэж үзэж болох ч хэрэглэгчид ал

ь нэг талын үгийг танил бус, өөрийнх нь хэлнээс ангид мэт хүлээн авахад хүргэх тэмдэглэгэ э ч болж болзошгүй. Иймд хоёр талын хэлний ялгааг үнэн зөв мэдээлэхийн зэрэгцээ аль нэг талын хэлийг захын, хоёрдогч зүйл гэж хүлээн авахад хүргэхгүйн тулд тольд юуг анхаарах ё стой талаар таны бодлыг сонсохыг хүсэж байна.

Хоёрдугаарт, хэлний нэгдмэл байдлыг хангахад мэргэжлийн салбарын ялгааг хэрхэн авч үз эх тухай асуулт юм. Захиргаа, хууль, эрүүл мэнд шиг алдаа нь шууд нийгмийн хохирол, зард алд хүргэдэг салбарын хэлний нэгдмэл байдлыг чухалчилсантай санал нийлж байна. Гэхдээ эдгээр салбарт зөвхөн үг нь өөр бус, тогтолцоо нь өөр байх тохиолдол элбэг. Таны жишээ б олгосон '전세 чонсэ' шиг нэг талд нь яг дүйх тогтолцоо өөрөө байхгүй байхад «ижил утгат үг» гэж яаран холбовол харин ч ташаа ойлголт үүсгэж болно. Ойлголтууд үнэхээр дүйж байна у у, аль талын хэлбэрийг үндсэн хувилбар болгох вэ гэдгийг дан ганц хэл шинжээчид шийдэхэ д бэрх байх. Ийм шийдвэрийг салбарын мэргэжилтэн, толь зохиогчид ямар журмаар, хэрхэ н үүргээ хуваан гаргах нь зүйтэй талаар таны бодлыг сонирхож байна.

Гуравдугаарт, Өмнөд, Умардын хэлний хамтын ажиллагааг тогтвортой үргэлжлүүлэх тухай а суулт юм. Та《Солонгос үндэстний хэлний их тайлбар толь》-ийн хоёр талын тохиролцсон эх, хэлний хөмрөгийг хэлний хамтын дэд бүтэц болгон өвлүүлэх санал тавьсан. Гэтэл тус толий г зохиох ажил дуусах шатандаа яваа учир юуг, ямар хэлбэрээр үлдээж, цаашид хэлний хамт ын дэд бүтэц болгон хэрхэн өвлүүлэх вэ гэдэг нь одоо ч эргэцүүлж буй асуудал юм. Үүнтэй х олбоотойгоор бидний яг одоо тулгарч буй бодит бэрхшээл бий. Хоёр тал шууд уулзахад хүнд рэлтэй байгаа энэ үед эхийн хянан засварлах ажил зөвхөн Өмнөдөд хийгдэж байна. Энэ явц ад зориогүй ч толийн тайлбар, эрэмбэлэлт Өмнөдийн хэм хэмжээ, бодит хэрэглээг голлосон тал руу хэлбийж болзошгүй гэсэн болгоомжлол бий. Эхийг ийм байдлаар шилжүүлбэл Өмнө дийн шалгуур хамтын дэд бүтцийн анхдагч тохиргоо болж ч магадгүй. Хиймэл оюун Умарды н хэллэгийг алдаа гэж тогтоодог «хэлний хэм хэмжээг тулган тогтоох эрх мэдэл» болж боло хгүй гэж та хэлсэн. Толь ч зөвхөн нэг талын гараар дамжих хугацаа уртсах тусам ийм болго омжлолоос зайлсхийхэд бэрх гэж бодож байна. Үүний зэрэгцээ хоёр тал шууд уулзах болом ж хомс үед Өмнөд урьдчилан хийж болох бэлтгэл юу байх талаар таны бодлыг сонсохыг хүс эж байна.

Хэлний нэгдмэл байдлыг хангах ажил нь хүмүүсийг ижил үг хэлдэг болгохоос бус, өөр өөр үг хэлсэн ч харилцан ойлголцож чаддаг болгохоос эхэлнэ гэсэн илтгэлийн чиглэлтэй гүнээ са нал нийлж байна. Толь ч мөн адил гэж боддог. Сайн толь гэдэг нь ялгааг арилгасан толь биш, ялгаа хаана байгааг үнэн зөв харуулж, түүнийг даван ойлголцох замыг хамт зааж өгсөн толь юм.

Толь бүтээх ажилд оролцсон хүний хувьд хэлбэл,《Солонгос үндэстний хэлний их тайлбар т оль》-ийг бүтээсэн үйл явц нь таны хэлсэн «хэм хэмжээг үе шаттай нэгтгэсэн бодит туршла га» гэхээс илүү хоёр тал тохиролцоход бэрх нөхцөлд эцсийг нь хүртэл тэсэж, ажлаа үргэлж лүүлж ирсэн хугацаа байсан гэж санагддаг. Тэрхүү тэсэж үргэлжлүүлсэн туршлагыг онолын

үүднээс нэгтгэн, тэмдэглэн үлдээж, дараагийн толь зохиогчдод өвлүүлж чадвал тэр нь өөр өө үнэ цэнтэй хэрэг болно. Илтгэлийн төгсгөлд хэлсэнчлэн хэл хүн хүнийг холбох гүүр болд ог юм бол《Солонгос үндэстний хэлний их тайлбар толь》тэр гүүрний хашлага шиг үүрэг гүй цэтгэх болов уу. Нүдэнд төдийлөн тусдаггүй ч байхгүй бол гүүрээр гарахад түгшүүртэй байд аг тэр хашлага юм. Түүнийг хэрхэн илүү бат бөх болгох талаар бодоход хүргэсэн илтгэлд тан ь баярлалаа. Үгээр хэлэлцүүлгээ өндөрлөе.

Жү Ён Хүнъ

Солонгос үндэстний хэлний их тайлбар толь бүтээх Өмнөд, Умард Солонгосын хамтарсан төслийн хо рооны толь зохиох ажлын ахлах мэргэжилтэн.

《Солонгос үндэстний хэлний бага тайлбар тольтой урьдчилан танилцах нь》(хамтран зохиосон),ᶠУма рд Солонгосын багшийн дээд сургуулийн хэл зүйн <Чосөнъ утга зохиолын хэл> сурах бичгийн шинж илгээᶩ,ᶠӨмнөд, Умардын хэлийг нэгтгэсэн солонгос хэлний тольд хэл шинжлэлийн нэр томьёог тусга х аргын судалгаа — 《Солонгос үндэстний хэлний их тайлбар толь》-ийн жишээгээрᶩ(хамтын өгүүлэл) зэрэг бүтээлийн зохиогч.

Илтгэл 2

Өмнөд, Умардын хэлний ялгаа ба《Солонгос үндэстний хэлний их тайлбар толь》-д түүнийг тусгах арга



Чой Сон Гйү Солонгос үндэстний хэлний их тайлбар толь

1. Удиртгал

Японы колоничлолын үе дууссаны дараа гурван мянган ли сунасан Солонгосын хойгт хоёр засгийн газар тус тус байгуулагдаж, Өмнөд, Умард болон хуваагдсанаас[1] хойш өдгөө бараг 80 жил өнгөрчээ. Гэсэн ч Өмнөд, Умардынхан нэг нэгнийхээ хэлийг өнөө ч ойлгодог бөгөөд эвлэрлийг зорьсон яриа хэлэлцээнээс эхлээд буруутгасан мэдэгдэл хүртэл орчуулгагүйгээр, хэлсэн үгийн утга төдийгүй сэтгэлийн өнгө аяс нь ч амьдаар мэдрэгдэн хүрдэг.

Мэдээж Өмнөд, Умардын хэлэнд ялгаа бий. Хуваагдахаас өмнө байсан нутгийн аялгууны түвшний ялгаан дээр олон жилийн турш харилцаа тасарснаас үүдсэн шинэ ялгаа бага багаар нэмэгдсээр байна.《Солонгос үндэстний хэлний их тайлбар толь》-ийг Өмнөд, Умардын эвлэрэл, хуваагдлыг даван туулах үйлсэд хувь нэмэр оруулж, хоёр талын хэлний нэгдмэл байдлыг хангахыг зорьсон толь болгон бүтээж байна. Иймээс тус тольд хоёр талын хэлэнд илэрсэн ялгааг хэрхэн нэгтгэн зохицуулах нь нэн чухал асуудал юм.

Энэхүү өгүүлэлд Өмнөд, Умардын хэлний ялгаанаас толь бүтээх ажилтай шууд холбогдох асуудлуудыг авч үзэж, тэдгээрийг нэг тольд багтаан тусгах аргыг хэлэлцэнэ. Иймд хэлний олон дэд түвшнээс бичлэг, хэл зүй, утгад голлон анхаарна. Энэ нь мэдээж《Солонгос үндэстний хэлний их тайлбар толь》-ийн агуулгатай ч холбоотой. Гэхдээ тус толь хараахан нийтэд нээл

1) Энэ өгүүлэлд аль болох '북한' (Умард Солонгос), '남조선' (Өмнөд Чосөнъ) гэсэн нэрээс зайлсхийж, '남, 남녘' (Өмнөд), '북, 북녘' (Умард) гэсэн хэллэг хэрэглэнэ. Харин бусдын үгийг эшлэх зэрэг зайлшгүй шаардлагатай үед өөрөөр хэрэглэх болно.

ттэй болоогүй тул толийн эхийг жишээ болгон үзүүлэхдээ одоо оруулсан агуулгыг тэр хэвээр нь харуулахгүй, харин уншигчдад ойлгуулах зорилгод нийцүүлэн заримыг нь товчилж, өөрчилж үзүүлнэ.

2. Бичлэгийн ялгаа

Өмнөд, Умардын хэлний бичлэгийн[2] ялгаа нь мэргэжилтэн, мэргэжлийн бус хүн ялгалгүй олны анхаарлыг татдаг сэдэв боловч[3] хэлэлцэхэд амаргүй. Учир нь олон хүн өөр өөр санал дэвшүүлэхийн зэрэгцээ энэ асуудал нийгмийн зөрчилтэй холбогдох эрсдэлтэй. Өмнөх судалга ануудад ч ийм бэрхшээлийг дурдсан байдаг.[4]

Олон бэрхшээл байсан ч《Солонгос үндэстний хэлний их тайлбар толь》-ийн хүрээнд «Хэлбэр, бичлэгийн хороо»-ийг байгуулж, хамтарсан хурлуудаар бага багаар тохиролцоонд хүрч иржээ. Үүний үр дүнд хоёр талын бичлэгээс нэгийг нь нэгдсэн хэлбэр болгон авсан, хоёр бичлэгийг хоёуланг нь зөвшөөрсөн, мөн гурав дахь шинэ бичлэгээр нэг мөр болгосон тохиолдлууд бий болсон. Гэвч 2015 оноос хойш хамтарсан хурал үргэлжлээгүй учир өнөө хүртэл тохиролцоогүй асуудлууд үлджээ.

Хамтарсан хурлыг дахин хийж, бүх асуудлыг тохиролцох нь хамгийн зохистой. Гэхдээ хурал болохгүй байна гээд зөвхөн хүлээсээр байх боломжгүй. Тохиролцоогүй асуудлыг тольд хэрхэн тусгах талаар боломжит хувилбарыг түр боловсруулж, цаашид хамтарсан хурал дахин болбол тохиролцооны үр дүнг тусган засаж болох юм. Энэ хоёрдугаар хэсэгт тохиролцсон болон тохиролцоогүй асуудлуудыг тоймлоод, цахим, хэвлэмэл толийн онцлогтой холбон бичлэгийн ялгааг тусгах аргыг авч үзнэ.

2.1. Тохиролцсон ба тохиролцоогүй асуудал

Өмнөдийн эрдэмтэн Хон Жон Сон (2012:140) 2010 оны арван хоёрдугаар сар хүртэл хоёр талын тохиролцсон зүйлсийг товч танилцуулсан байдаг. Үүнээс хойших хамтарсан хурлуудаар ч шинэ тохиролцоонууд нэмэгджээ. Нийт тохиролцсон зүйлээс заримыг нь 1-р хүснэгтэд үзүүлэв.[5]

---

2) Нарийн утгаар энд ‘бичлэг’ болон ‘хэлбэр’ (morph) хоёуланг хамруулж байна.

3) Өмнөдийн «Солонгос утга зохиолын хэлний тайлбар толь» (1999), Умардын «Солонгос (Чосөнъ) хэлний их тайлбар толь» (2006–2007)-ийн бичлэгийн нийт ялгааны тухайд Өмнөд, Умардын хамтарсан хорооны 2019б бүтээлийг үзнэ үү.

4) Хон Юн Пё (2007:44–45), Ким Жү Сон (2020:170) зэрэг судалгаанд энэ асуудлыг дурдсан. Товчхондоо, хэлний бичлэг нь улсын нэр хүнд, үндэсний бахархалтай холбогддог тул аливаа тохиролцоо, хэсэгчилсэн буултыг хүртэл буруу бичлэг гэж үзэх эрсдэлтэй.

5) Тус толийн агуулга нийтэд нээлттэй болоогүйг харгалзан, энэ өгүүлэлд нийт тохиролцооны өчүүхэн хэсгийг л жишээлсэн. Цаашдын жишээнүүдэд ч мөн энэ зарчмыг баримталсан.

Бичлэг, хэлбэрийн асуудал	Жишээ
Залгуулан бичих ба зааглан бичих	모질음 (Ө) — **모지름** (У) **설거지** (Ө) — 설겆이 (У)
Давхар ба дан үсэг[6]	곱빼기 (Ө) — **곱배기** (У) **빛깔** (Ө) — 빛갈 (У) **잠깐** (Ө) — **잠간** (У)
'-이', '-히' дагавар	촉촉이 (Ө) — **촉촉히** (У) **빼곡히** (Ө) — 빼곡이 (У)
[j] авиа шургах	**드디어** (Ө) — 드디여 (У) **되었다** (Ө) — **되였다** (У) **이엉** (Ө) — 이영 (У)
[i], [j] авианы нөлөөгөөр өмнөх эгшиг ижилсэх	**구덩이** (Ө, У) — **구뎅이** (У) **할아비** (Ө) — **할애비** (У)
'ㅎ'-ээр төгссөн хувилах үгс (үйл үг, тэмдэг нэр) -ийн дүрмийн бус хувилал	누레서 (Ө) — **누래서** (У) 꺼메지다 (Ө) — **꺼매지다** (У)
Ханзны дуудлага	**오류** (Ө) — **오유** (У) **왜곡** (Ө) — **외곡** (У)
Харь үг	**라디오** (Ө) — 라지오 (У) 메시지 (Ө) — 메쎄지 (У) **알루미늄** (Ө) — 알루미니움 (У) **클라리넷** (Ө) — **클라리네트** (У)

Хүснэгт 1. Хоёр талын тохиролцсон бичлэг, хэлбэрийн зарим жишээ. Ө - Өмнөд; У - Умард.

1-р хүснэгтийн тод, доогуур зураастай үсгээр тэмдэглэсэн хэлбэрүүд нь тохиролцсон бичлэг юм. Хоёр хэлбэрийг хоёуланг нь тодруулж бичсэн тохиолдол (жишээлбэл, '잠깐, 잠간') нь эд гээрийг (хэлний хэм хэмжээнд нийцэх.орч) зэрэгцээ хувилбар болгон хүлээн зөвшөөрөхөөр хоёр тал тохиролцсоныг илэрхийлнэ. Аль алийг нь тодруулаагүй бол, жишээлбэл '메시지, 메쎄지', гурав дахь хэлбэрээр тохиролцсоныг заана. Энэ тохиолдолд '메세지' гэж тохиролцжээ. Нэ гэнт тохиролцсон бичлэгүүдийг толийн эхэд тэр хэвээр нь тусгана.

Харин тохиролцоонд хүрээгүй зүйлс асуудал хэвээр үлдэнэ. Хамгийн том асуудал нь үгийн эхний авианы дүрэм буюу 두음법칙, жишээлбэл '노동 нодон' (Өмнөд), '로동 родон' (Умард), мөн нийлмэл үгийн заагт ㅅ(с) үсэг бичих дүрэм буюу 사이시옷, жишээлбэл '바닷물' (Өмнөд), '바다물'

6) Эдгээрийг чанга, сул гийгүүлэгч гэж нэрлэх нь олонтоо. Гэхдээ дээрх жишээнүүдийг хоёр талд хоёуланд нь [곱빼기], [빛깔], [잠깐] гэж дууддаг.

(Умард) юм. Эдгээрт хамаарах үг олон учир толийн эхэд ч олон давтагдахаас өөр аргагүй. 1-р хүснэгтэд үзүүлсэн тохиролцоонууд үнэ цэнтэй ч толийн эхэд эзлэх хэмжээ нь энэ хоёр ас уудлынхаас хавьгүй бага. Өөрөөр хэлбэл, хамгийн их анзаарагддаг хоёр асуудал тохиролцо огүй үлдсэн байна.

Хангыл үсгийн бичлэгээс гадна үгийг салгаж бичих дүрэмд ч ялгаа бий. Үүнд мөн тохиролцс он, тохиролцоогүй зүйлс байна. Зян Лина (姜丽娜, 2022) Хятад дахь солонгос хэлний 2016 он ы хэм хэмжээг шинэчлэхдээ《Солонгос үндэстний хэлний их тайлбар толь》-ийн тохиролцоо г тусгасныг танилцуулжээ. Тохиролцсон зүйлсээс цөөн жишээг 2-р хүснэгтэд үзүүлэв.

Бичлэгийн асуудал	Жишээ
Албан тушаал, зэрэг дэв	**김철수 부장** (Ө) — 김철수부장 (У) **박영철 동지** (Ө) — 박영철동지 (У)
Тоолох нэгж заасан эрхшээлт нэр (бие даан хэрэглэгддэггүй нэр үг)	한 개 (Ө) — **한개** (У) 오만 원 (Ө) — **오만원** (У)
Туслах үйл үг, тэмдэг нэр	먹여 주다 (Ө) — **먹여주다** (Ө, У) **보고 싶다** (Ө) — 보고싶다 (У)

Хүснэгт 2. Хоёр талын тохиролцсон үгийг салгаж бичих дүрмийн зарим жишээ

2-р хүснэгтэд бүгдийг нь оруулаагүй боловч нэр үгийн цуваа холбооны талаар хэд хэдэн на рийвчилсан тохиролцоо бий. Гэхдээ олон тохиолдолд утгыг харгалзсан шалгуур, үндсэн зар чим, зөвшөөрөх хувилбар зэрэгцэн үйлчилдэг. Тиймээс хоёр талын ялгаа, тохиролцоог товч хүснэгтээр харуулахад бэрх тул энд орхисон. Дээрх мэт тохиролцсон зүйлс энгийн ч бай, төвөгтэй ч бай толийн эхэд шууд тусгаж болох учир хүндрэлгүй.

Тохиролцоогүй үгийг салгаж бичих дүрмээс хамгийн их анзаарагддаг нь эрхшээлт нэр үгийн зай авч бичих бичлэг юм. Тоолох нэгж заасан эрхшээлт нэр үгийн тухайд 2-р хүснэгтэд үзүү лсэнчлэн тохиролцсон. Харин нэгж заадаггүй '것, 수, 데…' зэрэг эрхшээлт нэр үгийг хэрхэн би чих нь тохиролцоогүй үлджээ. Эдгээр нь тольд олон давтагддаг тул толь бүтээх явцад хэрхэ н тусгах аргыг боловсруулах шаардлагатай.

Ю Хён Гён (2021:24–25) тохиролцоогүй бичлэгт '#' тэмдэг хэрэглэн '노인#로인', '푸주간#푸줏간' г эх мэтээр бичиж болохыг товч үзүүлсэн. Ийнхүү хоёр бичлэгийг зэрэгцүүлэн харуулах нь нэг б оломж юм. Гэхдээ олон нийтийн өдөр тутмын хэлний хэрэглээнд байдаггүй танил бус тэмдгий г шууд үзүүлдэг нь сул талтай. Дараах 2.2-р хэсэгт цахим болон хэвлэмэл толийн онцлогтой хо лбон тохиролцоогүй бичлэгийн асуудлыг үргэлжлүүлэн авч үзнэ.

2.2. Цахим толь ба хэвлэмэл толь

《Солонгос үндэстний хэлний их тайлбар толь》-ийг цахим болон хэвлэмэл хэлбэрээр гаргахаа р төлөвлөж байна. Цахим толь нь хэвлэмэл толиос өөр онцлогтой тул үүнийг ашиглан тохирол цоогүй бичлэгийг харуулах өөр арга сонгож болно. Тус толийн Өмнөдийн талын зөвлөлийн дар га Чо Жэ Сү дараах саналыг хэлсэн байдаг.

"'여성노동자' ёсоннодонжа болон '녀성로동자 нёсонродонжа' нь нэг үг боловч сонсогдох өнгө аяс нь их өөр тул аль нэгийг нь сонгочихвол хоёр тал хоёул буулт хийсэн мэт санагдаж болно. … Э нэ асуудлыг вэб толь хялбархан шийдэж чадна. Учир нь 'Умардын горим', 'Өмнөдийн горим'-ыг тус тус бий болгож, үгийн эхний авианы дүрэм болон заагийн ㅅ-тэй хэсгийг автоматаар хувир гадаг болгож болно." (Жон Чоль, 2017:21-ээс эшлэв.)

Хэвлэмэл толь нэгэнт хэвлэгдсэн үр дүнг л үзүүлдэг бол цахим толийн дэлгэцэд гарах үр дүнг өөрчилж болно. Иймээс хоёр хэлбэрийг бэлтгээд, хэрэглэгчийн сонголтод тохируулан харуула х замаар тохиролцоогүй бичлэгийг тусгах боломжтой.

Үүнтэй холбоотой жишээ нь хятад ханзны хялбаршуулсан ба уламжлалт[7] бичлэг юм. Хятад хэл ний зарим цахим хуудас хэрэглэгчийн сонголтоор хялбаршуулсан эсвэл уламжлалт ханзаар м эдээллээ харуулдаг. 1, 2-р зурагт BBC-ийн хятад хэлний https://www.bbc.com/zhongwen цахим хуудасны хэсгийг үзүүлэв.[8]



Зураг 1. BBC-ийн хятад хэлний хуудасны хялбаршуулсан ханзтай дэлгэц



Зураг 2. BBC-ийн хятад хэлний хуудасны уламжлалт ханзтай дэлгэц

1-р зураг нь хялбаршуулсан, 2-р зураг нь уламжлалт ханзтай дэлгэц юм. Үсэг нь өөр боловч хэ лний илэрхийлэл болон мэдээний агуулга нь ижил. Гол мэдээний гарчгийг буулган бичиж, ялга атай үсгийг дэвсгэр өнгөөр ялгавал дараах байдалтай байна.

---

7) Эх газрын Хятадад нийлмэл бичлэгт ханз '번체자 (繁体字)', Тайваньд үндсэн хэлбэрээ хадгалсан ханз '정체자 (正體字)' гэж нэрлэдэг.

8) Зар сурталчилгааны хэсгийг арилгасан тул бодит дэлгэцээс бага зэрэг өөр. Зургийг 2026 оны есдүгээр сарын 21-нд авсан.

(1) 中共五中全会日期敲定 习近平政治地位新提法成看点
(2) 中共五中全會日期敲定 習近平政治地位新提法成看點

Хоёр гарчгийн утга: «ХКН-ын Төв хорооны тавдугаар бүгд хурлын тов тогтов. Ши Жиньпиний улс төрийн байр суурийн талаарх шинэ томьёолол анхаарал татаж байна».
Дэлгэцийн баруун дээд булан дахь 简 хялбаршуулсан эсвэл 繁 уламжлалт-ыг дарахад хоёр бичлэгийн хооронд шилжинэ. Хялбаршуулсан ханзаар унших хүн тухайн дэлгэцийг, уламжлалт ханзаар унших хүн нөгөө дэлгэцийг сонгож болно. Цаасан дээр дэлгэцийн ийм шилжилт хийх боломжгүй боловч компьютерын дэлгэцэд боломжтой. Ингэснээр өөр өөр бичлэгээр и жил агуулгыг хүргэж чадна.
《Солонгос үндэстний хэлний их тайлбар толь》 хараахан нийтлэгдээгүй тул бодит эх нь дэлгэцэд хэрхэн харагдахыг яг таг үзүүлэх боломжгүй. Харин 1, 2-р хэрэглэгдэхүүнд түүнтэй төс тэй түр жишээ бэлтгэв. Бичлэг нь ялгаатай үгсийг харахад дөхөм болгохын тулд дэвсгэр өнг өөр ялгасан.



Хэрэглэгдэхүүн 1. ‘쏨뱅이’ үгийн Өмнөдийн бичлэгээр харуулсан дэлгэцийн түр жишээ

Хэрэглэгдэхүүн 2. ‘쏨뱅이’ үгийн Умардын бичлэгээр харуулсан дэлгэцийн түр жишээ

쏨뱅이 ссомбэн-и [нэр үг]

Толгойн ар хэсэгт олон хурц өргөстэй загас. Биеийн урт нь 20 см орчим. Далайн эрэг, арлын эргэн тойрны гүехэн усан дахь хадны завсраар амьдарна. Манай орны далайн эрэг дагуу ни йтэд тархсан. Өндөг нь эхийн биед бойжиж, зулзага төрүүлдэг бөгөөд хүнсэнд хэрэглэж бол но. (Sebastiscus marmoratus)
Дээрх хоёр жишээний утга ижил; зөвхөн ‘바닷가/바다가’, ‘난태생/란태생’, ‘식용할 수/식용할수’ гэсэн б ичлэгүүд ялгаатай.
Өмнөдийн бичлэгийг сонгосон хэрэглэгчид 1-р хэрэглэгдэхүүн, Умардын бичлэгийг сонгосо н хэрэглэгчид 2-р хэрэглэгдэхүүнтэй адил дэлгэц харагдана. Ийм арга нь бүрэн тохиролцоо гүй асуудалд аль нэг талын бичлэгийг эцэслэн сонгох ачааллыг багасгана. Мөн хоёр талын бичлэгийг цахим тольд хоёуланг нь хэрэгжүүлснээр аль алиныг нь хүндэтгэх эмхэтгэлийн за рчмыг баримталж чадна.

Хэвлэмэл тольд энэ аргыг хэрэглэх боломжгүй. Гэхдээ түүнд тохирох өөр арга бодож бол но. Үүний нэг жишээ нь зэрэгцүүлэн бичих арга юм. 3-р зурагт Interlinear Bible (Cambridge University Press, 1906)-ийн Маркийн сайн мэдээний хэсгийг үзүүлэв.



THE GOSPEL ACCORDING TO

S. MARK.

I 1 THE beginning of the gospel of Jesus Christ, [1a]the Son of God. God; 2 [b]Even as it is written [2]in Isaiah the prophet, the prophets, [c]Behold, I send my messenger before thy face, Who which shall prepare thy way; way before thee. 3 [d]The voice of one crying in the wilderness, [e]Make ye ready the way of the Lord, Prepare ye Make his paths straight; straight.

a See Matt. 14. 33.
b For ver. 2—8, see Matt. 3. 1—11 & Luke 3. 2—16.
c Acts 7. 56. d Isai. 64. 1. e John 1. 23. Cp. Luke 3. 4, 5.
f Acts 10. 38. / Matt. 11. 10. Luke 1. 17, 76 & 7. 27. Cited from Mal. 3. 1. g John 12. 38.
h Cp. ch. 2. 7. i Ps. 2. 7. k Isai. 42. 1. l Eph. 1. 6. m Col. 1. 13. n 2 Pet. 1. 17.

was baptized of John [4]in the Jordan. 10 And straightway coming up out of the water, he [o]saw [d]the heavens rent asunder, [e]and the Spirit as like a dove descending upon him: 11 And there came [g]a voice came out of the heavens, saying, [h]Thou art my beloved Son, in thee whom I am well pleased. 12 [i]And straightway immediately the Spirit driveth him forth into the wilderness. 13 [j]And he was there in the

Зураг 3. Cambridge Interlinear Bible (1906)-ийн хэсэг

Энэхүү Библи нь 1885 онд хэвлэгдсэн шинэчилсэн орчуулга (RV, Revised Version) болон 1611 онд хэвлэгдсэн хааны зарлигаар баталсан орчуулга (AV, Authorized Version)-ыг[9] нэг хуудас д ээр зэрэгцүүлэн бичжээ. Хоёр орчуулгын ижил хэсгийг том үсгээр нэг мөрт, ялгаатай хэсгий г жижиг үсгээр хоёр мөрт бичсэн байна. Дээд мөр нь RV, доод мөр нь AV хувилбар юм. 3-р з ургийн 1-р бүлгийн 2-р эшлэлийг зүүлтийн тэмдэггүйгээр буулгавал дараах байдалтай.

(3) Even as / As | it is written in | Isaiah the prophet, / the prophets, | Behold, I send my messenger before thy face,

Who / Which | shall prepare thy | way; / way before thee.

(3) Зэрэгцүүлэн бичсэн эх. Хувилбаруудын эхнийх нь дээд, хоёр дахь нь доод мөрт орно.

(3′) Even as it is written in Isaiah the prophet, Behold, I send my messenger before thy face, Who shall prepare thy way; (RV хувилбар)

«Эш үзүүлэгч Исаиагийн номд бичсэнчлэн: “Харагтун, чиний замыг бэлтгэх элчээ би чиний өмнө илгээж байна”».

(3″) As it is written in the prophets, Behold, I send my messenger before thy face, Which shall prepare thy way before thee. (AV хувилбар)

9) Кинг Жеймсийн орчуулга (KJV, King James Version) гэдэг нэрээр илүү танигдсан.

«Эш үзүүлэгчдийн номд бичсэнчлэн: “Харагтун, чиний өмнөх замыг бэлтгэх элчээ би чиний өмнө илгээж байна”».

(3) нь (3′), (3″) гэсэн хоёр эхийг нэг хуудас дээр нэгтгэн зэрэгцүүлж бичсэн үр дүн юм. Ийнх үү бага зэрэг ялгаатай эхүүдийг нэгтгэн харуулж болно. Мэдээж (3)-т зөвхөн бичлэгийн бус, үг болон түүнээс том нэгжийн ялгааг ч багтааж байгаа тул《Солонгос үндэстний хэлний их тайлбар толь》-ийн аргатай яг адил биш. Гэхдээ хоёр ялгаатай хэлбэрийг нэгтгэсэн ийм дүрсл элийг хэвлэмэл материалд бодитоор хэрэглэж болдог нь чухал. Энэ аргыг өмнө үзсэн ‘쏨뱅이’ үгийн эхэд хэрэглэвэл дараах байдалтай болно.

쏨뱅이 [명]

머리의 뒤쪽에 날카로운 가시가 많이 나있는 물고기. 몸의 길이는 20cm 정도이며, 바위틈에서 산다. 우리 나라 전 연안에 퍼져있다.

바다가 바닷가 나 섬 둘레의 얕은 물속

난태생 란태생 이며 식용할수 식용할 수 있다. (Sebastiscus marmoratus)



Хэрэглэгдэхүүн 3. ‘쏨뱅이’ үгийг зэрэгцүүлэн бичсэн хэвлэмэл хуудасны түр жишээ

3-р хэрэглэгдэхүүнд дээд, доод мөрийн байрлалыг Interlinear Bible-ийнхээс арай өөр зарчма ар тогтоосон. Өмнөдийн эсвэл Умардын бичлэгийг үргэлж дээр нь байрлуулбал нэг талыг д авуу тавилаа гэсэн шүүмжлэл гарч болно. Иймээс хангыл үсгийн дарааллыг баримтлав. ‘바다가/바닷가’-д Умардын, ‘난태생/란태생’-д Өмнөдийн хэлбэр нь дээр орсон. Харин зайгаар ялгаата й ‘식용할수/식용할 수’-ийн богино хэлбэрийг дээр байрлуулсан.

Зэрэгцүүлэн бичих аргын сул тал нь бага зэрэг төвөгтэй харагдаж, уншихад хялбар байдлы г бууруулдагт оршино. Хааяа нэг тохиолдвол асуудалгүй ч олон давтагдвал уншихад эвгүй б олж болно. Үүнийг харгалзан салгаж бичих ялгааг илүү энгийн аргаар тэмдэглэж болох юм. Жишээлбэл, ‘식용할∨수’ эсвэл ‘식용할⌒수’ гэж хянан засварлах тэмдэг хэрэглэвэл заавал хоёр мөрт зэрэгцүүлэх шаардлагагүй. ‘∨’, ‘⌒’ нь албан ёсны цэг тэмдэг биш бөгөөд олон нийтийн өдөр тутмын бичгийн хэрэглээнд ордоггүй. Гэвч сургуульд зай авах, нийлүүлж бичихийг заа даг тэмдэг болгон өргөн хэрэглэдэг учир олон нийт ойлгохгүй байхаар хэцүү биш.

Ийнхүү Өмнөд, Умардын бичлэгийн ялгааг цахим болон хэвлэмэл тольд харуулах аргуудыг авч үзлээ. Эндэх жишээнүүд нь《Солонгос үндэстний хэлний их тайлбар толь》-ийн эцсийн х увилбар биш тул бэлэн толь тодорхой хэмжээнд өөр байх болно. Гол нь хоёр талын бичлэги йн ялгааг хүндэтгэх зарчмыг баримтлан, хэрэглэгчид ойлгомжтой аргыг олох явдал юм.

3. Хэл зүйн ялгаа

Өмнөд, Умардын хэлний өөрийнх нь хэл зүй төдийлөн ялгаатай биш. Харин хэл зүйг тайлба рладаг онол, нэр томьёонд их ялгаа бий. Толь бичиг нь хэл зүйн судалгааны бүтээл биш учи р хэл зүйн тогтолцоог нарийвчлан авч үздэггүй, мөн заавал хэл зүйн тайлбар шаарддаггүй үг олон. Гэвч зарим үгийн онцлогийг тайлбарлахад хэл зүйн нэр томьёо хэрэглэхээс аргагүй бөгөөд тэдгээр нэр томьёо тодорхой онолын тогтолцоонд тулгуурладаг. Иймээс наад зах нь толь бүтээхэд хэрэгтэй хэмжээнд тохиролцох шаардлагатай.

Ким Бён Мүн, Жү Ён Хүнъ (2017) 《Солонгос үндэстний хэлний их тайлбар толь》-ийн хэл зүйт эй холбоотой нэр томьёог хэрхэн тусгахыг судалсан. Мөн тус толийн хамтарсан хурлаар хэл шинжлэлийн нэр томьёог хэлэлцэн тохиролцож иржээ. Толь зохиоход хамаатай зарим тохи ролцоог хүснэгт 3-т үзүүлэв.

Өмнөдийн нэр томьёо	Умардын нэр томьёо	Тохиролцсон хувилбар
조사, 어미 Нэр үгийн нөхцөл, үйл үгийн нөхцөл	토 То	토[10] То
의존명사 Эрхшээлт нэр (Бие даан хэрэ глэгддэггүй нэр үг)	불완전명사 Бүрэн бус нэр	의존명사 Эрхшээлт нэр
지시대명사 Заах төлөөний үг	가리킴대명사, 지시대명사 Заах төлөөний үгийн хоёр нэ ршил	지시대명사 Заах төлөөний үг
보조동사 Туслах үйл үг	보조동사[11] Туслах үйл үг	보조동사 Туслах үйл үг
감탄사 Аялга үг	감동사 Аялга үгийн өөр нэршил	감탄사 Аялга үг

Хүснэгт 3. Хоёр талын тохиролцсон хэл зүйн нэр томьёоны зарим жишээ

Хэл шинжлэлийн нэр томьёог өөрийг нь тайлбарлахдаа хоёр талын ялгаа их бол аль алиныг нь толгой үг болгон авч, тус тусад нь тайлбарлан, зөвшөөрөгдсөн зэрэгцээ хувилбарын адил тусгаж болно. Харин тэр нэр томьёог өөр үгийн тайлбарт хэрэглэх үед нөхцөл өөр болно. Нэ

10) Зөвхөн ‘조사’, ‘어미’-гийн оронд ‘토’ гэдэг нэр хэрэглэхийг тохиролцсон гэсэн үг. ‘주격토 Нэрлэхийн тийн ялгалын нөхцөл’, ‘이음토’ Үйлийн холбох нөхцөл зэрэг дэд ангиллыг тэр хэвээр нь хэрэглэнэ гэсэн үг биш. Ю Хён Гён (2021:14) ‘토’-гийн дэ д ангилал тогтоохгүйгээр тайлбарлана гэжээ. Хан Ён Үн (2007:330) мөн «үйл үг, тэмдэг нэрд залгадаг то», «нэрийн үгэ нд залгадаг то» гэх хэлбэрээр бичнэ гэж дурдсан.

11) Нарийн хэлбэл, Умардын туслах үйл үг ‘보조(적)동사’ нэр томьёоны хамрах хүрээ Өмнөдийн ‘보조동사’-гаас арай өргөн тул ялгаа бий. Дэлгэрэнгүйг Ким Бён Мүн, Жү Ён Хүнъ (2017:28)-ээс үзнэ үү.

г үгийн эх доторх тогтолцоо, ойлголт нь ялгаатай хоёр нэр томьёог зэрэг багтаах бараг боломжгүй, багтаалаа ч тайлбар хэт төвөгтэй, ойлгомжгүй болно. Хоёр талын хэл зүйн тогтолцог хоёуланг нь хүндэтгэх үндсэн зарчмыг зөвшөөрсөн ч толь бүтээхэд бодитоор хэрэгжүүлэх нь нэн төвөгтэй.

Хоёр талын тохиролцоо бүрэн биш үед үүнийг шийдэх хоёр үндсэн арга бий. Нэгдүгээрт, хэл зүйн нэр томьёог аль болох цөөн хэрэглэж, ялгааг нь ил гаргахгүй байх; хоёрдугаарт, хоёр талын тольд аль хэдийн ижил буюу ойролцоо утгаар хэрэглэж буй нэр томьёог олж ашиглах юм.

Хэл зүйн нэр томьёог цөөрүүлэхийн тулд тогтсон нэршлийг өгүүлбэрээр(句, phrase) задлан тайлбарлаж болно. Ю Хён Гён (2021:14) '체언토'-гийн оронд '체언 뒤에 붙는 토', өөрөөр хэлбэл «нэрийн үгийн ард залгадаг то» гэх маягаар бичдэг гэж тайлбарласан. Энэ нь утгын тайлбарыг уртасгах сул талтай ч мэргэжлийн нэр томьёо цөөн хэрэглэснээр ойлгомжтой болгох давуу талтай. Олон нийтэд хэл зүйн нэр томьёо ихэвчлэн хэцүү санагддаг тул тэдгээрийг цөөлөх нь уншигчийн бэрхшээлийг багасгана.

Түүнчлэн хоёр талын тольд ижил буюу ойролцоо хэрэглэдэг нэр томьёо бий. '체언' (нэрийн үг), '용언' (хувьсах үг/үйл үг, тэмдэг нэр), '주어' (өгүүлэгдэхүүн), '의문사' (асуух үг) зэргийг хамтарсан хурлаар шууд хэлэлцээгүй ч Өмнөдийн《Солонгос утга зохиолын хэлний тайлбар толь》Умардын《Солонгос (Чосөнъ) хэлний их тайлбар толь》-д бараг ижил утгаар оруулжээ. Ийм нэр томьёог шинэ тольд мөн хэвээр нь ашиглаж болно.

Эдгээр аргыг эрхшээлт нэр үг '바'-гийн тайлбар эхэд хэрэглэвэл дараах байдалтай.

바[5] — [нэр үг] (бие даан хэрэглэгддэггүй)

① 《Үйл үг, тэмдэг нэрд залгадаг '-은', '-을' то-гийн дараа хэрэглэнэ.》Өмнө хэлсэн зүйл, тодорхой баримт, хэрэг явдал зэргийг заана. // 느낀∨바를 말하다. — Мэдэрсэн зүйлээ ярих. 다를∨바 없다. — Ялгаатай зүйл үгүй.

② 《Үйл үг, тэмдэг нэрд залгадаг '-을' то-гийн дараа хэрэглэнэ.》Өмнө хэлсэн үйлдлийг хийх арга, арга замыг заана. // 몸둘∨바를 모르다. — Биеэ яахаа мэдэхгүй байх.

③ 《'-은/-을∨바에는', '-은/-을∨바에야' хэлбэрээр хэрэглэнэ.》 Нэгэнт тийм болох, эсвэл тийм болмж, тохиолдол, нөхцөл байдлын утгыг илэрхийлнэ. // 도중에 그만둘∨바에는 시작하지 말았어야 했다. — Нэгэнт дундаас нь орхих байсан юм бол анхнаасаа эхлэхгүй байх байж.

④ 《Нэгдүгээр биеийн өгүүлэгдэхүүнтэй, '-는∨바이다' хэлбэрээр хэрэглэнэ.》Өөрийн байр суурийг батлан мэдэгдэхэд хэрэглэнэ. // 이에 우리의 뜻을 선포하는∨바이다. — Үүгээр бид өөрсдийн хүсэл зоригийг тунхаглаж байна.

Хэрэглэгдэхүүн 4. '바' үгийн толийн өгүүллийн түр жишээ

Өмнөдөд '바'-г эхршээлт нэр буюу бие даан хэрэглэгддэггүй нэр үг, Умардад бүрэн бус нэр үг гэж үздэг. Харин шинэ тольд эрхшээлт нэр үг гэж тусгахаар тохиролцсон тул үгийн аймгийг [명](의존), буюу [нэр үг](бие даан хэрэглэгддэггүй) гэж тэмдэглэжээ.

Дараагийн 《 》 давхар өнцөгт хаалттай хэсэгт хэл зүйн нөхцөл, орчныг бичнэ. ‘용언’ (үйл үг, тэмдэг нэр), ‘1인칭’ (нэгдүгээр бие), ‘주어’ (өгүүлэгдэхүүн) нь хоёр талд нийтлэг хэрэглэдэг нэр томьёо тул хэвээр нь авна. Өмнөдийн ‘어미 өми’ нэршлийг хэрэглэхгүй, харин тохиролцооны дагуу ‘토 то’ гэж бичнэ.

Үүний дараа утгын тайлбар орно. Хоёр талын толь, хэлний хөмрөг дэх хэрэглээний жишээг хамтад нь ашиглан аль болох сайн тайлбар бичихийн зэрэгцээ хоёр талд өөрөөр хэрэглэдэг хэл зүйн нэр томьёоноос зайлсхийх хэрэгтэй. Харин ② утгад орсон ‘방법, 방도’ буюу «арга, арга зам» гэсэн үгс хоёр талын тольд хоёуланд нь бий.[12] Хоёр тал өмнө нь ижил буюу төстэй үгээр тайлбарласан бол шинэ толийн эхийг бичихэд ихээхэн дөхөм болно. Мэдээж ийм нийтлэг зүйл үргэлж амархан олдохгүй.

Хэл зүйн бүтээврийг ч мөн ийм аргаар тусгаж болно. Жишээлбэл, ‘(-)를 зтя’-ийн өгүүллийг дараах байдлаар бичиж болно.

-를 — [то]

① 《Үеийн адаг гийгүүлэгчгүй нэрийн үгийн ард залгана.》Өмнөх үг нь үйлдлийн шууд нөлөөг хүлээх зүйл болохыг заана. // 밥을 먹다. — Хоол идэх.

② 《Үеийн адаг гийгүүлэгчгүй нэрийн үгийн ард залгана.》Өмнөх үг нь үйлдлийн дам нөлөөг хүлээх зүйл болохыг заана. // 이 꽃은 너를 주려고 샀다. — Энэ цэцгийг чамд өгөхөөр авсан.

③ 《Үеийн адаг гийгүүлэгчгүй нэрийн үгийн ард, ‘가다’ (явах), ‘걷다’ (алхах), ‘뛰다’ (гүйх) зэрэгтэй хамт хэрэглэнэ.》 Өмнөх үг нь үйлдэл болох газрыг зааж буйг илэрхийлнэ. // 종일 거리를 걷다. — Өдөржин гудамжаар алхах.

④ 《Үйл хөдлөлийг заасан, үеийн адаг гийгүүлэгчгүй нэрийн үгийн ард залгаж, голдуу ‘가다’ (явах), ‘오다’ (ирэх) зэрэгтэй хамт хэрэглэнэ.》 Өмнөх үг нь үйлдлийн зорилго болсон үйлийг зааж буйг илэрхийлнэ. // 주말에 낚시를 가다. — Амралтын өдрөөр загасчлахаар явах.

⑤ 《Үеийн адаг гийгүүлэгчгүй нэрийн үгийн ард залгана.》 Өмнөх үг нь тодорхой үйлдэлтэй холбоотой цаг хугацаа, тоо хэмжээ, эсвэл үйлдлийн дарааллыг зааж буйг илэрхийлнэ. // 걸어서 삼십리를 오다. — Гучин ли газар алхаж ирэх.

…

⑩ 《Нэрийн үгийн ард залгадаг ‘-에, -으로’ то, үгсийг холбодог ‘-아, -게, -지, -고’ то болон үеийн адаг гийгүүлэгчгүй зарим дайвар үгийн ард залгана.》 Өмнөх үгэнд онцлох утга нэмнэ. // 일이 잘 되지를 않는다. — Ажил ер бүтэмжтэй болохгүй байна.

Хэрэглэгдэхүүн 5. ‘-를’ бүтээврийн толийн өгүүллийн түр жишээ

Өмнөдөд ‘를’-ийг ‘목적격 조사 зтя’, Умардад ‘-를’-ийг ‘대격토 тусагдахууны нөхцөл’ гэж ангилдаг. Шинэ тольд ‘조사 нэр үгийн нөхцөл’, ‘어미 үйл үгийн нөхцөл’-ийн оронд ‘토 то’ гэж тусгахаар то

12) Өмнөдийн тольд ‘바’-гийн ② утгыг «үйлийг гүйцэтгэх арга буюу арга зам», Умардын тольд «өмнө өгүүлсэн үйл хөдлөлийн арга, арга замыг заах үг» гэж тайлбарласан.

хиролцсон тул бие даан хэрэглэгддэггүй бүтээвэр гэж үзэж, толгой үгийн өмнө '-' тэмдэг та вина. Үгийн аймгийг [토] гэж тэмдэглэнэ.

Дараах 《 》 хаалттай хэсэгт '체언' (нэр үг/ нэрийн бүлэг), '받침' (үеийн адаг гийгүүлэгч) зэрэг хо ёр талд нийтлэг нэр томьёог хэвээр нь хэрэглэнэ. Харин ⑩-т '부사격 조사Байцын үүрэгтэй бол гох нөхцөл', '위격토Үйл болох газар, гарах эхийг заах нөхцөл', '조격토 Үйлийн хэрэгсэл, арга, чи глэлийг заах нөхцөл', мөн '연결어미Үйлийн холбох нөхцөл', '이음토Үйлийн холбох нөхцөл' гэсэн нэр томьёог хэрэглэх боломжгүй тул «нэр үгийн ард залгадаг то», «үгсийг холбодог то» гэсэ н хэллэгээр орлуулжээ. Утгын тайлбарт '목적격', '대격' гэсэн шууд тусагдахууны тийн ялгалын нэршлийг хэрэглэхгүй, оронд нь ойролцоо санаатай '대상' буюу «үйлдэлд өртөх зүйл» гэсэн үг хэрэглэнэ. Аз болоход хоёр талын толь '(-)를'-ийг тайлбарлахдаа энэ үгийг аль хэдийн адил хан хэрэглэсэн байдаг тул[13] 《Солонгос үндэстний хэлний их тайлбар толь》д ч ашиглаж болн о. Гэхдээ өмнөх толиудад ижил үг байлаа гээд үргэлж тэр хэвээр нь авна гэсэн үг биш.

Ийнхүү үгийн сангийн утгаас илүү хэл зүйн үүрэг нь чухал толгой үгсээр жишээлэн, хоёр тал ын хэл зүйн ялгаа ба тольд тусгах аргыг авч үзлээ. Шинэ толийн үндсэн зарчим нь ялгааг ал ь болох багасгаж, даван туулахын зэрэгцээ нийтлэг талыг нь сайн олж ашиглах явдал юм. Х эл зүйн салбарт хоёр талын ялгаа маш их тул толь бичиг бүтээхэд хүндрэлтэй, үр дүн нь дут агдалтай байж болно. Гэхдээ боломжит аргыг эрж хайсан туршлага, хүчин чармайлт байж г эмээнэ цаашид илүү сайн үр дүн хүлээх боломжтой.

4. Утгын ялгаа

4.1. Толийн утгын тайлбар

Өмнөд, Умардад нэг үгийг өөр өөр утгаар хэрэглэх тохиолдол бий. Улс төрийн үзэл суртлаа с үүдсэн ялгааг түгээмэл дурддаг. Үүнээс гадна хуваагдахаас ч өмнө нутгийн аялгууны түвш инд утгын ялгаатай байсан үгс, мөн удаан хугацаанд тусгаар амьдарсны улмаас өөр өөр утг аар хэрэглэх болсон үгс бий. Хэвлэл мэдээлэлд гардаг '오징어', '낙지 наймаалж'-ийн утга хоёр талд ялгаатай тухай яриа, эсвэл Умардад '오빠 убба' үгийн хэрэглээг хязгаарласан гэх мэдээ ч хоёр талын үгийн утгын ялгаатай холбоотой.

《Солонгос үндэстний хэлний их тайлбар толь》 нь хэлний нэгдмэл байдлыг хангахыг зорих ын зэрэгцээ хоёр талын хэлний бодит байдлыг үнэн зөв тусгах ёстой. Хан Ён Үн (2007:332–333), Хон Жон Сөн (2012:154), Бён Ён Сү (2024:119) нарын өмнө тэмдэглэснээр, тус толийн у тгын тайлбарт улс төрийн үзэл сурталтай шууд холбоотой үнэлэмжийг аль болох ил гаргалг

13) Өмнөдийн тольд '를'-ийн ① утга нь «үйл хөдлөлийн нөлөө шууд тусах зүйлийг заах тийн ялгалын нөхцөл», Умардын тол ьд «үйл хөдлөл шууд нөлөөлөх зүйлийг заана» гэсэн тайлбартай.

үй, хэлний бодит баримтад үнэнч тайлбар хийхийг зорино. Харин улс төрийн үзэл сурталтай шууд холбоогүй хэсэгт ялгаа байвал түүнийг таньж, тайлбарт тусгахыг хичээнэ.
Улс төрийн үзэл сурталтай шууд холбоотой капитализм, коммунизм, жүчэ үзэл зэрэг үгс хэт эмзэг сэдэв тул энэ өгүүлэлд авч үзэхэд хүндрэлтэй. Харин дам холбоотой '천리마' чоллима үгийг жишээ болгон авч үзье. Хоёр талын толийн тайлбарыг 4-р хүснэгтэд үзүүлэв.

Солонгос утга зохиолын хэлний тайлбар толь	Солонгос (Чосөнъ) хэлний их тайлбар толь (2017)
천리마 (千里馬) [нэр үг] Өдөрт мянган ли давхиж чадахуйц сайн морь. ≒ 기마, 천리구, 천리총.	**천리마 (千里馬)** [нэр үг] Агуу удирдагч нөхөр Ким Ил Сон дараах сургаалыг айлджээ: «Угтаа ... (дунд хэсгийг орхив) ... хэрэглэж ирсэн билээ». («Ким Ил Соны бүрэн зохиол», 40-р боть, 343-р тал.) ① =천리룡마. ② «Социалист бүтээн байгуулалтыг маш өндөр хурдаар урагшлуулж буй солонгос ардтүмний хувьсгалч эрмэлзэл»-ийг бэлгэдэн нэрлэдэг байсан үг.

Хүснэгт 4. Хоёр талын толь дахь '천리마' үгийн тайлбар

Өмнөдийн тольд утгын салаа ялгаагүй, үндсэн нэг утгыг товч тайлбарласан. Харин Умардын толь улс төрийн удирдагчийн зааврыг эхэнд нь оруулж, дараа нь утгыг хоёр салган, бэлгэдлийн утгыг тусад нь тайлбарлажээ. Хэлний нэгдмэл байдлыг хангах үүднээс энэ хоёрыг нэгтгэн тайлбарлах амаргүй. Шинэ толийн зарчмын дагуу тайлбарыг засвал дараах байдлаар бичиж болно.

천리마 (千里馬) — [нэр үг]
① (Өдөрт мянган ли давхих морь гэсэн утгаар) маш хурдан, сайн морийг хэлнэ. [Ойролцоо] 천리준마.
② «Ажлыг маш өндөр хурдаар эрчимжүүлэн урагшлуулах үзэл санаа буюу хөдөлгөөн»-ийг Умардад нэрлэдэг үг. // 천리마 시대. — Чоллимагийн үе. 천리마의 기상. — Чхоллимагийн хийморь, тэмүүлэл.
Хэрэглэгдэхүүн 6. '천리마' үгийн толийн өгүүллийн түүр жишээ
6-р хэрэглэгдэхүүнд улс төрийн удирдагчийн зааврыг оруулаагүй. Энэ нь улс төрийн үзэл сурталтай шууд холбоотой үнэлэмжийг ил гаргахгүй гэсэн зарчимд нийцнэ. Харин утгыг хоёр салгаж, хоёр дахь утгад Умардын онцлогийг тусган «Умардад нэрлэдэг үг» гэж тайлбарлажээ. Ингэснээр хоёр талын хэлний бодит байдлыг тусгахыг зорьсон. Тус толь хоёр талын аль нэгэнд хэрэглэгдэж, нийгмийн онцлогийг тусгасан нэгжүүдийг «...-ийг Өмнөдөд/Умардад нэ

рлэдэг үг» гэж тайлбарлахаар тогтсон.[14)]

Улс төрийн үзэл сурталтай холбоогүй утгын ялгаа ч бий. Ийм тохиолдолд «...-ийг Өмнөдөд/У мардад нэрлэдэг үг» гэсэн хэллэг хэрэглэхгүй, харин тусдаа утга болгон ялган тайлбарлана. Ялгаа нь нарийн эсвэл төвөгтэйгээс үндсэн тайлбарт багтаахад хэцүү бол доор нь нэмэлт та йлбар оруулахаар шийджээ. Үүний жишээ болгон '융화'юнхва гэдэг үгийг авч үзье. Хоёр талы н тайлбарыг 5-р хүснэгтэд үзүүлэв.

Солонгос утга зохиолын хэлний тайлбар толь	Солонгос (Чосөнъ) хэлний их тайлбар толь (2017)
융화[4] (融和) [нэр үг] Харилцан зохицож, зөрчилгүй эв найртай бол ох.	**융화[1] (融和)** [нэр үг] ① Буруу зүйлд зарчимгүйгээр буулт хийх, эсв эл тийм үйл. ② Зөрчил, мөргөлдөөнгүй эвлэлдэх, эсвэл ти йм үйл.

Хүснэгт 5. Хоёр талын толь дахь '융화' үгийн тайлбар

Өмнөдийн тайлбар нь зөвхөн эерэг утгатай. Харин Умардынх хоёр утгатай бөгөөд сөрөг утга а эхэнд нь тавьжээ. Шинэ толийн зарчмын дагуу засаж бичвэл дараах байдалтай болно.

융화 (融和) — [нэр үг]

① Харилцан зохицож, зөрчил, мөргөлдөөнгүйгээр эвлэлдэх. // 간의 융화. — Ажилчин, ажил о лгогчийн хоорондын эв зохицол.

② Буруу зүйлийн талаар зарчимгүйгээр буулт хийх. // 추호의 타협이나 융화를 모르다. — Өчүүхэн т өдий ч буулт, эвлэрэл хийхгүй байх.

[Нэмэлт тайлбар] Зөрчилгүйгээр эв зохицолтой болох утгаар хоёр талд хоёуланд нь хэрэглэ нэ. Умардад буруу зүйлд зарчимгүйгээр буулт хийх утгаар ч хэрэглэдэг бол Өмнөдөд эерэг утгаар хэрэглэнэ.

Хэрэглэгдэхүүн 7. '융화' үгийн толийн өгүүллийн түр жишээ

7-р хэрэглэгдэхүүнд утгыг хоёр салгасан. Харин дарааллыг тогтоохдоо хоёр талд нийтлэг эе рэг утгыг эхэнд, Умардын онцлог утгыг ②-т оруулсан. Зөвхөн үндсэн тайлбараас хоёр талы н ялгааг бүрэн ойлгоход хэцүү тул нэмэлт тайлбараар ялгаатай хэрэглээг тодруулжээ.

Ийм тохиолдлыг тусгай тэмдэг буюу толийн хэрэглээний тэмдэглэгээгээр ч шийдэж болно.[15)]

---

14) Энэ талаар Хон Жон Сон (2012:150–151), Ким Бён Мүн, Жү Ён Хүнъ (2017:19), Бён Ён Сү (2024:130–131) нар танилцуулсан. 'Хуваагдсанаас хойш шинээр бий болсон', 'нийгэм, эдийн засаг, улс төр, соёл, эрдэм шинжилгээний онцлогийг тусгаса н' нэгжүүдэд ийм хэллэг хэрэглэнэ. Дээрхээс гадна '주민등록증' (Өмнөд, иргэний бүртгэлийн үнэмлэх), '고등중학교' (Умард, дунд сургуулийн нэг төрөл), '특별시' (хоёр тал, тусгай хот) зэрэг үгийг ийм аргаар тайлбарлана.

15) Эх газрын хятад болон Тайванийн хятад хэлийг хамтатган эмхэтгэсэн «兩岸現代漢語常用詞典», «兩岸常用詞典»-д зөвхөн эх г азарт хэрэглэдэг үг, утгыг '★', зөвхөн Тайваньд хэрэглэдгийг '▲'-аар тэмдэглэсэн. Хоёр дахь толийн тухай дэлгэрэнгү йг Юн Со Жон (2019)-өөс үзнэ үү.

2023 онд гарсан《Солонгос үндэстний хэлний бага тайлбар тольтой урьдчилан танилцах нь》(미리 만나는 겨레말작은사전)-д ② утгын дэргэд 북 гэсэн тэмдэг тавьсан. Ингэвэл ялгааг илүү тод, энгийнээр харуулах ч хоёр талын ялгааг хэт онцлох сөрөг нөлөө гарч болно.[16] Ю Хён Гён (2021:16, 18) хэрэглээний жишээгээр ялгааг ойлгуулах аргыг тайлбарласан байдаг. Харин энд 7-р хэрэглэгдэхүүний жишээнүүдийг орхисон. Толийн эцсийн хувилбарт тэмдэглэгээг ямар болгохыг энэ өгүүлэлд тодруулахгүй болно.

4.2. Ижил утгат үг, ойролцоо утгат үг, лавлах үг

Хоёр талд ижил утгыг огт өөр үгээр илэрхийлэх тохиолдол бий. Энэ ялгаа мэргэжлийн нэр томьёо, амьтан ургамлын нэрэнд илүү их, заримдаа өдөр тутмын үгэнд ч тохиолдоно. Иймээс ижил утгатай үгсийг олж, хооронд нь холбох нь хоёр талын харилцан ойлголцол, харилцаанд туслах ач холбогдолтой. Өмнөд, Умардын үгсийг хамтад нь багтаадаггүй уламжлалт толь хийх боломжгүй онцгой ажил ч мөн.

Хэл шинжлэлийн хатуу шалгуураар утга нь төгс адил үг байдаггүй гэж үзэх нь бий. Гэсэн ч толь зохиоход ижил утгат үгийг зөвшөөрдөг. Нарийн өнгө аясыг ялгахад бэрх мэргэжлийн үгсийн хувьд бүр ч тийм. Жишээлбэл, Өмнөдийн '에탄올'ethanol, '에틸알코올'ethyl alcohol хоёр нь хоёулаа C_2H_5OH томьёотой нэг нэгдлийг заана. Энэ хоёрын хооронд нарийн өнгө аясыг ялгахад ч бэрх. Этанол нь арай түгээмэл хэрэглэгддэг ч Этилийн спирт нь илт танил бус нэр биш. Мөн бараг бүх хам сэдэвт харилцан орлуулж болно. Иймхүү өгүүлэмж хэлбэрээр томьёолсон тайлбаруудын үнэн-худлын утга нь ижил, өнгө аяс ба хам сэдвийн ялгааг тогтооход бэрх бол наад зах нь тольд ижил утгат үг гэж үзэж болно.

Нөгөөтээгүүр Солонгос үндэстний хэлний их тайлбар толь нь хоёр талын хэлний нэгдмэл байдлыг хангахыг зорьдог тул адил утгатай Өмнөд, Умардын үгийг «ижил» гэхгүй, зөвхөн «ойролцоо» гэж үзвэл өөрөө асуудал үүсгэж болно. Жишээлбэл, сүлжээнд холбогдож нийтлэг мэдээлэл хадгалах, эсвэл өгөгдсөн удирдлагын ажиллагааг гүйцэтгэх компьютерыг Өмнөдөд '서버'сервер, Умардад яг адил зүйлийг '봉사기'бонсаги (奉仕機) гэж нэрлэнэ. Эдгээрийг ижил биш, зөвхөн ойролцоо утгатай гэж тольд үзүүлбэл уншигч хоёр төхөөрөмжийн үүрэг нь жаахан өөр юм байна гэж андуурах магадлалтай. Энэ нь хэлний бодит байдалтай зөрж, харилцан ойлголцолд ч тус болохгүй. Иймээс сервер, бонсаги-г ижил утгат үг гэж тусгах нь илүү зохистой.

Хоёр талын үгсийг ижил утгат үгийн холбоогоор нэгтгэсэн зарим жишээг 8-р хэрэглэгдэхүүнд үзүүлэв.

---

16) Хоёр талын зарим уншигч нөгөө талын онцлог үг хэллэгийг 'буруу' гэж илрүүлэх хэрэгсэл болгон ашиглаж, хориглох, буруутгах шалтаг болгох асуудал гарч болохыг бодолцох хэрэгтэй.

Үндсэн толгой үг	Ижил утгат үг
브로콜리 (англи broccoli) [нэр үг] Зэрлэг байцааг сайжруулан гаргасан ургам ал. Мөчир нь эгц ургаж, гол иш болон мөчри йн үзүүрт ногоон өнгийн цэцгийн нахиа шиг үү ургана. Гол төлөв бараан ногоон жижиг цэ цгийн бундууг нь иднэ. (Brassica oleracea var. botrytis) [Ижил үг] 설란화. солланхва	**설란화** солланхва (← хятад xilanhua/西蘭花) [нэр үг] =**브로콜리**.
인쇄기 хэвлэх машин(印刷機) [нэр үг] ①《Хэвлэл》Хэвлэмэл зүйл дарж гаргах маши н. Хэвлэх хавтангийн аргаар нь товгор, хавтга й, хонхор хэвлэлийн гэж ангилна. [Ижил үг] 프린터 принтер①. ②《 — компьютер》Компьютерын боловсруул алтын үр дүнг гаргаж, цаасан дээр хэвлэх төх өөрөмж. [Ижил үг] 프린터принтер②.	**프린터** (англи printer) [нэр үг] ①《Хэвлэл》=인쇄기хэвлэх машин①. ②《 — компьютер》=인쇄기хэвлэх машин②.
참대곰 [нэр үг] хулсны баавгай Хулсны төрлүүдийг үндсэн хоолоо болгодо г баавгай. Гадаад төрхөөр баавгайтай төстэ й. Нүүр, мөр, хүзүү, нурууны хэсгээрээ хөндл өн судалтай. Нүдний эргэн тойрон, чихний д отор тал, хөл нь хар, бусад хэсэг нь цагаан. (Ailuropoda melanoleucus) [Ижил] 대왕판다. 판다②.	**대왕판다** (大王 + англи panda) [нэр үг] Том панда =참대곰. 판다 (англи panda) [нэр үг] ① Гол төлөв өндөр уул, өндөрлөгт амьдардаг том панда ба улаан пандаг хамтатган нэрлэд эг үг. Баавгайтай төстэй зүйл, элбэнх нохойто й төстэй зүйл бий. ② =참대곰. Хулсны баавгай
포도알균 (葡萄–菌) [нэр үг]《Биологи》 Бөмбөлөг хэлбэрийн эсүүд нь усан үзмийн ба гц шиг бөөгнөрсөн нян. Байгаль болон хүний биед өргөн тархсан бөгөөд идээт үрэвсэл, хо олны хордлого, дунд чихний үрэвсэл зэрэг өв чин үүсгэнэ. [Ижил] 포도상구균. 포도상알균.	**포도상구균** (葡萄狀球菌) [нэр үг]《Биологи》 =포도알균. **포도상알균** (葡萄狀–菌) [нэр үг]《Биологи》 =포도알균.

Хэрэглэгдэхүүн 8. Ижил утгат үгийн холбоогоор холбосон Өмнөд, Умардын үгсийн түр жишээ

Брокли (Өмнөд), ‘Солланхва’ (Умард), мөн ‘Хэвлэх машин’ (хоёр тал), ‘Принтер’ (Өмнөд) нь 1:1 харьцаатай ижил утгат үгс юм. Харин Хулсны баавгай ‘참대곰’ (Умард) ба Том панда‘대왕판다’, ‘Панда’ (Өмнөд), мөн ‘Подоаль гюн포도알균’ (хоёр тал) ба подосан гүгюнь‘포도상구균’ (Өмнөд), подосан альгюн ‘포도상알균’ (Умард) нь 1:2 харьцаатай. Энд ‘Панда’ хоёр утгатай бөгөөд зөвхөн ② утга нь ижил утгат үгийн холбоонд хамаарна. Хоёр талын үгсийн энэ холбоо энгийн биш болох нь харагдана.

8-р хэрэглэгдэхүүний солланхва ‘설란화’, хулсны баавгай ‘참대곰’ зэрэг нь Өмнөдийн олон ний

тэд танил бус үгс. Эдгээрийг брокли, панда/том панда-тай ижил гэдгийг тодорхой хэлснээр харилцан ойлголцолд тусалж чадна. Харин ойролцоо утгат үг гэж үзүүлбэл арай өөр амьтан, ургамал гэж андуурахад хүргэнэ.

Тольд ижил утгат үгээс гадна ойролцоо утгат үг, лавлах үг гэж холбох тохиолдол бий. Тодорхой ялгаа байсаар атал ижил гэж үзвэл бас л буруу гэсэн шүүмжлэлд өртөнө. Хоёр талын үгсийг ойролцоо утгат болон лавлах үгийн холбоогоор тусгасан жишээг 9-р хэрэглэгдэхүүнд үзүүлэв.

Ойролцоо утгат ба лавлах үг	Холбоотой толгой үгс
모닥불 [нэр үг] түүдэг гал Хуурай өвс, хатсан мөчир, навчит түлээ зэрги йг цуглуулан шатаасан гал. // 모닥불을 지피다. — Түүдэг асаах. 모닥불을 쪼이다. — Түүдэгт дулаацах. [Ойролцоо] 우등불. Үдын бүл	**우등불** [нэр үг] үдын бүл Гол төлөв гадаа том модны хэсэг, түлээ зэрги йг овоолж асаасан гал. // 우등불을 피우다. — Том түүдэг асаах. [Ойролцоо] 모닥불. Модаг бүл
뚜꺼먹다 [үйл үг] (тусах) Ажил, сургууль, цуглаан зэрэгт хүндэтгэх шалтгаангүйгээр очихгүй байх. Гол төлөв яриад хэрэглэнэ. Эхийн ‘шалтгаан’ гэдэг үгийг гэж зэрэгцүүлжээ. // 학교를 뚜꺼먹다. — Сургуулиа таслах. [Лавлах] 땡땡이치다.	**땡땡이치다** [үйл үг] (эс тусах, тусах) «Хийх ажлаа хийхгүй, эсвэл хичээл зэрэгт суухгүй, дэмий зугаацах»-ыг этгээд хэллэгээр нэрлэдэг үг. // 수업시간에 땡땡이치다. — Хичээлийн цагаар хичээлээ таслан зугаацах. [Лавлах] 뚜꺼먹다.
사이짓기 [нэр үг]《Газар тариалан》 ① Нэг төрлийн таримал тарьсан мөр хооронд өөр таримал суулгаж ургуулах. ② Нэг таримлыг хураасны дараа дараагийн таримлын үрийг тарихаас өмнө хүнсний ногоо зэрэг тарьж ургуулах. [Лавлах] 대우². 머드레¹.	**대우²** [нэр үг]《Газар тариалан》 Арвай, улаан буудай, хоног будаа зэрэг тарьсан талбайд тэдгээрийн завсраар шар буурцаг, улаан шош зэрэг тарих. [Ойролцоо] 머드레¹. [Лавлах] 사이짓기. **머드레¹** [нэр үг]《Газар тариалан》 Үр тариа тарьсан мөр хооронд өөр таримал тарих үйл, эсвэл тийн тарьсан зүйл. // 머드레를 치다. — Мөр хооронд нь өөр таримал тарих. [Ойролцоо] 대우². [Лавлах] 사이짓기.
개막이 [нэр үг]《Загас агнуур》 Тэнгисийн түрлэг орж гардаг усан тохойд загасны шургааган хаалтыг жигүүр мэт хэлбэрээр хүрээлүүлж эсвэл хатган хашаалаад, дунд нь тор өлгөж, түрлэгээр орж ирсэн загасыг татралтаар барих арга, мөн түүнд хэрэглэдэг тор. Гол төлөв кефаль (숭어), жоги (조기), далайн алгана (농어), сам хорхой зэргийг барихад хэрэглэнэ. ‘개매기’ гэж ч нэрлэнэ. [Лавлах] 벌컬. 풀거리.	**벌컬** [нэр үг]《Загас агнуур》 Түрлэгээр орж ирсэн загас ус татрахад буцаж гарах замыг хааж барих арга, мөн түүнд хэрэглэдэг тор. Хэлбэр нь газрын тогтцоос хамаарч өөр. [Ойролцоо] 풀거리. [Лавлах] 개막이. **풀거리** [нэр үг]《Загас агнуур》 Ёроолд шон хатгаж тор, эсвэл бутны мөчрөөр сүлжсэн хаалт тогтоон, түрлэгээр орж ирсэн загасыг татралтаар барих тор. Гол төлөв жоги (조기) болон бусад загасыг барихад хэрэглэнэ. [Ойролцоо] 벌컬. [Лавлах] 개막이.

Хэрэглэгдэхүүн 9. Ойролцоо утгат болон лавлах үгийн холбоогоор холбосон Өмнөд, Умардын үгсийн түр жишээ

Түүдэг гал ‘모닥불 (модаг бүл)’ (хоёр тал), ‘우등불’ (үдын бүл) (Умард) нь ойролцоо утгат үгс. Өмн өдийн тольд ‘우등불үдын бүл’-ийг ‘모닥불 модаг бүл’-ийн хэм хэмжээний бус хэлбэр гэж үздэг т ул утга нь ижил мэт харагддаг. Харин Умардын тольд хоёр үгийн тайлбар бага зэрэг ялгаатай. 9-р хэрэглэгдэхүүнд тус тусад нь тайлбарлаж, ойролцоо утгат үгээр холбосон.

‘뚜꺼먹다 Түккомогдо’ (Умард), ‘땡땡이치다 Дэндэн-и чида’ (Өмнөд) нь лавлах үгийн холбоотой. Х ам сэдвийн хувьд төстэй тал их ч нэг нь тусах үйл үг, нөгөө нь тусах ба эс тусах аль аль үүргээ р хэрэглэгддэг хэл зүйн ялгаа бий. Түүнчлэн ярианы үг, этгээд үг гэсэн өнгө аясаар ялгаатай ту л ойролцоо утгат үгээс арай алс холбоотой лавлах үг гэж үзүүлэх нь зохистой.

‘사이짓기 Са-и жигги’ (Өмнөд)-гийн ① утга, ‘대우 Тэү’ (хоёр тал), ‘머드레 Модырэ’ (Умард) нь бүгд ойролцоо утгатай. Гэхдээ ‘사이짓기Са-и жигги’ дахиад нэг утгатай. Үгийн утгын хамрах хүрээг х аргалзан ‘대우Тэү’, ‘머드레Модырэ’-г хооронд нь ойролцоо утгат үгээр, ‘사이짓기Са-и жигги’-г тэд гээрийн лавлах үгээр холбож болно.

‘개막이 Кэмаги’ (Өмнөд), ‘벌컬 Болкол’, ‘풀거리 Пүлгори’ (Умард) ч мөн ойролцоо утгатай. Харин ‘개 막이Кэмаги’ нь Умардын ‘개매기 Кэмэги’-тэй зөвшөөрөгдсөн зэрэгцээ хэлбэрийн холбоотой. Өөр өөр хэлбэл, хоёр талын ялгаа хэлбэр, бичлэгийн түвшинд л байгаа тул Кэмаги, Кэмэги -г хамта д нь авч үзвэл илүү өргөн тархалттай үг гэж үзэж болно. Үүнийг харгалзан ‘벌컬Болкол’, ‘풀거리 П үлгори’-г хооронд нь илүү ойр утгатай, ‘개막이 Кэмаги’-г тэдгээрийн лавлах үг гэж тусгаж болно.

Ижил, ойролцоо утгат болон лавлах үгийн холбоог илүү нарийн тогтоохын тулд хоёр талын эр дэмтэд уулзаж, үнэн зөв мэдээлэл солилцох хэрэгтэй. Ялангуяа мэргэжлийн салбарын үгэнд э нэ нь чухал. Гэвч өнөөгийн харилцаа хүндрэлтэй тул уулзах боломжийг хүлээхэд бэрх байна. Б одит толь бүтээх ажилд түр хувилбар болгон хоёр талын хэлний толь, нэвтэрхий толь, олон төрлийн хэлний хөмрөгийг аль болох өргөн ашиглаж, хамгийн зохистой аргыг хайж байна.

5. Дүгнэлт

Хоёр талын хэлэнд багагүй ялгаа гарсныг бодитоор хүлээн зөвшөөрөхийн зэрэгцээ хэлний нэг дмэл байдлыг хангахыг зорьсон толь бүтээх нь хэцүү боловч үнэ цэнтэй ажил юм. Өмнөд, Ума рдын харилцаа таатай биш, бүх асуудлаар бүрэн тохиролцоогүй байгаа нь толь бүтээх бэрхшэ элийг нэмэгдүүлж байна. Гэсэн ч ажилд оролцож буй хүмүүс өнөө хүртэл хүрсэн тохиролцоо, тэдгээрт шингэсэн зарчим, үзэл санааг хадгалан, практик арга замыг эрж, нөхөн сайжруулсаа р ирэв.

《Солонгос үндэстний хэлний их тайлбар толь》-ийн бүх ажлыг 2028 оноос өмнө дуусгаж, үр дү нг нийтэд гаргахаар төлөвлөж байна. Гэхдээ толь гарсны дараа ч хоёр тал дахин уулзвал бүрэ н тохиролцоонд тулгуурлан улам сайжруулсан хэлний нэгдсэн толь хэвлэж болно. Энэ нь хамг ийн хүсүүштэй зам гэдгийг дахин онцолъё.

Ашигласан материал

«Солонгос үндэстний хэлний их тайлбар толь» бүтээх Өмнөд, Умард Солонгосын хамтарсан төслийн хороо. 2019а. «Өмнөд, Умардын үгийн утга, хэрэглээг нэг дор харьцуулах нь». Мэпсито.
«Солонгос үндэстний хэлний их тайлбар толь» бүтээх Өмнөд, Умард Солонгосын хамтарсан төслийн хороо. 2019б. «Өмнөд, Умардын толийн толгой үгийн бичлэгийн ялгааг нэг дор харьцуулах нь». Мэпсито.
«Солонгос үндэстний хэлний их тайлбар толь» бүтээх Өмнөд, Умард Солонгосын хамтарсан төслийн хороо. 2020. «Солонгос үндэстний хэлний их тайлбар тольтой урьдчилан танилцах нь». Тус хороо.
«Солонгос үндэстний хэлний их тайлбар толь» бүтээх Өмнөд, Умард Солонгосын хамтарсан төслийн хороо. 2023. «Солонгос үндэстний хэлний бага тайлбар тольтой урьдчилан танилцах нь». Тус хороо.
Ким Бён Мүн, Жү Ён Хүнъ (김병문·주영훈). 2017. «Өмнөд, Умардын хэлийг нэгтгэсэн солонгос хэлний толь д хэл шинжлэлийн нэр томьёог тусгах аргын судалгаа — Солонгос үндэстний хэлний их тайлбар толий н жишээгээр». «Солонгосын толь бичиг судлал» (한국사전학), № 29, 7–40-р тал.
Ким Жү Сон (김주성). 2020. «Солонгос хэлний бичлэгийн дүрмийн нийгэм хэл шинжлэлийн тайлбар». «Кёрэ хэл бичиг судлал» (겨레어문학), № 64, 169–190-р тал.
Бён Ён Сү (변영수). 2024. «Солонгос үндэстний хэлний их тайлбар толийн утгын тайлбарын онцлог — Солонгос утга зохиолын хэлний тайлбар толь, Солонгос (Чосөнъ) хэлний их тайлбар тольтой харьцуулах нь». «Кёрэ хэл бичиг судлал» (겨레어문학), № 73, 115–143-р тал.
Ю Хён Гён (유현경). 2021. «Өмнөд, Умардын хэлийг нэгтгэх толь болох Солонгос үндэстний хэлний их тайлбар толь». «Хэлний баримт ба үзэл баримтлал» (언어사실과 관점), № 53, 5–30-р тал.
Юн Со Жон (윤소정). 2019. «Эх газрын Хятад, Тайвань хоёр эргийн хамтарсан толь зохиосон туршлагын судалгаа — Хоёр эргийн түгээмэл үгийн толь ба Хоёр эргийн өдөр тутмын үгийн толийг голлон авч үзэх нь». «Солонгосын толь бичиг судлал» (한국사전학), № 33, 64–89-р тал.
Жон Чоль (정철). 2017. «Сүүлчийн толь зохиогчид». Сагежоль.
Хан Юн Үн (한용운). 2007. «Өмнөд, Умардын хэлний нэгдмэл байдлыг хангахыг зорьсон толь зохиох арга зам». «Солонгос судлал» (국학연구), № 10, 315–342-р тал.
Хон Юн Пё (홍윤표). 2007. «Солонгос үндэстний хэлний их тайлбар толийг зохиох чиглэл». «Солонгосын толь бичиг судлал» (한국사전학), № 9, 23–52-р тал.
Хон Жон Сөн (홍종선). 2012. «Солонгос үндэстний хэлний их тайлбар толийн онцлог ба зорилт». «Хангыл» (한글), № 295, 135–161-р тал.
Зян Лина (姜丽娜). 2022. «Хятад дахь солонгос хэлний үгийг салгаж бичих дүрмийн тухай — 2016 оны шинэ «Солонгос хэл бичгийн дүрмийн эмхэтгэл»-ийн өөрчлөлтийг голлон авч үзэх нь». «Солонгос, Хятадын хүмүүнлэгийн ухааны судалгаа» (한중인문학연구), № 74, 129–151-р тал.
BBC-ийн хятад хэлний цахим хуудас. https://www.bbc.com/zhongwen
The Interlinear Bible. 1906. The Interlinear Bible: The Authorised Version and the Revised Version, together with the marginal notes of both versions and central references. [Мөр зэрэгцүүлсэн Библи: хааны зарлига ар баталсан болон шинэчилсэн орчуулгууд, хоёр орчуулгын захын тайлбар ба төвийн эшлэлийн хамт.] London: Cambridge University Press. https://www.archive.org/details/interlinearbibl01unkngoog

---

Чой Сон Гйү

Солонгос үндэстний хэлний их тайлбар толь бүтээх Өмнөд, Умард Солонгосын хамтарсан төслийн хороонны толь зохиох ажлын ахлах мэргэжилтэн.「Өмнөд, Умардын солонгос хэлний түүх судлалын сүүлийн үеийн чиг хандлага ба түүнийг ойлгох нь — Умард Солонгосын 2010–2024 оны тогтмол хэвлэлд тулгуурлах нь」,「Үгийн нөхцөлтэй холбоотой хэллэгийн Өмнөд, Умардын ялгаа — Өмнөд Солонгос маягийн риа гэгддэг хэлбэрийг голлон авч үзэх нь」,「Солонгос, монгол, манж хэлний үйлдэхийн тийн ялгалын нөхцөлийн үүргийн харьцуулалт」 зэрэг бүтээлийн зохиогч.

Хэлэлцүүлэг 2

｢Өмнөд, Умардын хэлний ялгаа ба《Солонгос үндэстний хэлний их тайлбар толь》-д түүнийг тусгах арга｣ илтгэлийн хэлэлцүүлэг



Кан Бо Сөнъ Дэгү их сургууль

Чой Сон Гйү багшийн илтгэлийг анхааралтай уншлаа. Та《Солонгос үндэстний хэлний их тайлбар толь》нь Өмнөд, Умардын хэлний нэгдлийг зорьсон толь учраас хоёр талын хэлний ялгааг нэгтгэн зохицуулах ёстой гэсэн үндэслэлд тулгуурлан бичлэг, хэл зүй, утгын ялгааг тус тольд хэрхэн тусгаж байгаа, тохиролцоонд хүрээгүй асуудлыг хэрхэн шийдвэрлэж болох, цаашид ямар ажил үлдээд байгааг дэлгэрэнгүй авч үзжээ. Үүний ачаар《Солонгос үндэстний хэлний их тайлбар толь》-ийг зохиох ажлын өнөөгийн байдал болон цаашдын зорилтыг ойлгоход их хээхэн дөхөм боллоо. Илтгэлийг уншихад дэлгэрүүлэн сонсохыг хүссэн зүйлсээ болон тус толь хэвлэгдсэний дараах зорилтын талаар асууж, хэлэлцүүлэгчийн үүргээ гүйцэтгэхийг хүслээ.

1. Үгийн эхний авианы дүрэм, нийлмэл үгийн заагийн ㅅ(с)-ийн бичлэгийг тохиролцох бэлтгэл

Таны илтгэлд дурдсанчлан Өмнөд, Умардын тохиролцоонд хүрээгүй бичлэгийн гол асуудалд үгийн эхний авианы дүрэм болон нийлмэл үгийн заагийн ㅅ(с) хамаарна. Энэ хоёр дүрэм хоёр талын хэл бичгийн хэм хэмжээнд бэлгэдлийн хувьд ямар байр суурь эзэлдэг, хэр нөлөө тэйг бодолцвол аль алиных нь талаар тохиролцоход амаргүй байх болов уу.《Солонгос үндэстний хэлний их тайлбар толь》-ийг зохиох явцад ч энэ асуудлыг нэлээд эргэцүүлэн хэлэлцс

эн гэж ойлгож байна. Цаашид Өмнөд, Умардын хамтарсан хурал сэргэвэл энэ хоёр дүрмийн талаар зайлшгүй тохиролцох шаардлагатай болно. Өмнөх хамтарсан хурлуудаар тохиролцо онд хүрч ирсэн туршлагад тулгуурлавал, амжилттай тохиролцохын тулд Өмнөд, Умард тус т усдаа урьдчилан юу бэлтгэж болох вэ? Тухайлбал, уг хоёр дүрэмтэй холбоотой бичлэгийн б одит хэрэглээг хоёр талд судлах, бичлэгийг өөрчилбөл гарах нөлөөллийг тогтоох, ийм өөрч лөлтийн талаарх мэргэжилтнүүд болон хэл хэрэглэгчдийн ойлголт, хандлагыг судлах зэрэг а жил хийвэл тохиролцох явцад үр дүнтэй хэлэлцүүлэг өрнүүлэхэд тустай биш үү? Ийм судалг аанууд бодитой тус болох эсэх, мөн тохиролцооны өмнө өөр ямар ажил хийх шаардлагатай талаар тайлбарлаж өгнө үү.

2. Тохиролцоонд хүрээгүй бичлэгийг тольд тусгах арга

내몽골 학자 세첸바타르(Сэцэнбаатар)는 「몽골어 방언학 서론」이라는 저서 "언어와 방언의 차이" 부분에서 다음과 같은 몇 가지 근거를 들어 설명하고 있습니다. 즉 어떤 언어 내 방언은 다른 방언들과 병존하며, 단일 방언만 있는 언어는 없습니다. 한 언어 안에 있는 방언들의 기본 어휘와 문법 구조는 기본적으로 같습니다. 그러나 단지 어휘와 문법의 크고 작은 차이만으로 문제를 완전히 밝힐 수 없습니다. 또한 언어들 사이에 과도기적 성격의 요소가 있는지 여부, 정치 구조와 소속, 문자와 문어, 단일 민족 여부 등도 문제를 해결하는 중요한 요인이지만 역시 완전히 판가름하기는 어렵습니다. 따라서 이러한 조건들을 개별적이 아니라 종합적으로 고려한 바탕 위에서, 첫째 해당 언어와 방언 자체의 특징에 기초하고, 둘째 해당 언어와 방언 화자들의 의식에 기초하여 독립 언어와 방언의 차이를 밝힐 수 있을 것입니다. 언어와 방언 자체의 특징이라는 것은 1. 통일된 한 언어 내부 언어일 것, 2. 일정한 지역적 분포를 가질 것, 3. 해당 언어의 공통적 특징을 유지하면서도 적정 수준의 고유한 특징을 가질 것, 4. 음성학, 문법, 어휘, 의미론적 체계성을 가질 것 등 기본 특징을 검토하며, 공동의 내적 발전 법칙에 종속되는지 여부를 중요시합니다. 서로 다른 지역의 사람들이 자신을 정말 어떻게 보는가 하는 의식이 언어와 방언의 차이를 명확히 하는 데 중요하게 작용합니다.(세첸바타르, 2005)

과학원 원사 투무르토고(Д. Төмөртогоо)는 "서로 다른 나라에 거주하고 있는 같은 언어의 방언 화자들이 각각 별도의 문어를 갖고 있다면, 그것들을 독립 언어로 간주한다는 원칙이 국제적으로 통용되고 있다. 그 원칙을 고수한다면 상술한 세 나라에 소속되어 있는 오이라트인과 부랴트인들은 서로 다른 문어를 갖고 있어서, 오이라트어와 부랴트어는 각각 독립 언어라고 해야 맞다"(투무르토고, 2017)라고 원칙을 제시했습니다.

사실 내몽골, 부랴트몽골, 칼미크 몽골인들이 사용하는 언어를 기원과 역사적 경로 등의 측면에서 보면 몽골어 방언이 맞습니다. 그러나 오늘날 국경 건너 다른 나라에 거주하고 있는 상황, 자신의 문학적 기반과 기준 방언이 있고, 그에 따른 정서법, 발음, 작문 규범이 있으며, 자체적인 언론 매체가 있다는 점 등을 고려하면, 지역 방언과 독립 언어라는 이중적 성격을 갖고 있다고 할 수 있습니다. 그러나 향후 몽골어의 광범위한 틀 안에서 종합적인 연구를 수행하기 위해서는 몽골어의 현황, 발전 방향, 각지 몽골인들 구어의 구체적인 차이를 비교 연구할 어떤 분류에 의존해야 할 필연적인 요구에 직면해 있습니다.

러시아연방의 부랴트 공화국과 칼미크 공화국 및 기타 지역에 분산 거주하는 사람들이 사용하는 언어는 러시아어 영향을 크게 받아 혼합어 성격을 갖는 독립적 부랴트어와 칼미크어가 되었습니다. 이에 반해 몽골국 서부 여러 아이막(도)에 거주하는 오이라트인들과 북동부 아이막에 거주하는 부랴트인들이 해당 아이막과 솜(군)에서 사용하는 구어는 오이라트어와 부랴트어로서 자신들의 특징을 유지하고 있지만, 할하 방언을 기반으로 한 몽골 문학어의 정서법과 문체 규범을 가진 문어에 종속되어 있고, 구어 역시 일정 정도 균일화되어 있어 몽골어 방언이라 할 수 있을 것입니다.

내몽골 자치구와 신장위구르자치구 거주자들은 자신을 몽골어 언중(言衆)이라 생각하고, 기준 음성인 차하르 구어 방언은 할하 방언과 비교적 가깝습니다. 그러나 그들은 부랴트 공화국, 칼미크 공화국과 마찬가지로 자기 나라 국경 내에 있고, 전통 몽골 문자에 기반한 문어가 있고, 그것은 자체적인 정서법, 발음, 작문 규범을 갖춘 기준 방언이 있으며, 그 안에 또 지역 방언들, 그 안에 다시 구어와 하위 구어 방언들이 있습니다. 몽골어 사용자 수를 살펴보면 차하르 구어 방언 화자는 현재 약 46만 명으로 내몽골인의 10.78%를 차지하고 있습니다. 반면에 호르친 구어 방언 화자는 약 208만 명으로 단독으로 48.77%를 차지합니다.(나머지 40.45%는 오르도스, 알샤, 바린, 하르친 구어 방언 화자) 호르친 구어 방언은 어휘 외에도 문법과 음운 차원에서 중국어 영향을 강하게 받아 몽골국 몽골인들이 그들의 일상적 구어를 이해하기가 점점 어려워지고 있습니다. 이와 같이 그들은 이중언어 구사자에서 혼합어 구사자로 점차 그 성격이 변모하여 부랴트어, 칼미크어와 마찬가지로 독립 언어로 발전하고 있음을 인정해야 할 것입니다. 다만 본인은 용어 측면에서 과학원 원사 투무르토고가 몽골국 남쪽의 지리적 위치에 따라 "남부 몽골어"라고 명명한 것에 동의합니다.

또한 이 논문에 나열된 단어 중 일부가 부랴트어로 어떻게 발음되는지 제가 아는 범위 내에서 적어 보았습니다. 내용은 다음과 같습니다.

몽골어	부랴트어	한국어
усанд орох	душьд орох	샤워하다
байшин	гэр	건물, 집
номын шүүгээ	шкаф	책장, 옷장
зуслан	зуһаал	여름 별장
дээл	дэгэл	델, 전통 옷
хашаа	хороо	울타리
намхан	набтар	낮다
алс хол	аяар хол	멀다
хариулах	һөөргөө хэлэх	대답하다
хууч хөөрөх	зугаалах, хөөрөлдөх	옛 이야기하다, 수다 떨다
царай	шарай	얼굴
бид нар	маандууд	우리들
дуусах	дүүрэх	끝나다
сонирхолтой	һонин	흥미롭다
амархан	дүтэрхий	쉽다
анх удаа	түрүүшийн удаа	첫 번째
хоолонд орох	эдеэлэх	식사하다
нэг дэх өдөр	нэгти үдэр	월요일
хоёр дахь өдөр	хоёрти үдэр	화요일
гурав дахь өдөр	гуравти үдэр	수요일
дөрөв дэх өдөр	дүрэвти үдэр	목요일
тав дахь өдөр	тавти үдэр	금요일
утсаар ярих	хонходох	전화 통화하다
завтай	сүлөөтэй	한가하다
ер нь	ерөйдоо	대체로
буйдан	диван	소파
тэтгэвэрт гарах	пенсэд гарах	은퇴하다
боломжийн	бараг	적당하다, 괜찮다

게렐트-오딘 바트자야

몽골과학원 언어문학연구소 언어학 분과 연구원. 『몽골어와 방언의 명사 및 동사 어미의 비교 연구』, 『몽골어 지역 방언 연구』(공저), 「지역 방언 · 구어 방언 · 하위 구어 방언·중간 구어 방언이라는 용어의 확립」 등 집필.

겨레말큰사전 몽골국립대학 국제학술포럼

갈라진 언어, 이어지는 숨결

Солонгос үндэстний хэлний их тайлбар толь ·Монгол Улсын
Их Сургууль Олон улсын эрдэм шинжилгээний форум

Хэлний хуваагдал ба оршин тогтнохуй

Хоёрдугаар салбар хурал

Монгол хэлний ертөнц

Чиглүүлэгч

Очиртогоогийн Шинэбаяр

Монгол Улсын Шинжлэх ухааны академи

Илтгэл 3

Орчин үеийн монгол хэлний аялгууны үгийн сангийн ялгаа(Халх болон өвөр нутгийн аялгууны[1)] жишээн дээр)



Гөрөөчингийн Гэрэлмаа Шинжлэх Ухааны Академи

Түлхүүр үг: шинэ үг, өвөрлөгч аялгуу, халх аялгуу, нэр томьёо хуулбар орчуулга

Монгол хэлний нутгийн аялгууг судалсан академич Ш.Лувсанвандан “Монгол хэл аялгууны у чир”(Уб.,1959) бүтээлд халх болон өвөр нутгийн аялгууг нутаг орны байдлаар нь ялгалгүй Төв аялгуунд халх, цахар, ордос аялгууг багтаасан нь санамсаргүй хэрэг биш бөгөөд эдгээр аялгуу нь авиа зүй болон үгийн сангийн хувьд ялгаа багатайг тэмдэглэсэн бол Дорнод аялгуунд багтаасан харчин, хорчины аман аялгууг халх аялгуунаас нэлээд ялгаатайг тэмдэглэсэн. Үүгээр монгол хэлний нутгийн аялгуу бүр авиа зүй, хэл зүй, үгийн сангийн үүднээс адил төстэй биш, түүнд хөрш зэргэлдээ орших өөр хэл аялгууны нөлөө тусдаг гэдгийг харуулж байгаа юм. Иймээс бид орчин үед монгол хэлний халх аялгуу болон өвөр нутгийн аялгуунд шинэ үг, нэр томьёо ямар арга замаар үүсэж, үгийн санд нөлөөлж ямар ялгаа гарч байгааг судлан үзэхийг зорив.

Энэхүү судалгааны үндсэн хэрэглэгдэхүүн болгож өөрийн хамтран зохиосон “Хятад монгол шинэ үгсийн тайлбар толь”[2)] -ийг авав. Уг толийн анхны хэвлэлийг Сүмбэрбат эрхлэн найруулсан бөгөөд 2007 онд БНХАУ-ын Шинхуа хэвлэлийн газар хэвлэсэн. Толь бичигт 1978-2004 хүртэлх шинэ үгийг багтаасан байдаг бол Сүмбэрбат, Хастуяа бидний нэмэн боловсруулсан хоёрдугаар хэвлэлд 1978-2018 оны хооронд буюу сүүлийн 40 жилийн дотор БНХАУ-д гарса

1) Монгол хэл судлал.I боть.(Уб., 2022,)-д Монгол хэлний бүлэгт Халх аялгуу болон өвөр нутгийн аялгуу гэж тэмдэглэсэн тул ийнхүү авав. х.55-59.

2) Хавсралт N1. Хятад монгол шинэ үгийн тайлбар толь.

н эдийн засаг, нийгэм, соёлын амьдралын өөрчлөлт хувиралтыг тусган шинээр үүссэн үгс, т үүнчлэн орчин цагийн шинжлэх ухаан, технологийн салбарын нэр томьёог багтааж, тэдгээр ийг монгол хэлнээ хөрвүүлсэн тайлбартай толь юм. Энэ толь бичиг нь хятад үгээр толгойлж, монгол бичгээр тайлбарлаж мөн оноолт хийсэн, түүнийгээ монгол утга зохиолын хэлний су урь халх аялгуугаар оноолт давхар хийсэн хоёр хэл, гурван бичиг үсгээрх толь бичиг юм. Т олийн ажил 2014 оноос эхэлж 2020 хүртэл үргэлжилсэн. Толийг зохиож эхлэхэд өвөр монг олын үг хэллэгийг шууд монгол бичгээс кирилл бичигт хөрвүүлэхэд монгол хэлээр боловч б идний ойлгохгүй үг хэллэг, нэр томьёо олонтоо гарч эхэлсэн. Тиймээс бид толийн арга зүйг ээ өөрчлөн өвөрлөгч болон халх аялгууны энэхүү ялгааг тусгахаар шийдэж Өвөр монголд х эвлэгдсэн Норжин нарын "Монгол хэлний толь" (Хөх хот.,1999), монгол хэлний тайлбар толи йн mongoltoli.mn цахим толь бичиг болон бусад хоёр хэлний толь бичиг, гарлын толь зэргийг ашиглан шинэ үг, нэр томьёог дүйцүүлэн зохиосон билээ.

Монгол утга зохиолын хэлний аялгуу болоод өвөрлөгч аялгууны үгийн сангийн ялгаа зөрүүн ий талаар цөөнгүй бүтээл байдгаас дээр дурдсан толь бичгийн найруулагч Сүмбэрбат "Мон гол хэлний үгсийн сангийн хөгжлийн асуудалд"[3] бүтээлээрээ шинэ үгсийг аль салбарт хама арахаар нь бүлэг болгон хувааж уламжлалт монгол үг хэрэглэх, оновчтой орчуулах талаар х арьцуулан өөрийн саналаа тусгасан болно.

Дэлхий дахины хурдацтай технологи, нийгэм, эдийн засгийн хөгжлийг хамгийн түрүүнд нэв трүүлдэг хэлний салбар бол үгийн сан, түүний дотроос шинэ үг, нэр томьёо анхдагч зөөвөрл өгч нь гэж үзэж болно.

Шинэ үгийн талаарх судлаачид "Шинэ үг хэмээх нь аливаа хэлний үгийн сангийн үүсвэр бүр элдэхүүний нэг бөгөөд улс нийгмийн аж ахуй, соёл боловсрол, үйлдвэр, техник шинжлэх уха аны хөгжилт нь шинэ шинэ утга, санаа, эд юмыг буй болгож, улмаар үүнийг нэрлэх шинэ үги йг үүсдэг[4]. Шинэ үгийн үүсэх шалтгаан нөхцөлийн тухайд "Нийгмийн хөгжлийн тодорхой заа г болсон цаг үеэс өмнө хэрэглэж байгаагүй шинээр үүсэж хэрэглэгдэх болсон үгийг шинэ үг гэнэ"[5] гэх буюу "Аливаа юм үзэгдэл шинээр бий болсныг тэмдэглэсэн үг хэллэгийг шинэ үг х эллэг гээд нийгмийн хөгжлийн хурд харьцангуй түргэн болж шинжлэх ухаан техникийн оло лт амжилт урьд урдынхаас их болж байгаа өнөө үед шинэ үг хэллэг олон гарч үүнтэй уялдан хэл найруулгад их орох болжээ"[6], "Ерийн үг биш шинэ үг болох нь тодорхой мэдэгдэж байгаа, хүмүүс харилцаандаа хэрэглэж хэвшээгүй, үгийн сангийн идэвхтэй нөөцөд ороогүй байгаа үгийг шинэ үг гэнэ»[7], "Хүмүүсийн амьдрал ахуй, соёл боловсрол, үйлдвэр, шинжлэх ухаан, те хник, улс төр эдийн засгийн амьдралд шинэ шинэ зүйл, мэдлэг ухаан бий болж түүнийг хэлэ

---

3) Ц.Сүмбэрбат. Монгол хэлний үгийн сангийн хөгжлийн асуудалд. Уб., 2007, х.230.

4) Төмөрцэрэн Ж., Монгол хэлний үгийн сангийн судлал, Уб., 2001, х.115.

5) Баатар. Монгол үгийн сангийн шинжилгээ, Хөх хот, 1988, х. 48-49.

6) Д.Отгонсүрэн Монгол хэлний үгийн сангийн найруулга зүй, Уб., 1998, х.119-120.

7) П.Бямбасан Монгол хэлний шинэ үгийн тухай. "УБДС-ийн ЭШЗАБ", Уб., 1971, №1 х.39.

нд тэмдэглэж илэрхийлэх хэрэгцээ шаардлагаас үүсгэсэн үг хэллэгийг хэлнэ"[8] гэх буюу "Со ёлын хөгжил, нийгмийн амьдралын өөрчлөлтөөс үүдсэн хэрэгцээ шаардлагыг хангахын тул д шинээр бүтээсэн үгийг шинэ үг гэнэ"[9] зэргээр тодорхойлсон нийтлэг хандлагатай байна.

Шинэ үг үүсэх нь хэлний өөрмөц үзэгдэл бөгөөд хэл болгонд түгээмэл шинжтэй юм. Үүнийг Оросын эрдэмтэн И.Г.Миловславский "Вопросы слово – образовательного синтеза" хэмээх бүтээлдээ шинэ үг үүсэх дараах хэд хэдэн онцлог байдгийг дурдсан байна. Үүнд:

Гадаад байдлын адил төстэй чанар: глазок (в двери) –хаалганы шагайвч, глазок (у картошки)-төмсний хадаас нь гадаад байдлаараа нүдтэй төстэй учраас адил нэртэй. Бодит байдал дээр үг чанар нь хоорондоо адилгүй.

Үүргийнх нь адил төстэй байдлаар: значок-пластинка (тэмдэг-хавтгай юм), мамка –кормилща (ээж-сүүгээр тэжээгч).

Гадаад байдал болон гүйцэтгэх үүргээрээ адил төстэй чанар: дорожка (магнитофона)-магнитофоны зам, пилка (для ногтей)- хумсны хуурай, корка (хлеба)- талхны хайрс, вилка (еды) -хоолны сэрээ[10] гэж ангилан судалжээ.

Шинэ үг болон нэр томьёоны бүтэх арга нь тухайн хэлний үг бүтэх зүй тогтлоор бий болдог. Үг зүйч Ц.Өнөрбаян "хэлний нэрлэх хэрэгцээг хангадаг үндсэн арга зам болох үг бүтэх ёс нь үг бүтэх арга дээр суурилсан үг бүтэх хэв маягуудын тогтолцоо мөн"[11] хэмээн үзээд монгол хэлний үг бүтэх тогтолцоог дараах загвараар тодорхойлсон. Анхны хэл зүй "Орчин цагийн монгол хэл" (Уб., 1966) болон үүнээс хойшид гарсан хэл зүйнүүдэд үг бүтэх аргыг тусгайлан авч бичсэн байдаг агаад ШУА-ийн Хэл зохиолын хүрээлэнгээс гаргасан "Орчин цагийн монгол хэл" (Уб., 1997)-д "... монгол хэлний үг бүтэх аргыг үг зүйн арга, үг зүйн бус арга гэж ерөн хийд нь хоёр ангилсан байдаг.

Шинэ үгийн багагүй хэсгийг нэр томьёо эзлэх бөгөөд түүнийг хэл шинжлэлийн толь бичиг, судалгааны бүтээлүүдэд "...мэргэжлийн хүрээн дэх ойлголтыг тэмдэглэсэн үг болон нийлэмж[12]", "... мэргэжлийн ухагдахууныг нарийн тодорхой, бүрэн дүүрэн илэрхийлэх үг болон нийлэмж үг"[13] мөн "Мэргэжлийн ухагдахууныг авианы буюу бичгийн хэлбэрээр илэрхийлэх, эсвэл зааглан тодорхойлох болзмол тэмдгийг нэр томёо гэнэ"[14] гэж тодорхойлсон.

Нэртомьёо бүтэх аргыг нарийвчлан судалж тусгай бүтээлээ туурвисан эрдэмтэн Г.Ц.Пюрбеев "Современная монгольская терминология" (М., 1984)-д түүний хэв шинжийг доорх хэдэн зүйлд хуваан үзжээ.

---

8) Ж.Баяансан, Ш.Одонтөр Хэл шинжлэлийн нэр томъёоны зүйлчилсэн тайлбар толь, Уб.,1995, х.192.

9) 张永言：《词汇学简论》，武汉：华中工学院出版社，1982年，第87页.

10) И.Г.Миловславский., "Вопросы слово – образовательного синтеза " М.,1980.,стр 51.

11) Ц.Өнөрбаян. Орчин цагийн монгол хэлний үгзүй, Уб., 1994, х.20.

12) Лингвистический энциклопедический словарь. М., 1990. Термин- слово или словосочетание обозначающее понятие с пециальной области знания или деятельности. стр.508,

13) Г.Ц.Пюрбеев. Современная монгольская терминология. М., 1984. Термин- это слово или словосочетание профессиональ ного употребления обладающее достаточной информативностью и точностью в передаче специальных понятии. стр.5.

14) 冯志伟：《现代术语学引论》，北京：语文出版社，1997年，第1页.

Үгзүйн аргаар нэр томьёо бүтэх
Үгзүй-өгүүлбэрзүйн аргаар нэр томьёо бүтэх /нийлмэл үг/
Өгүүлбэрзүйн аргаар нэр томьёо бүтэх
Эх сэдэв-утгазүйн аргаар нэр томьёо бүтэх
Хэлний бэлэн байгаа материалд суурилан нэр томьёо бүтэх
Үг товчлох нь нэр томьёо бүтэх нэг хэрэглүүр хэмээн үзжээ.
Эрдэмтэн П.Бямбасан 1971 онд нийтлүүлсэн "Монгол хэлний шинэ үгийн тухай" хэмээх өгүү лэлдээ шинэ үг бүтээх үндсэн 7 арга байна[15] хэмээсэн нь орчин цагийн монгол хэлний үгий н санг шинэ үгээр баяжуулах аргыг бүхэлд нь тусган харуулсан юм.
Шинэ үгийн нэг үүрэг нь үгийн санг баяжуулах бөгөөд энэ талаар эрдэмтэн Ж.Төмөрцэрэн с удалж, "Орчин цагийн монгол хэлний үг бүтээх механизм, түүний нэрийтгэл нэгжийг үүсгэн бүтээх үйл ажиллагаатай холбоотой юм" гэж үзээд шинэ үг бүтээх авиа зүйн, үг зүйн, өгүүлб эр зүй, үгийн сан-утга зүйн 4 үндсэн арга жишээгээр батлан харуулсан нь шинэ үг, нэр томь ёо бүтээх аргыг бүхэлд нь хамруулсан[16] бол шинэ үгийн хэрэглээний тухайд [17] гэх зэргээр су далжээ.
Шинэ үг болон нэр томьёо үүсэхэд хэлний болоод хэлний бус хүчин зүйл нөлөөлдөг нь халх аялгуунд өдгөө шинэ үг, нэр томьёог орос болоод англи хэлээр дамжуулан авч байгаа бол ө вөрлөгч аялгуунд хятад хэлээр дамжуулан авч байгаа хэлний ялгаатай байдал нөлөөлөхийн сацуу нийгэм, эдийн засгийн талаар ялгаатай байдал ч мөн тухайн хэл аялгуунд илэрч байна. Бид халх болоод өвөрлөгч аялгууны шинэ үг, нэр томьёогоор жишээлэн үгийн сангийн ялгаа тай болоод адилсах байдал хэрхэн үүссэн талаар тусгайлан судлахын тулд 10,000 гаруй үгт эй дээрх толиос 1000 үгийг үсэг тус бүр, он тус бүрээс түүвэрлэн ашигласан юм.
Халх болон өвөрлөгч аялгуу нь монгол хэлний аялгууд учир адил төстэйн зэрэгцээ хэлний б олон хэлний бус харилцан нөлөөллийн улмаас ялгаа бий болж байгаа нь маргаангүй. Иймээ с дараах үндсэн 2 төрөлд хуваан үзэж болно.

1. Халх болон өвөрлөгч аялгууны үгийн сангийн зөрөөтэй байдал

Илтгэлийн агуулгатайгаа нийцүүлэн халх аялгуу болон өвөрлөгч аялгууны үгсийн ялгарах ш инжийг талаар эхлэн авч үзье. Энэ ангилал хоорондоо харилцан ойлголцохгүй байгаа хоёр а ялгууны талаарх судалгаа биш бөгөөд газар нутаг, хил хязгаар, бусад үндэстэнтэй хөрш зэрг элдээ оршин суух, соёлын нөлөөллөөс шалтгаалан үгийн санд үүсэж буй онцлогийн талаар өгүүлэх юм.

---

15) П.Бямбасан., "Монгол хэлний шинэ үгийн тухай" УБДС-ийн ЭШЗАБ.Уб.,1997,№1.,39х.
16) Ж.Төмөрцэрэн. Монгол хэлний үгийн сан баяжиж байгаа нь. -ОУМЭ-ийн Y их хурал.Уб.,1992, х.110-112.
17) Н.Нансалмаа. Үгийн сан судлал.Уб., 2005, х.120.

1.1.Хуулбар орчуулгаас шалтгаалсан утгын ялгаа

Хятад хэлнээс шууд хуулбарлан орчуулсны үр дүнд үүссэн өвөрлөгч аялгууны шинэ үг, нэр томьёо нь халх аялгуутай утгын талаар огт тохирохгүй байсан ""Хятад монгол шинэ үгсийн тайлбар толь"-д дүйлгэн орчуулсан. Тухайлбал:

а.石油 Чулуун тосыг гадаадад гаргах улсуудын холбоо-ОПЕК (бензин) гэхэд өвөрлөгч аялгуунд "чулуу, тос"-ыг нийлүүлэн "чулуун тос" гэсэн бол халх аялгуунд "бензин мөн шатахуун" гэж хоёр янзаар хэрэглэж байна. Энэ хоёр аялгуунд дээрх үгийг хоёр өөр хэлний сурвалжаас авч буй нь өмнө нь энэ ойлголт байгаагүйтэй холбоотой.

框架 бор төлөв- бүдүүвч (228х) хэм хэмжээ, шүүгээ тавиур гэхэд хятад хэлнээс орчуулсан.

拍戏 ший жүжиг сүүдэрлэх-бичлэг хийх гэх мэт. Хятад хэлний ший гэдгийг авч "ший жүжиг сүүдэрлэх" гэсэн хуучин маягийн оноолтыг өвөрлөгч аялгуунд бий болгосон бол халх аялгуунд "бичлэг хийх" хэмээн оноожээ.

粉领 fen ling ягаан заамтан- нарийн бичиг эмэгтэй (246х) гэхэд хятад улсад ажил мэргэжлээр нь ялган нэгдсэн хувцас өмсгөдөг тул "цагаан захтан"-албан тушаалтан, хөх захтан- ажилчин гэх мэтээр тэмдэглэдэг ойлголтыг шууд орчуулснаас энэ хэллэг үүсжээ. Халх аялгуунд "захтан" гэж хэлдэг бол өвөрлөгч аялгуунд "заам" гэдэг ойролцоо үгээр хэрэглэнэ.

б.Уг толинд халх аялгуунд огт байхгүй шинэ үг хэллэг цөөнгүй байгаа бөгөөд энэ нь мөн л хуулбар орчуулгаас үүдэлтэй.

БНХАУ-ын хэтийн төлөвлөгөө зорилттой холбоотой бодлого шийдвэр, журмыг нэрлэсэн тооны нэрээр томьёолсон шинэ үг хэллэг цөөнгүй байгааг монгол хэлнээ шууд хуулбарлахаас өөр замгүй байна. Жишээлбэл,

一带一路Нэг бүс нэг зам

四二一综合症 421 нийлэг гэм

四个全 面дөрвийг биелүүлэх- (чинээлэг нийгэм, өөрчлөлт, хуулиар засах, намыг цэгцлэх)

中央八项规定 төв хорооны найман тогтоол гэх зэргээр тооны нэрээр хэвшүүлсэн журам зарлиг цөөнгүй бөгөөд эдгээрийг орчуулбал утга нь өөрчлөгдөх тул шууд үг нэг бүрийг хуулан орчуулж авдаг юм. Үүнийг хуулбар орчуулга гэж нэрлэх агаад тухайн ойлголт ухагдахуун байхгүй тохиолдолд хэрэглэхийн сацуу энэ талаар судалсан эрдэмтэд үзэхдээ хэлбэр нь тухайн хэлнийх боловч агуулга нь харь хэлнийх байдаг гэсэн дүгнэлт хийдэг. Хятад соёлд 1, 2, 4, 8 -ийн тоог бэлгэддэг бөгөөд үүнийгээ нэр томьёог бүтээхэд хэрэглэж энэ ойлголтыг мэдэхийг тулд өвөрлөгч аялгуунд шууд хуулбарлан авсан хэрэг юм.

в. Хэлний хэв шинжийн адил бус байдлаас үүссэн хуулбар орчуулга нь өвөрлөгч болон халх аялгуунд үгийн сангийн ялгааг бий болгож байна. Хятад хэлний үет үсэг болгоныг өвөрлөгч аялгуунд хуулбарлан орчуулснаас

Бүх ардын чийрэгжүүлэлтийн төлөвлөгөөний хөтөлбөр-нийтийн биеийн тамирын хөтөлбөр (670х)

Нөхцөлгүйгээр хоёр хүүхэд төрүүлж болох бодлого-хоёр хүүхэдтэй байх бодлого (669х) бай гаа бол зэрэг нэрлэлт нь хэт урт, хэлний хэм хэмжээнд таарамжгүй үзэгдэл юм. Ийм хуулба р орчуулгын үр дүнд үүссэн шинэ үг 20% хувийг эзэлнэ.

1.2 Ойролцоо утгатай үгийн аль нэгийг сонгон хэрэглэсэн ялгаа

Халх аялгуу болон өвөрлөгч аялгуунд "үгийн сангийн утгаараа бүрэн буюу заримдаг нийлэх үгс"[18] эртнээс байсан бөгөөд тэдгээр нь харилцан ойлголцоход бэрхшээлтэй биш байдаг нь утгын холбоо ямагт байдагтай хамааралтай. Ийм үгс "Хятад монгол шинэ үгсийн тайлбар то ль"-д дараах байдалтай байна.

Өвөрлөгч аялгуу	Халх аялгуу
нисдэг багаж	нисэх төхөөрөмж
сансрын онгоц	сансрын хөлөг (150х)
ганцаар шийдэх	дангаараа шийдэх (288х)
цусны байцаалт	цусны шинжилгээ (395х)
жимсний ус	жимсний шүүс
гааль төлөгч	татвар төлөгч (278х)

гэх мэт шинэ үгэнд тохиолдож буй багаж төхөөрөмж, хөлөг онгоц, байцаалт шинжилгээ, ус шүүс, гааль татвар нь монгол хэлний үгийн сангийн хувьд ойролцоо хоршоо үг үүсгэх болом жтой хэдий ч салангид байхдаа үгийн сангийн ялгамжаа гаргаж байна. Тухайлбал, гааль бо лоод татвар гэдгийг авч үзвэл гааль хэмээх үгийн анхдагч утга нь "татвар, хураамж" (Нор жин, mongoltoli.mn) гэсэн хэлбэрээрээ байдаг боловч монгол хэлэнд энэ утга нь идэвхтэй х эрэглэгдэхгүй хуучирч орхигдсоноос зөвхөн "хил нэвтэрч буйг шалгах байгууллага" хэмээх утгаараа хэрэглэгдэнэ. Харин өвөрмонголчууд гааль гэдгийг «хураамж» гэсэн утгаар нь хэр эглэж байна.

Мөн «байцаалт» болон «шинжилгээ» хэмээх үгийн тухайд монгол хэлнээ «тухайн зүйлийг ня гтлахаар магадлан асуух» утгатай тул (mongoltoli.mn) «байцаалт өгөх, байцаалт авах» гэхчл эн шүүх, цагдаагийн ажилд хэрэглэж тогтсон нэр томьёо байдаг бол өвөр монголд байцаах хэмээх үгийг «биеийн байцаалт -эмнэлэгт үзүүлэх, цусны байцаалт-цусны шинжилгээ өгөх « гэх зэргээр хэрэглэн дадждээ. Энэ мэтээр ойролцоо утгатай үгээр оноосон байдал бидний ав сан 1000 шинэ үг, нэр томьёоны 36%-ийг эзэлнэ. Энэ нь нэгдүгээрт монгол хэлний аялгуу х

18) Монгол хэл судлал, Боть.Х,Үгийн сан-утга зүй. Уб., 2022, х.157

оорондын үгийн сан болон орчуулгаас үүдсэн шинжтэй байна.

1.3 хэллэгийн утгын ялгаа

Хэлц үгийн үүсэл нь үгийн сангийн утга ихэд шилжсэний үр дүн тухайн хэллэгийг үндсэн утг аар нь хялбар ойлгохгүй болсон хэлний нэгж юм. Нөгөө талаар хэлц бол тухайн үндэстний с этгэлгээний онцлогийг тусгасан өвөрмөц судлагдахуун. Өвөрлөгч аялгуу болоод халх аялгу уны зарим хэлц хэллэгийн утга тэр бүр таарахгүй байна. Өвөрлөгч аялгууны «дотор тамир» хэмээх хэлцийг халх аялгуунд «муу санаатай» гэж ойлгодог бол үндсэн утга нь «сэтгэлийн тэнхээ (280х)" гэсэн утга байх жишээтэй. Ойролцоо утгатай хэлцүүд өвөрлөгч аялгуунд "ар үүд нээх" хэмээх хэлц нь «арын хаалгадах» (танилаа ашиглаж илүү)-тай ойролцоо утга илтг эж буй бол "сагсны амсар оногч» гэдгээр «бөмбөг оруулдаггүй тамирчин (108х)» хэлдэг бол "хөх малгайт цэрэг" гэдгээр "НҮБ-ийн цэрэг (232х)"-ийг хэлж, мөн хятад хэлнээс шууд орчу улж авсан "уулнаас барыг буулгаж ирэх" гэдэг хэлцээр "улсын мөнгө хөрөнгө их хэмжээгээ р завшсан авилгачдыг барих" ажиллагааг тус тус хэлжээ. Толь бичигт хэлц үгээр шинэ үг үү сгэсэн жишээ 2%-ийг эзлэх бөгөөд утгын талаар яв цав таарахгүй байна.

1.4 Зүйрлэн нэрлэхээс үүдсэн утгын ялгаа

Аливаа хэлний зүйрлэн нэрлэх үзэгдэл бол тухайн үндэстний танин мэдэхүйн онцлог шинжэ эс хамааралтай. Тиймээс өвөрлөгч аялгууны бичгийн хэлэн дэх зарим зүйрлэлд хятад хэлни й зүйрлэл уг хэвээрээ нөлөөлжээ.

熊猫侠- малар өтөг мэт ховор цус хандивлагч-ховор цусны донор (955х) гэхэд маш ховор үн этэй зүйлийг малар өтөг буюу бидний ярианы хэлэнд хэрэглэж дадсанаар панда баавгайтай зүйрлэсэн байна. Угтаа энэ нэр томьёо бол баавгайтай огт хамаагүй маш ховор тохиолддог Rh бүлгийн цусны нэр юм.

Мөн Цагаан хэрэм хэмээх хятадын алдарт хэрэмтэй зүйрлэж орчин тойрноо ногооруулахыг 绿色臂垒 - ногоон бэхлэлт (536х) гэж өвөрлөгч аялгуунд орчуулжээ. Халх аялгуунд "ногоон х эрэм" гэнэ, "бэхлэлт" гэдэг нь дайны үеийн хамгаалалтыг заана.

Мөн 植物人- гэсэн нь ургамал шиг хүн өвөрлөгч аялгуунд ургамаллаг хүн (1063) гэсэн нэр том ьёо оноосон бөгөөд энэ нь тархи мэдрэлийн хүнд гэмтэл авч хөдөлгөөн хийж чадахаа больсо н хүнийг ургамалтай зүйрлэсэн хэллэг болно. Ийм ялгаатай зүйрлэл 3,5%-ийг эзэлж байна.

1.5 Дагаврын аргаар үүссэн шинэ үгийн утгын ялгаа

Залгамал бүтэцтэй монгол хэлний халх болон өвөр нутгийн аялгуунд дагаврын аргаар шинэ үг, нэр томьёо үүсэх нь үндсэн онцлог юм. Харин дагаврын аргаар үүссэн зарим үүсмэл үгий н утга харилцан адилгүй байна. Тухайлбал:

Өвөрлөгч аялгуу	Халх аялгуу
шагайгуур	хаалганы дуран (228х)
сансарчийн хувцас	сансрын нисгэгчийн өмсгөл 150
хүүхэнчир залуу	унжгар дорой залуу (278х)
үүрэглэх- үүрэг+л+х	үүрэг хүлээлгэх,
эрүүлжүүлэх- эрүүл+ж+үүл+х/	өвчингүй болох, чийрэгжих/
шалиг хэвлэгдэхүүн	шалиг завхай хэвлэл
мөр шилжүүлэх даравч	интер товч
Нуруувч үйлдэл	тулгуур

Өвөрлөгч аялгууны -чир, -ч дагавар монгол хэлэнд өнгөц харахад байхгүй мэт боловч -цар[4] дагаврын хувилбар шинжтэй бөгөөд бага жижгийн утга илтгэж гучинцар, зээнцэр гэ дэг үг бүтээхийн сацуу нэр томьёонд савханцар, хуванцар гэх мэтийн хувтай төстэй, савхтай ади л төстэй гэсэн утга илэрхийлдэг үг бүтээнэ. Үүнийг өвөрлөгч аялгуунд хүүхэнчир гэдэг үг үү сгэсэн нь «хүүхэн шиг, хүүхэнтэй төстэй» гэсэн утгаар хэрэглэжээ.

Монгол хэлний нэрээс нэр үг бүтээдэг -ч дагаврын талаар нь Л.Болд "Орчин цагийн монгол хэлний дагавар" бүтээлдээ Монгол хэлний -ч дагавар нь -чин дагаврын хувилбар агаад туха йн зүйлийг байнга болон түр эрхэлсэн хүний ажил мэргэжлийг заасан нэр үүсгэнэ гэж үзсэн агаад монгол хэлнээ сансар хэмээх язгуурт -ч дагавар залгаж үг бүтээсэн тохиолдол байхгү й байна.

Харин -вч дагавар бүхий даравч, нуруувч хэмээх үгийн тухайд энэ дагаврын бүтэц, утгын та лаар тусгайлан судалсан академич Л.Болд «гол төлөв бүрхэх хаах гэсэн утгатай шинэ үг үүс гэнэ»(1986:34) хэмээн үзсэн атал дардаг хэрэгсэл, тулах багаж мэтээр өвөрлөгч аялгуунд х эрэглэжээ. Үүнтэй төстэйгөөр үүссэн «эрүүл+ж+үүл+х- /өвчингүй болох, чийрэгжих/ гэсэн үг нь бүтэц, үүслийн талаар халх аялгуутай адил боловч илэрхийлэх утгын хувьд өвөрлөгч а ялгуунд өвчнөөс салгахыг хэлдэг бол монголын хэлэнд архины хороос салахыг хэлдэг байх жишээтэй, үүрэглэх- үүрэг+л+х -(үүрэг хүлээлгэх) хэмээх үүрэг хэмээх нэр үгэнд үйл үг бү тээх -л дагавар залгаж үүрэг хариуцлага хүлээлгэх утгатай үг үүсгэсэн нь монгол хэлэнд үүс ээгүй байна.

Мөн телевизийн суваг хайгч –телевизийн антенн (173х) гэсэн үгэнд орсон -гч дагавар нь «ту хайн үйлийг гүйцэтгэх машин эсвэл багаж хэрэгслийг заадаг» гэсэн нь утгын талаар өөр хоо рондоо таарч буй юм. Дагавар залгаж шинэ үг бүтээх тухайд шинээр үүссэн нийлмэл үгээс х арьцангуй бага байгаа нь ажиглагдаж байна. Бидний авсан 1000 жишээний 4% нь дагавар з алгаж шинэ үг бүтээсэн байгаа бөгөөд утга тохирохгүй нь 1,5 %-ийг эзэлнэ.

2. Халх болон өвөрлөгч аялгууны үгийн сангийн нэгдмэл байдал

Монгол хэлний хоёр аялгуу болох халх болон өвөрлөгч аялгуунд шинэ үг бүтээх дагаврын а рга, үг нийлэх арга, үгийн сан-утга зүйн арга нь хэвээр хадгалагдаж байна.

2.1. Үгийн сан болон хэлзүйн утгаараа бүрэн тохирох шинэ үг

Хоёр аялгуунд хятад болон англи хэлнээс дам авсан шинэ үгийг хөрвүүлэхдээ монгол хэлни й нийлмэл үг бүтээх арга хэлбэрээр шинэ үг үүсгэсэн нь үгийн сангийн болон хэлзүйн утгаар аа дүйцэж байна. Тухайлбал:

Өвөрлөгч аялгуу	Халх аялгуу
далайн осол	далайн осол
дурсгалын зоос	дурсгалын зоос (148х)
зочдыг татах	зочдыг татах(231х)
алтан гахай жилийн хүүхэд	алтан гахай жилийн хүүхэд
аядан дагах	аялдан дагах
аяны савх	аяны савх(107х)

гэх зэрэг жишээнээс орчуулга нь өвөрлөгч аялгуу халх аялгуутай яг тохирч буй агаад ийм т охиолдол 21%-ийг эзэлнэ. Хоёр үг нийлэн утгын талаар нэгдэж шинэ нэрлэлт үүсгэхийг ний лмэл үг хэмээн нэрлэдэг энэ арга дагаврын аргаас илүү бүтээлч байна.

2.2 Зарим гадаад үгийг зээлдэхэд үүссэн тохирч буй байдал

Шинэ үг хэллэг, нэр томьёоны дотор шинэ ойлголт ухагдахууныг нэрлэсэн эх хэлний бус үг х эллэг цөөнгүй тохиолддог онцлогтой. Иймээс Өвөрлөгч болон халх аялгууны аль алинд нь гадаад хэлнээс авсан үгс адилхан байх үзэгдэл байна. Тухайлбал:

Өвөрлөгч аялгуу	Халх аялгуу
нано материал	нано материал (277х)
караоке	караоке
Генийн инженеринг	Генийн инженерчлэл
гэхэд нийлмэл үгийг	бүхэлд нь авсан бол
картинг тэрэг	уралдааны машин
сток захын нээлт	үнэт цаасны захын нээлт
картон дүрст цахилгаан бараа	хүүхэлдэйн зурагт цахилгаан бараа (277х)
дэйта хөмрөг	цахим хөмрөг (372х)
дэйта холбоо	цахим холбоо
лазер бичиглүүр	лазер хэвлэгч
хурмал цахилгаан хэлхээт карт	цахилгаан карт

гэх зэргээр хоёр үгийн аль нэгийг нь орчуулсан буюу хагас зээлдмэл үг хэллэг цөөнгүй байна. Өвөрлөгч аялгууны шинэ үг хэллэгийн дотор англи хэлнээс шууд авсан картинг (carting) [анг л. carting] автомашины уралдаан зохион байгуулах тусгай талбай; картон(cartoon)-хүүхэлдэй н кино, лазер(laser) [ор. ла’зер < англ. laser-light amplification by stimulated emission of radiation ‘’ гэсэн үгийн товчлол]; ген (gen) [лат. genus ‘үүсэл, төрөл’] 1. биол. амьд организм нь үржих я вцдаа удамшуулан үлдээх мэдээллийг агуулсан материаллаг тээгч. 2. генет. ДНХ –ийн молек улын хэсэг; 3. ◊ зан авирын удамшсан онцлог; инженеринг (engeneering) гэх зэрэг үг хэллэг б айх бөгөөд дуудлагыг нь өөрчилж авсан дэйта (DATA), карт-ka (cart) зэрэг үг хэллэгийг авч х эрэглэжээ.

Өвөрлөгчдийн шинэ үг хэллэгийн дотор өмнө нь монгол хэлээр дамжуулан орос болон бус ад хэлнээс авсан кадр систем, мораль, машин зэрэг үгс шинэ нийлмэл үгийн бүтцэд орж х эрэглэгдэж буй бөгөөд эдгээр нь үгийн санд нэгэнт хэвшин тогтжээ. Тухайлбал:» ёс морали йн 4 журам» гэсэн үгийн бүтцэд орсон мораль ([ор. мора’ль < фр. morale] ёс суртахуун, зан суртал, дүрэм журам) нь франц хэлнээс орос хэлэнд орж улмаар монгол хэлэнд хэрэглэгдэ ж байгаад ёс суртахуун хэмээн хэрэглэгдэх болсныг хэвээр хадгалан үлджээ. Үүнтэй адил а хмад кадр--ахмад ажилтан.494х), [ор. ка’дры < фр. cadre ‘бие бүрэлдэхүүн’] хэмээх үг, мөн машин-([ор. маши’на < фр. machine < лат. machina ‘бүтээгч, хийгч’] механик болон цахилгаан

хөдөлгүүрийн тусламжтайгаар ажил гүйцэтгэх оньсон техникийн ерөнхий нэр) зэрэг нь фра нц хэлнээс орос хэлэнд нэвтэрч улмаар монгол хэлээр дамжин өвөр нутгийн аялгуунд орс он бол систем- тогтолцоо [ор. систе'ма < гр. systēma 'олон зүйлийг багтаасан цул, нэгдмэл з үйл'] хэмээх үг мөн адил зүй тогтолтой бий болжээ.
Эдгээр нэр томьёоны чанартай үгс 1940-60-аад онд өвөр монголын болон монголын нэр то мьёог жигдрүүлэн тогтоож байх үеэс үгийн санд хэвшин тогтсон байдаг ч монгол хэлнээ өдг өө бараг хэрэглэгдэхээ больж орчуулагдсан, хуучирсан үгийн тоонд ордог юм.

2.3. Уламжлалт монгол үг хэллэгээ шинэ үгэнд хэрэглэж буй байдал

Монгол уламжлалт ахуй, соёлд хэрэглэгдэж байсан үг хэллэгийг шинэ үг, нэр томьёонд улир уулан хэрэглэсэн хоёр аялгуунд хадгалагдаж байна. Тухайлбал:
Суварган асар- суварган байшин - (806х.)- Бурхны шашны дурсгалын хөшөө, үнэт зүйл агуу лах уран барилгын нэг төрөл;2. Дөрвөлжин, дугуй, хагас дугуй, гурвалжин, соёмбо зэргийг давхарлан үелүүлж босгосон сүм хийдийн тахил мөргөлийн шүтээн(mongoltoli.mn) гэж тайлб арласан бөгөөд энэ үгийг өдгөө ч хэрэглэж байна. Үүнтэй адил Өтгөс гэр бүл-настай гэр бүл (669х), богц-цүнх (836х) гэх зэргээр хэрэглэж буй нь уламжлалт үгийн санг тодорхой хэмжэ эгээр хадгалж байна.

2.4. Оноосон нэрийн тохироо

Олон хэлний туршлагаас харахад оноосон нэрийг тухайн хэлнийх нь хэлбэрээр авч хэрэглэ х нь түгээмэл. Ингэж тэр хэвээр нь авч хэрэглэдэг улс орны нэр, хүний нэр, газар усны нэр, компани, байгууллагын оноосон нэр, хэмжих нэгжийн нэрийг орчуулалгүй хэрэглэж байгаа энэ хоёр аялгуунд адил байна. Жишээлбэл:

Өвөрлөгч аялгуу	Халх аялгуу
Кинийн илтгэлцүүр	Кинийн илтгэлцүүр (147х)
Корейг шүтэх	Солонгосыг шүтэх
Японыг шүтэх	Японыг шүтэх

гэх мэтээр гадаад хэлнээс авч шууд хэрэглэсэн шинэ үг байна.
Ийнхүү монгол хэлний хоёр аялгуугаар үг нэг бүрийн утгыг зэрэгцүүлэн тавьснаар үгийн са нд харилцан нөлөөлж улмаар орчуулга, монгол хэлийг заах, судлахад чухал үүрэгтэй. Учир нь нэг аялгуунд оноож чадаагүй гадаад хэлээр авсан үгээ нөгөө аялгуунаас монголчлох бол

омжтой трапиц өмд гэдгийг «бүрээ өмд», пуужин гэдгийг «залуурт сум» гэх зэргээр хэрэгл эж болох бол хятад хэлнээс өвөрлөгч аялгууны ярианы хэлэнд орж нэгэнт хэвшсэн 电话 dian hua хэмээх үгийг шинэ үгийн бүтцэд оруулахдаа 电话银行 утаст банк, 水 泥 shui ni гэж хэвшсэ н байсныг гахиур-цемент, 电池 dian chi гэдгийг зай хураагуур гэх зэргээр монголоор оноосо н бол өвөрлөгч аялгуунд хаалганы дуран гэдгийг «шагайгуур» гэдгийг бид авч хэрэглэх, ца ашилбал, өвөрмонголд хэрэглэж буй зарим хуулбар орчуулгын шинэ үгийг монголжуулан ху рааж «хөргүүрийн идээнээс болсон гэдэсний үрэвсэл» гэдгийг «хөргөгчөөс болсон гэдэсни й халдвар» гэж авснаар нэр томьёо , шинэ үг хэллэг богиносох найруулгын болоод хэрэглээ ний ач холбогдолтой болно.

Дүгнэлт:

Өвөрлөгч аялгуу болоод халх аялгуунд шинэ үг, нэр томьёо үүсэх арга нь адил. Харин ямар хэл нөлөөлснөөс шалтгаан хэлний болон соёлын ялгаа илэрч байна. Үгийн сангийн ялгаатай байдлыг илрүүлэхийн тулд 1000 үгийн хүрээнд тооцоо хийж үзвэл, хуулбар орчуулгаас үүсс эн ялгаа 20%, ойролцоо утгатай үгийг хэрэглэснээс үүссэн ялгаа 36%, зүйрлэсэн нэрлэлтий н ялгаа 3.5%-ийг, хэлц хэллэгийн утгын ялгаа нь 2%-, дагавар залгаж шинэ үгийн утгын зөр өө 1,5% гарч байгаа бөгөөд нийтдээ 67%- орчим өвөрлөгч болоод халх аялгууны үгийн санг ийн зөрөөтэй гэж харагдаж байна. Гэвч ойролцоо утгатай үгийг аль нэгийг сонгож хэрэглэх нь нэг хэлний хоёр аялгууны хувьд түгээмэл үзэгдэл бөгөөд харилцан ойлголцоход бэрхшээ л үүсдэггүй билээ.

Өвөрлөгч аялгууны шинэ үг нэр томьёоны ялгаатай байдал нь хятад хэлний орчуулгаас үүсэ лтэй бол халх аялгууны үгийн санд англи, орос хэл тодорхой нөлөө үзүүлж байгаа нь харагд аж байна.

Өвөрлөгч болон халх аялгууны үгийн санг ийнхүү бичгийн хэлний хүрээнд харьцуулан судал снаар бие биеэс суралцах, үгийн сан баяжихад хувь нэмэр оруулна.

[Ном зүй]

Баатар. Монгол үгийн сангийн шинжилгээ, Хөх хот, 1988, х. 48-49.

Болд. Л. Орчин цагийн монгол хэлний дагавар.Уб., 1986, 132х.

Большая советская энциклопедия. М., с. 428.

Бямбасан.П., Монгол хэлний шинэ үгийн тухай. «УБДС-ийн ЭШЗАБ», Уб., 1971, №1 х.39.

Баянсан. Ж., Одонтөр. Ш., Хэл шинжлэлийн нэр томъёоны зүйлчилсэн тайлбар толь, Уб., 1995, х. 192.

Крысин Л. П. Иллюстрированный толковый словарь иностранных слов. М. , Эксмо. 2008, с.864.

Монгол хэлний толь. (Норжин нарын)., ӨМАХХ, Хөх хот. 1999, х. 3142.

Монгол хэл судлал. Боть.I., Монгол хэл, аялгуу, үсэг бичиг, авиа судлал. Уб., 2022.

Монгол хэл судлал, Боть.X,Үгийн сан-утга зүй. Уб., 2022, х.157.

Миловславский. И.Г., "Вопросы слово – образовательного синтеза " М1980.,стр 51.

Нансалмаа. Н., Үгийн сан судлал.Уб., 2005, х.173.

Одоо үеийн монгол хэл. ӨМАХХ. Хөх хот, 2005, х.965.

Отгонсүрэн. Д., Монгол хэлний үгийн сангийн найруулга зүй, Уб., 1998, х.119-120.

Орчин цагийн монгол хэл. Уб., 1997, х.167.

Орчин цагийн монгол хэлний үгийн сангийн судлалын үндэс. Уб., 1986, х.268.

Өнөрбаян. Ц., Орчин цагийн монгол хэлний үгзүй, Уб., 1994, х.20.

Сүмбэрбат. Ц., Монгол хэлний үгийн сангийн асуудалд. Уб., 2007, х .230.

Төмөрцэрэн. Ж., Монгол хэлний үгийн сангийн судлал, Уб., 2001, х.115.

Хятад-монгол шинэ үгсийн тайлбар толь. ӨМАХХ. Хөх хот.

www.htpp. mongoltoli.mn


张永言：《词汇学简论》，武汉：华中工学院出版社，1982年，第87页.

冯志伟：《现代术语学引论》，北京：语文出版社，1997年，第1页.

[Summary]

In this article, we conducted a comparative study of the Inner Mongolian and Khalkha dialects of the Mongolian language, focusing on their vocabulary. We utilized the "Dictionary of New Chinese-Mongolian Terms" and other dictionaries as source material. While the methods for coining new words and terms are similar in both the Inner Mongolian and Khalkha dialects, linguistic and cultural differences emerge depending on the languages that have influenced them. An analysis of 1,000 words reveals the following breakdown of lexical differences: 20% stem from calques (loan translations), 36% from the use of near-synonyms, 3.5% from differences in metaphorical naming, 2% from differences in the meaning of idioms, and 1.5% from differences in meaning arising from the use of suffixes; overall, the two dialects exhibit a lexical divergence of approximately 67%. However, choosing and using one of several words with similar meanings is a common phenomenon between two dialects of the same language, and it does not create difficulties for mutual understanding.

[Хавсралт] N1. Хятад монгол шинэ үгийн тайлбар толь.





Гэрөөчингийн Гэрэлмаа

Монгол Улсын Шинжлэх ухааны академийн Хэл зохиолын хүрээлэнгийн Харьцуулсан хэл шинжлэли йн салбарын эрхлэгч. 『Хэрэглээний хэл шинжлэл』, 『Монгол хэлний нэр томьёо бүтэх нийлэг болон з адлаг хэв шинж』, 『Монгол хэл судлал』-ын 3, 10 дугаар боть (хамтын бүтээл) зэрэг бүтээлийн зохиогч.

Хэлэлцүүлэг 3

⌜Орчин үеийн монгол хэлний аялгууны үгийн сангийн ялгаа (Халх болон өвөр нутгийн аялгууны жишээн дээр)⌟ илтгэлийн хэлэлцүүлэг



Тогтохын Отгонтуул Монгол Улсын Их Сургууль

Доктор, дэд профессор Г. Гэрэлмаа тус судалгаандаа монгол хэлний халх аялгуу болон өвөрлөгч аялгуунд шинэ үг, нэр томьёо ямар аргаар үүсэж, үгийн санд хэрхэн нөлөөлж буйг харьцуулан судлахыг зорьжээ.

Тус судалгааны эх хэрэглэгдэхүүн нь “Хятад монгол шинэ үгсийн тайлбар толь” бүтээл бөгөөд судлаач уг бүтээлийн хоёр дахь хэвлэлд дэд голлон найруулагчаар ажилласан байна. Али ваа хэлний үгийн сангийн судалгаа хийхэд сан хөмрөг нэн чухал бөгөөд судлаачийн хувьд нэгэнт хийсэн судалгааны сан хөмрөг сайтай байсан нь тун сайшаалтай. Тодруулж хэлбэл, энэ чиглэлээр Монгол улс болон БНХАУ-ын Өвөр монголын өөртөө засах оронд олон судлаач судалгааны арвин бүтээл туурвиж ирсэн байдаг.

Г. Гэрэлмаа докторын хувьд тэдгээр судлаачийн судалгаатай танилцаж энэ удаагийн илтгэл дээ өмнөх судлаачийн хөндсөн асуудлыг дурдахаас илүү өөрийн судалгааны сан хөмрөгтөө тулгуурлан шинэ содон жишээ баримтыг гаргаж ирсэн нь чухал байна. Толь бичгээ хятад хэлний үгээр толгойлж монгол бичгээр тайлбар оноолт хийж, мөн халх аялгуугаар хадаж өгсөн нь тус судалгаанд чухам оносон эх хэрэглэгдэхүүн болжээ. Түүнчлэн хамтарсан судалгааны сан хөмрөгийг өөрийн ажилдаа үргэлжлүүлэн ашигласан нь судалгааны ёс зүйн хувьд зөрчилгүй гэж үзэж байна.

Судлаач судалгаандаа шинэ үг, нэр томьёо үүсэх аргыг гадаад болон дотоодын эрдэмтэд хэрхэн авч үздэг тухайд онолын талаас сайтар нэгтгэж түүндээ тулгуурлан судалгаагаа ангилжээ.

Тус өгүүлэлд нийт 10 000 гаруй үгтэй “Хятад монгол шинэ үгсийн тайлбар толь”-оос нэг мян ган үгийг түүвэрлэн ашигласан нь тодорхой байна. Гэвч уг толь бичгийн эхний хэвлэл (2007 онд хэвлэгдсэн, 1978–2004 оны хоорондох шинэ үгсийг багтаасан) болон нэмж боловсруулс ан хоёр дахь хэвлэлийн (1978–2018 оны хоорондох шинэ үгсийг багтаасан) алинаас нь сонго сон нь тодорхойгүй байна. Судалгаа 2014–2020 онд хийгдсэн гэж үзвэл эхний хэвлэлээс хой ш нэмэгдсэн шинэ үгсээс түүвэрлэсэн эсэх нь эргэлзээтэй байгааг цаашид тодорхойлох шаа рдлагатай.

Толь бичгийн хэвлэгдсэн онууд болон судалгаа хийсэн он цагийн холбоосыг эргэн харж, “с үүлийн 40 жил” гэх мэт тодорхойгүй эсвэл зөрүүтэй, цаг хугацааны давхцалыг нягтлах хэрэ гтэй.

Эрдэм шинжилгээний тус өгүүлэл үндсэн хоёр хэсгээс бүрдэж байна. Эхнийх нь Халх болон өвөрлөгч аялгууны үгийн сангийн зөрөөтэй байдал, удаах нь халх болон өвөрлөгч аялгууны үгийн сангийн нэгдмэл байдал гэж авч үзээд дотор нь дэд хэсгүүдэд хуваажээ. Юун түрүүнд тус судалгааны шинэлэг талыг дурдъя.

Судлаач хоёр аялгууны үгийн сангийн ялгаатай талыг тодруулахдаа хятад хэлний хуулбар о рчуулга өвөрлөгч аялгуунд шууд орсноор халх аялгуутай нэлээд холдсоныг өв: чулуун тос - хал: бензин, шатахуун, өв: ягаан заамтан- хал: нарийн бичиг эмэгтэй; халх аялгуунд зарим н эршил шууд орж ирснийг өв: Нэг бүс нэг зам- хал: Нэг бүс нэг зам, өв: дөрвийг биелүүлэх- х ал: дөрвийг биелүүлэх гэх мэт жишээгээр тодлон харуулжээ. БНХАУ-ын бодлого шийдвэр, ж урмыг нэрлэсэн энэ мэт орчин үеийн нэршлийг халх аялгуунд шууд буулгаж буй бөгөөд энэ хүү ойлголтыг тухайн хэлнийх нь сэтгэлгээ, бэлгэдэл соёлтой холбон дэлгэрүүлэн тайлбарл асан нь чухал, шинэлэг байна. Энэ мэтчилэн хуулбар орчуулгаас үүссэн жишээ 1000 жишээн ий 20 хувийг эзэлж байна гэж судалгааны үр дүн гарсан байна. Тэгэхээр 200-аад үг байх нь. Харин судлаач дараагийн судалгаандаа сонирхолтой жишээг арвин оруулбал уншиж судлах хүнд илүү хэрэгтэй гэж бодож байна.

Мөн судалгааны сонирхолтой зүйл нь хэлц хэллэгийн утгын ялгааг харьцуулан үзсэн (1.3) хэ сэг байна. Өвөрлөгч аялгуутны хэл ярианд түгээмэл хэрэглэж буй орчин цагийн үйл явдалта й холбоотой “амсар оногч, хөх малгайт цэрэг, уулнаас барыг буулгаж ирэх” гэх мэт хэлцийг халх аялгуунд оноон буулгасан нь хоёр аялгуугаар хэлэлцэгчид үл ойлголцлыг давахад туст ай зүйл болсон байна. Энэ мэт жишээ 2 хувь эзэлж буй гэх судалгааны үр дүн гарсан тул ол он жишээ дараа дараагийн судалгаандаа дурдах нь чухал.

Халх болон өвөрлөгч аялгууны үгийн сангийн нэгдмэл байдлыг харьцуулан үзэхдээ хоёр ая лгуунд гадаад хэлнээс орчуулгаар дамжин орсон үгс яг адил байгаа бөгөөд ийм үг 21 хувь э зэлж байна гээд хоёр үг нийлэн утгын талаар нэгдэж шинэ нэрлэлт үүсгэж нийлмэл үг бүтээ ж байгааг онцолжээ.

Доктор Г. Гэрэлмаа өвөрлөгч аялгуунд англи хэлнээс шууд авсан, монгол хэлээр дамжуулан авсан үгс байгааг дурдахдаа тухайн үгийн гарлын асуудлыг анхааран латин, франц, орос, анг

ли, грек зэрэг үгийг тухайн хэл бичгээр нь хадаж, тодруулан гаргаж, утгыг тайлбарлан монго л хэлнээ оноосон нь судалгааны чанарыг илтгэж байна. Харин эдгээр үгсийг тухайн хэлээр нь хэрэглэх бус халх аялгуунаа буулгасан хувилбарыг хэрэглэх нь хоёр аялгуутан монгол хэлээ хамгаалж хадгалахад чухал болохыг судлаачийн байр сууринаас онцлон тэмдэглэх нь зүйтэй. Цаашдын судалгаанд анхаарвал зохих хэдэн асуудлыг дурдъя. Энэ нь тус судалгааны үнэ цэ нийг бууруулахгүй бөгөөд ажилд хэрэглэсэн нэр томьёог цаашид жигдлэхэд тусална. Тухай лбал, өвөрлөгч аялгуу, өвөр нутгийн аялгуу, өвөрлөгчдийн үг хэллэг, өвөр монголын нэр том ьёо гэж олон янзаар бичсэнийг нэг мөр болгох нь зүйтэй. Жишээ нь: Өвөр Монгол гэхийг БН ХАУ-ын Өвөр Монголын Өөртөө Засах Орон (ӨМӨЗО), Өвөрлөгчид гэхийн оронд Өвөр монго лчууд гэж хэвшсэн нэршилээр жигдлэх шаардлагатай. Мөн судалгааны үр дүнг хэсэг зүйл бү рд тоон хувиар дурдсаныг нэгтгэсэн диаграмм, хүснэгтээр харуулбал хоёр аялгууны онцлог ийг харьцуулан харахад илүү ойлгомжтой болох юм.

Түүнчлэн судалгаанд дурдагдсан жишээ үг, хэлц үгсийн заримд баримтын хуудасны дугаар дутуу, ханз үсэг болон дуудлагыг тэмдэглээгүй, ном зүйн мэдээлэл бүрэн бус зэрэг алдаа м адаг ажиглагдаж байгааг анхаарах нь зүйтэй.

Шинжлэх ухаан, технологи, эдийн засаг, нийгэм, соёлын салбарт нэр томьёо, шинэ ухагдаху ун хурдацтай нэмэгдэж буй өнөө үед олон улсад эх хэлэндээ орж байгаа шинэ үгсийг жил б үр судалж, толь бичиг болгон гаргаж байна.

Доктор, дэд профессор Г. Гэрэлмаа нь монгол хэлний үгийн сангийн судалгаагаар олон жил тууштай ажиллаж, судалгаа шинжилгээний арвин бүтээл туурвисан судлаач бөгөөд энэхүү судалгааны ажил цаашид улам гүнзгийрэн, ач холбогдолтой үр дүнгүүд гарсаар байна гэдэг т итгэлтэй байна.

Тогтохын Отгонтуул

Монгол Улсын Их Сургуулийн Шинжлэх ухааны сургуулийн Монгол хэл, хэл шинжлэлийн тэнхими йн профессор. 「A Comparative Study on the Interrogative Particle in Mongolian Language and Manchu Language - Focusing on 'Chong-o-Nogoldae' and 'Mong-o-Nogoldae'」 (хамтын өгүүлэл), 『Хуучин манж данс』 IX боть (орчуулга), 『Nisan udagan bitigi』 (хамтын орчуулга) зэрэг бүтээлийн зохиогч, орчуулагч.

Илтгэл 4

МОНГОЛ УЛС, ӨВӨР МОНГОЛ, БУРИАД ХЭЛНИЙ ҮГСИЙН САНГИЙН ӨӨРЧЛӨЛТ, ХЭРЭГЛЭЭНИЙ ОНЦЛОГ



Цэвээндоржийн Батдорж Монгол Улсын Их Сургууль

[Товч агуулга]

Энэхүү илтгэлд Монгол Улс болон БНХАУ-ын Өвөр Монголын Өөртөө Засах Орон (мөн, ОХУ-ын Бүгд Найрамдах Буриад Улс)-ы монгол хэлний үгийн сангийн хэрэглээнд нэгэн ижил юм, үзэгдэл, үйл явдал, үйлдлийг өөр өөр үг, хэллэгээр илэрхийлэх үзэгдлийг үгийн сан, утга суд лал, нийгэм хэл шинжлэлийн үүднээс харьцуулан судална. Судалгааны үндсэн асуудал нь ут га дүйцэх үг, хэллэгийн хэлбэрийн ялгааг бүртгэхийн зэрэгцээ тэдгээрийн ялгаа үүссэн нөхц өлийг тодорхойлж, тайлбарлах явдал болно.

Илтгэлд Насанбат зохиож, Өвөр Монголын Шинжлэх ухаан, техник мэргэжлийн хэвлэлийн х орооноос 2009 онд хэвлэн гаргасан “Монгол хэл сурах бичиг” номд орсон Хөххотын монгол чуудын хэл ярианы өгүүлбэрүүд болон харилцан яриаг гол эх хэрэглэгдэхүүн болгож, түүний г Улаанбаатарын халх аялгуутны хэл яриатай харьцуулж, мөн ОХУ дахь буриадчуудын үгийн сангийн холбогдох мэдээлийг хавсаргаж, тайлбарлана. Харьцуулах нэгжийг сонгохдоо ижи л юм, үзэгдэл, үйл явдал, шинж чанарыг зааж байгаа эсэхийг утгын тайлбар болон хэрэглээ ний хам сэдвээр нягталж, үүний үндсэн дээр утгын бүрэн ба хэсэгчилсэн дүйцлийг ялгаж, үг, хэллэгийн зөрөөг үгийн гарал, үг бүтэх арга, бүтцийн онцлог, утгын хөгжил болон хэрэглээ

ний хэв маягаар ангилна. Үг, хэллэгийн ялгааг тайлбарлахдаа үгийн сангийн сонголт, зэллэ г үг, орчуулсан арга зэрэг хэлний үзэгдлийг улс төр, газар зүйн тусгаарлалт, өөр өөр хэлний хавьтал, хэлний хэм хэмжээтэй холбон авч үзнэ. Эдгээр хүчин зүйлийг урьдчилан тогтоосон шалтгаан гэж үзэхгүй бөгөөд тухайн нэрлэлтийн үүсэл, тархалт, хэрэглээний баримтад тулгу урлан үнэлнэ.

1. Удиртгал

1.1 Судалгааны үндэслэл

Монгол төрөл хэл хийгээд монгол хэлний олон нутгийн аялгуунуудын үгийн сангийн судалга а, толь бичиг зохиох ажил бол нэлээд түүхтэй бөгөөд хэвлэн нийтэлсэн эх хэрэглэгдэхүүн, б үтээл ном ч арвин болжээ. Гэвч, эдээр хэрэглэгдэхүүний дийлэнх нь аль нэг хэл, аялгууны үгийн санд чиглэгдсэн, эсвэл зарим хэл аялгууны үгийн сангийн ижил хийгээд ялгаатай талы г зэрэгцүүлэн харуулахад анхаарсаар ирсэн юм. Тэгвэл бид цаашдаа, монгол төтөр хэл, аял гуунуудын үгийн сангийн зохих нэгжүүдийн ялгааг бүртгэн харуулахаар хязгаарлахгүйгээр, бусад хэлтэй харилцах явцад бий болсон зээллэг, орчуулга, утга ба хэрэглээний шинэчлэлтэ й холбон шинжилж, тайлбарлах шаардлагатай гэж үзэж байна. Өөрөөр хэлбэл, Эдвард Сапи рын “Хэл нь соёлын нэгэн адил дангаараа өөрийгөө хангах нь ховор” хэмээн тэмдэглэсэнчл эн монгол төрөл хэл, аялгууны үгийн санг нийгэм, соёлын харилцаан дунд нь тайлбарлах хэ рэгтэй (Sapir, 1921).

Үгийн сангийн харьцуулалтад хэлбэрээс утга руу, ойлголтоос илэрхийлэл рүү чиглэсэн хоё р хандлагыг хослуулах нь чухал байдаг. Дирк Герартс болон түүний хамтран зохиогчид үгий н сангийн хувилбарыг судлах нэг хэмжээсийг “хэлний хэлбэрийг утгатай холбох хэмжээс” г эж тодорхойлсон (Geeraerts et al., 2024). Тэд энэ харьцааг хоёр чиглэлээр шинжилж, семас иологи болон ономасиологийг ялган авч үздэг. Семасиологийн хандлагаар нэг үг ямар утгаа р хэрэглэгдэж байгааг, ономасиологийн хандлагаар нэг ойлголтыг ямар үг, хэллэгээр илэрх ийлж байгааг судална. Энэхүү илтгэлд ономасиологийн хандлагыг баримтлан: нэгдүгээрт, н эг ойлголтын ялгаатай илэрхийллийг; хоёрдугаарт, ижил буюу төстэй хэлбэртэй нэгжийн утг а, хэрэглээний зөрөөг тодорхойлно. Харин, үгийн утгын дүйцлийг зөвхөн толь бичгээс биш т эдгээр үгтэй хамт хэрэглэгддэг үгсээр нь тодлруулан таних нь чухал гэж үзэв (Firth, 1957). Т үүнчлэн, Герартс, Гронделарс, Бакема нарын санал болгосон үгийн сангийн хувилбарыг утг ын хувилбар, нэг ойлголтын нэрлэлтийн хувилбар, хэлбэрийн хувилбар гэсэн хүрээнд авч үз эв (Geeraerts, Grondelaers, & Bakema, 1994).

Эдгээр дурдсан хэрэгцээ шаардлага хийгээд үзэл баримтлалыг үндэс болгон “Монгол хэл с

урах бичиг"-ийн өгүүлбэр, харилцан ярианд тэмдэглэгдсэн Хөххотын монголчуудын үгийн с ангийн хэрэглээг Улаанбаатарын халх аялгуутны хэрэглээтэй харьцуулж, холбогдох хэсэгт Улаан-Удийн буриад хэрэглээний дүйцлийг нэмж, сонгосон эхэд илэрсэн үгийн сангийн ялга аг системтэй тайлбарлахыг оролдов. Энэ нь цаашдын өргөн хүрээний харьцуулалт болон ца г хугацааны өөрчлөлтийн судалгаанд суурь материал бүрдүүлэх үндэслэл болно.

1.2 Судалгааны зорилго ба зорилт

Монгол Улс, БНХАУ-ын Өвөр Монголын Өөртөө Засах Орон (ӨМӨЗО), мөн ОХУ-ын Бүгд Найр амдах Буриад Улсын монгол хэлний үгийн сангийн хэрэглээнд нэг ойлголтыг өөр өөр үг, хэл лэгээр илэрхийлэх үзэгдлийг харьцуулан шинжилж, тэдгээрийн ялгааны төрөл, утгын дүйх т үвшин, хэрэглээний онцлогийг тогтоох, улмаар эдгээр ялгааг үүсгэж, тогтворжуулж буй хэл ний дотоод болон нийгэм, түүхийн хүчин зүйлтэй холбон тайлбарлахад судалгааны зорилго оршино. Үүний тулд дараах зорилтыг тавьсан болно. Үүнд:

Насанбат зохиож, Өвөр Монголын Шинжлэх ухаан, техник мэргэжлийн хэвлэлийн хорооноо с 2009 онд хэслэсэн номд орсон Хөххотын монголчуудын хэл ярианы өгүүлбэрүүд болон хар илцан яриаг компьютерт оруулж, түүнийг Улаанбаатарын халх аялгууны тохирох нэгжүүдтэ й харьцуулах, ялгаа үг, хэллэгийг бүртгэн гаргах.

Цуглуулсан нэгжийн утга, зааж буй юм үзэгдэл, хэрэглээний хам сэдвийг харьцуулж, утгын бүрэн болон хэсэгчилсэн дүйцлийг тогтоох; төстэй боловч өөр ойлголтыг илэрхийлсэн нэгж ийг ялган үзэх.

Үг, хэллэгийн ялгааг үгийн гарал, үг бүтэх арга, бүтцийн онцлог, утгын хөгжилд тулгуурлан а нгилж, уламжлалт үгийн сонголт, зээлдлэг, орчуулгын нэрлэлт, утгын шилжилт болон нийлм эл нэрлэлтийн оролцоог тодорхойлох.

1.3 Судалгааны асуулт

Судалгааны зорилтуудад үндэслэн дараах асуултад хариулна. 1. Монгол Улс, БНХАУ-ын Өвө р Монголын Өөртөө Засах Орон (мөн, ОХУ-ын Бүгд Найрамдах Буриад Улс)-ны монгол хэлн ий үгийн сангийн хэрэглээнд ямар үг, хэллэг бүхэлдээ өөр байдаг вэ? 2. Ямар үг, хэллэгүүд э дгээр хэл ярианд байдаг боловч утга эсвэл бүтцээрээ ялгаатай вэ?

1.4 Судалгааны ач холбогдол

Илтгэлийн үр дүн нь Монгол Улс, Өвөр Монгол, Буриадын хэл ярианы хэрэглээнд нэгэн ижи л юм, үзэгдэл, үйл явдал, үйлдлийг илэрхийлэх нэр үг, үйл үг болон хэллэг ямар замаар, хэр хэн ялгарч хөгждөг хийгээд, тэдгээр ялгааг үүсгэж, тогтворжуулж буй хэлний дотоод болон нийгэм, түүхийн хүчин зүйлийн талаар таньж мэдэхэд ач холбогдолтой. Эдгээр нэгжийн утг ын дүйцэл, бүтэц, хам үгийн холбоо, хэрэглээний онцлогийг шинжлэх нь гурван бүсийн үгий н сангийн нийтлэг ба ялгаатай талыг тодруулна. Улмаар, энэ сэдвийн дагуу харьцуулсан тол ь бичиг зохиох, орчуулга хийх, хэл заах материал боловсруулахад онол, арга зүйн чиг барим жаа болгон ашиглах боломжтой.

1.5 Судалгааны хязгаарлалт

Судалгаа нь 2000 оны “Монгол хэл сурах бичиг”-ийн өгүүлбэр, харилцан ярианд голлон тулг уурлах тул тухайн эхийн сэдэв, үгийн сонголт, сургалтын зорилгоор хязгаарлагдана. Хөххот, Улаанбаатар, зарим тохиолдолд Улаан-Үдийн хэрэглээг харьцуулах учраас үр дүнг гурван б үсийн нийт хэрэглээнд ерөнхийлөхгүй. Нэр үг, үйл үгийн дүйцлийг тухайн хам сэдэвт тогтоо х бөгөөд үйл үгийн утгыг өгүүлбэрийн бүтэц, холбогдох үг, илэрхийлж буй үйлдлийн нөхцөл тэй нь хамтатган авч үзнэ. Гурван талын материалын хэмжээ, эх сурвалж жигд бус, мөн өөр өөр үеийн хэрэглээ давхцах боломжтой тул ялгааны шалтгаан, тархалт, түүхэн өөрчлөлтийн талаарх дүгнэлтийг баримтын хүрээнд хязгаарлана.

2. Судалгааны арга зүй

XXI зууны солонгосын уран зохиолд анхаарах нэг асуудал нь үндэстний асуудлыг урагш тэм үүлсэн шинэ төсөөллөөр сэтгэх явдал юм. Дэлхий дахины капиталист тогтолцооны нөхцөлд үндэстнийг ганц улсын хүрээнд ойлгодог уран зохиолын хэт явцуу танин мэдэхүй, түүнд тул гуурласан эсэргүүцлийн төсөөллөөр энэ асуудалд оновчтой хариу өгөх боломжгүй. Энэ утга араа Хван Сог Ёны «Баридэги» роман (Чанби, 2007), Жөн До Саны «Зэрлэг сарнайн цэцэг» ц уврал хүүрнэл зохиолын (Чанби, 2008) ололт анхаарал татна.

Энэ хоёр бүтээл хоёулаа Умардаас дүрвэгсдийн диаспораг өгүүлдэг. Гэхдээ хүүрнэлийнхээ г ол хүчийг хуваагдлын асуудлыг Солонгосын хойгийн Өмнөд, Умардын үзэл суртлын зөрчил, сөргөлдөөнөөр хязгаарлах бус, илүү өргөн хүрээнд харахад чиглүүлжээ. Өмнөх «хуваагдлын тухай хүүрнэл»-д дассан уншигчдад эдгээр зохиол шинэ санагдана. Хамгийн шинэлэг нь Ум ардаас дүрвэгсдийн асуудлыг (БНСУ, БНАСАУ хэмээх) үндэсний улсын буюу тусгаар улсын т өсөөлөлд хашигдсан үндэстний асуудал гэж бус, дэлхий дахины капиталист тогтолцоотой н ягт уялдсан бодит амьдрал дахь үндэстний асуудал гэж үзсэнд оршино. Энэ нь Умардаас дү рвэгсдийн диаспораг ойлгох, цаашлаад хуваагдлын тогтолцоог даван энх тайвны тогтолцоо нд хүрэхийг эрмэлзсэн уран зохиолын танин мэдэхүй, үйл ажиллагааны үнэ цэнтэй ололт юм. Бидний өнөөг хүртэл мэддэг Умардаас дүрвэгсдийн тухай ойлголт нь тэд Умардын улс төр, эдийн засгийн дарамтыг тэсэж чадаагүйдээ БНСУ-ын либерал ардчиллыг сайн дураараа со нгосон гэсэн, коммунизмыг эсэргүүцэх үзлээр дангаар тайлбарладаг «үзэл суртлын шалтгаа нт дүрвэлт»-д хэт баригдсан талтай. Харин Хван Сог Ён, Жөн До Саны зохиолд ийм тайлбара ас өөр шүүмжлэлт эргэцүүлэл бий. Олон улсын хамтын нийгэмлэг Умардыг эдийн засгийн х увьд тусгаарласнаар ядуурал нь хурдацтай гүнзгийрч, ийм олон улсын нөхцөлд Умардын эр х дархтай бүлэглэл ард түмнийхээ амьдралыг бүрэн анхаарч чадахгүй байгааг өгүүлдэг. Тэд ний Умардын тухай хүүрнэл нь коммунизмыг эсэргүүцэх байр сууринаас Умардын нийгмийг гадуурхан харах хандлагыг давж, олон улсын нөхцөл байдлын дунд хүч дорой талд орших У мардын ард түмнийг хүн төрөлхтнийг энэрэх сэтгэлээр харах үндэстний асуудлын шинэ ой лголтыг харуулна. Ялангуяа Хван Сог Ёны дүрсэлсэн Баридэги нь Хятадаар дамжин Их Брит анид шилжин суурьших явцдаа араб хүнтэй учирч, гэрлэн, аз жаргалтай амьдралыг мөрөөд дөг. Зохиолын үйл явдлыг ийн өрнүүлсэн нь Хван Сог Ён хуваагдлын тогтолцоог даван туула х асуудлыг зөвхөн нэг улсын хүрээнд авч үзэх үндэстний асуудал буюу үндэстнээ нэгтгэж, н эгдсэн улс байгуулах явдлаар хязгаарлаагүй бөгөөд үүнийг зөвхөн Өмнөд Солонгос эсвэл А НУ төвтэй Өрнөдийн хүчээр хэрэгжинэ гэж ч үзээгүй. Харин өнөөгийн дэлхийд улс төр, эдий н засгийн хувьд хамгийн ихээр ялгаварлан гадуурхагдаж буй умард солонгосчууд болон ара б үндэстний хооронд улс төр, ёс зүйн эв санааны нэгдэл бий болгох боломжийг эрэлхийлжэ э. Үүгээрээ тэрээр Өрнөд төвтэй ойрх үеийн нөлөөгөөр дахин зохион байгуулагдсан хуваагд

лын тогтолцоог тодорхой утгаар шүүмжлэн эргэцүүлсэн нь анхаарал татаж байна. Жөн До Сан ы дүрсэлсэн Чүншим ч Умардаас дүрвэгсдийн талаарх явцуу, коммунизмыг эсэргүүцсэн о йлголтыг засахад хүргэдэг. Дүрвэгсдийн туулдаг элдэв зовлонг энэрэн харснаар хуваагдлы н тогтолцоог задлахын тулд чухам юуг, хэрхэн тунгаах ёстой вэ гэсэн үндсийг нь хөндсөн ас уултыг тавьдаг. Бид Өмнөд, Умардын үндэстний асуудлыг Өмнөдийн тогтолцоо Умардынхаа с давж ялсан гэх бүдүүлэг, өнгөц ойлголтоор харж байгаа юм биш биз гэсэн зарчмын асуулт ыг Жөн До Сан дэвшүүлж байна.

Ийнхүү Умардаас дүрвэгсдийн диаспораг өгүүлсэн Хван Сог Ён, Жөн До Саны уран бүтээл XXI зууны солонгосын уран зохиолд үндэстний асуудлыг илүү өргөн, гүн эргэцүүлэх шинэ бо ломж нээсэн гэхэд хэтрүүлэг болохгүй. Хван Сог Ёны зохиолд Солонгосын хойгийн үндэстни й асуудал дэлхий дахины үйл явцтай холбогдож, Жөн До Саны зохиолд Өмнөд, Умардыг яар ан нэгтгэхээс татгалзан, ялгаатай оршихуй хамтран амьдрах ялгаатай байдлаа хадгалан эв з охицох (和而不同), «хоёр хэвээрээ нэгдэх» (統二/通二) төсөөллийг олж авдаг.

Умардаас дүрвэгсдийн диаспораг дүрсэлсэн хүүрнэл дунд сонирхол татах өөр бүтээлүүд ч б ий. И Ын Жүний «Улсын хувийн амьдрал» роман (Минүмса, 2009) нь «Бүгд Найрамдах Соло нгос Улс Бүгд Найрамдах Ардчилсан Солонгос Ард Улсыг өөртөө нэгтгэн шингээсний»[2] дар аах бодит байдлыг өгүүлсэн төсөөллийн түүхэн роман юм. Харин Квон Ригийн «Солгой гарт ноён Ли» роман (Мүнхагсүчоб, 2007) нь Умардаас дүрвэн БНСУ-д суурьшсан хүн компьюте рын тоглоомд гүн автаж, бодит амьдрал ба виртуал ертөнц хоорондоо хутгалдахыг харуулн а. Энд хамтад нь анхаарах зүйл бол өөртөө шингээн нэгтгэсний дараах «нэгдсэн БНСУ» боло н хуваагдлын тогтолцоотой хэвээр буй БНСУ-д өдөр тутмын амьдралаа залгуулж буй Умард ын иргэдийг зохиолчид хэрхэн ойлгож буй явдал юм. Хоёр зохиолд хоёуланд нь Умардын ир гэд дассан орчноосоо өөр БНСУ-д амьдралаа төвхнүүлэх гэж чармайдаг. И Ын Жүн, Квон Ри нар Солонгосын дайныг биеэр туулаагүй залуу үеийнхэн бөгөөд «Зургаадугаар сарын 15-ны үе»-ээс хойш ахисан Өмнөд, Умардын харилцааны соёлын үр шимийг хүртсэн хүмүүс юм. Ха мгийн гол нь Хүйтэн дайны үеийн улс төр, нийгмийн үзэл суртлаас ангижирч, түүнээс салж ч адаагүй Хүйтэн дайны хабитустай шийдэмгий салах ёс хийсэн үеийнхэн тул Умардын иргэд ийг ойлгох нэлээд сонирхолтой хандлага харуулдаг.

И Ын Жүн, Квон Ри нар БНСУ-ын дангаар тогтоох улс төр, нийгмийн ноёрхлоор төгсөх хуваа гдлын тогтолцооны ганхалт ямар бодит байдал үүсгэсэн, цаашид үүсгэж болохыг хурцаар х аруулна. Умардын иргэд «хоёрдугаар зэргийн иргэн» болж доройтож байгаа, цаашид ч тийм болох магадлал өндөр байгааг тэд шууд асуудал болгон тавьжээ.

«Ам хэлээрээ хүний эрх, хүний эрх гэдэг хэрнээ бодит тусламж үзүүлдэггүй засгийн газар л асуудалтай. Консерватив чууд, Америк хоёр Умардаас гарсан хүмүүсийг дүрвэгч болгон хуви ргаж, хүний эрхээр нь улс төрийн наймаа хийнэ. Харин дэвшилтэт талынхан Умардын тогтол цоо нуран уначих вий гэвд хүний эрхийн асуудлыг бүр харахгүй өнгөрөөнө биз дээ? Намынх

2) И Ын Жүн. “Улсын хувийн амьдрал”. Минүмса, 2009, 11-р тал.

аа явцуу ашиг сонирхлыг хөөж байгаад Ким Жон Илийн пуужингийн туршилтад араасаа цох иулчихна. Би Ким Жон Илийн дарангуйлал, удирдагчийг үнэмлэхүйд өргөмжлөх үзлийг дург үйцээд өөрийн хөлөөр гарч ирсэн хүн. Гэхдээ нийгэм яаж эргэж байгааг харахаар бодол ми нь зөв байсан уу гэж эргэлзэх юм. Тэгэж байх завтай бол бидэнд шударгаар хөдөлмөрлөх а жил олж өгвөл дээр дээ.»

«Сүүлийн үед зохион байгуулалттай дүрвэлтийг зогсооно гээд суурьших тэтгэмжийг хүртэ л хувааж өгдөг болсон гэнэ. Тэгвэл ганц дэлгүүр ч нээж чадах уу? Цөм л дүрвэгсдийн тоог ц өөлөх далд санаа.»

«Хельсинкийн бүлэг дахиад нэг хэрэг бүтээх нь үү? Хүний эрхээр дарамталж, Зөвлөлт, Зүүн Европыг нураах гэж.»

«Тийм ээ. Энэ бүхэн Америкийн империалист новшнуудаас болсон. Умардаас гарсан бүх хүн ийг хүлээж авбал Хятад хилээ чангална. Эцэст нь Умардаас хүн гарах аргагүй болно. Эдийн засгийг нь бүсэлж хаагаад "Хүнд бэрх аян"-ыг туулуулав. Одоо хүний эрхээр нь довтлон шах аж, Солонгосын хойгийг Ирак болгох санаатай байгаа юм. Америкт очвол байр, ажил, иргэн шил өгч, бүр дэвшин дээшилж болно гэдэг. Гэхдээ би Америк руу хэзээ ч явахгүй, хм!»

(«Солгой гарт ноён Ли», 111–112-р тал.)

Хамгийн аймшигтай бодит байдал нь БНСУ-ын консервативчууд, АНУ төдийгүй БНСУ-ын дэв шилтэт талынхан ч Умардаас дүрвэгсдийг өөр өөрийн ашиг сонирхолд нийцүүлэн улс төрд а шиглахаас цаашгүй, харин тэд БНСУ-д «хоёрдугаар зэргийн иргэн» болж буй асуудлын ноц тойг хэн ч зохих ёсоор ойлгохгүй байгаа явдал хэмээн зохиолчийн шүүмжилсэн нь үндэслэл тэй. Иймээс Квон Ри дүрвэгчийн нүдээр БНСУ-ыг «манан дунд амьдарсаар манандаа дасаж, юу ч харахыг хүсэхээ больсон улс»[3] гэж харуулдаг. Тэр манант улсад дүрвэгчид «хоёрдугаа р зэргийн иргэн» болон амьдрах ёстой гэсэн Сүйрлийн зөнтэй бодит байдлыг тун тайван, сэ тгэл хөдлөлд авталгүйгээр нээн харуулдаг.

И Ын Жүн, Квон Ригийн бүтээлээс «арай ч тийм юм болохгүй байлгүй» гэх хоосон болгоомжлол үнэндээ хоосон биш байж болохыг хүүрнэлээр дамжуулан тунгааж болно. Үүнийг урьдчилан сэ ргийлэх вакцин хийлгэсэнтэй зүйрлэж ч болох юм. Хуваагдлын тогтолцоо ганхах явцад бодитоо р нүүр тулах Умардын иргэдтэй шинэ харилцаа тогтооход ухаан, хэрсүү бодол шаардлагатай.

3. Гадаадын иргэдийн шилжилт хөдөлгөөн ба диаспора

Капиталист дэлхийн тогтолцооны хүчтэй нөлөөн дор анхаарал татаж буй нийгмийн тулгамд сан асуудлын нэг нь гадаадын иргэдийн цагаач хөдөлмөр юм. Солонгосын хөдөлмөрийн зах зээлд орж ирсэн гадаад ажилчид солонгос ажилчдаас хавьгүй дор орчин, нөхцөлд ажиллах ыг тэвчиж байна.

---

3) Квон Ри. "Солгой гарт ноён Ли". Мүнхагсүчоб, 2007, 148-р тал.

(1) Яруу найраг дахь диаспора

Тэр эмэгтэйг харахаар учиргүй уцаар хүрнэ / Түүний эцгийн эцэг / Японд булаалгасан Чосөнъ нутгаа голж / Амьдарлаа ч цааш амьдрах аргагүй эх орноо голж / Хар мөрөн р үү явсан атал / Тэр эмэгтэй өвгийнхөө орхисон / Газар ус нь танилгүй эх нутгийн нэг м ухарт ирээд / Цагаан гуяа ил гарган, цээж биеэ найгуулж / «Нэрийг чинь ч мэдэхгүй, о вгийг чинь ч мэдэхгүй / Анх учирсан эрийн тэвэрт тас тэврүүлээд...» // Хөгцний үнэр х анхалсан архины газар / Орхиод ирсэн том жижиг үр хүүхэд, гэрийнхнийхээ / Зүг тэнг эрийн хаяа ширтсэн нүдээр дуулна, новш / Яагаад ингэтлээ уур оволзоод байна аа / Гу йвж дайвсаар гарч, шараа тайлах гэж гоймон идтэл, новш / Шөл нь яагаад ийм халуун юм бэ / Цахилгааны шон түшиж шээтэл, новш / Ямар ч буруугүй өмдний салтаа л яага ад нороод байна аа

— Ким Сүү Ёл, «Яньбяний эмэгтэй», «Салхины мэхийн ёслол», Эжи, 2006. Бүтнээр нь.

Ёжү хошууны Канам сумын улсын зам дагуух, Ёжүгийн будаатай хоолны нэгэн газарт / Шаргал дүрэмт хувцастай залуу эмэгтэй оройтсон өдрийн хоол уу, эртэдсэн оройн х оол уу гэмээр хоолоо яаран идэж сууна (хэсэг хасав) Түр тээнэгэлзсэнээ хойгийн хам гийн хойд захын боомт хот Хамхынаас ирсэн гэлээ (хэсэг хасав) Өмнөдөд хамгийн хэ цүү нь, эцэг эх, ахан дүүсээ санахаас ч хэцүү нь аялга яриагаа өөрчлөх, Умардаас ирс нээ нуух гэнэ / Өлсөхийн эрхээр уйлан уйлсаар өвлийн тас хөлдсөн хүйтэн голыг ганц аараа гаталж, холын зам тойрон тойрсоор ирсэн чинь одоо өмнөх зам нь харагдахгүй байна гэнэ / (хэсэг хасав) / Тэсэхийн аргагүй хөнгөн сониуч зан, амны минь зоргоор у рсах үгс өөрөөс минь ичээхээс өөр аргагүй

— Квак Хё Хван, «Умардаас дүрвэсэн гольфын туслах И Со Хи», «Газрын зурагт байхгү й гэр», Мүнхаггважисөнса, 2010. Хэсгээс.

Яньбянаас ирсэн хятад дахь солонгос үндэстэн эмэгтэй архины газарт үйлчилж, Хамхынаас ирсэн умард солонгос эмэгтэй гольфын талбайд туслахаар ажиллан Солонгост амьдарч ба йна. Энэ хоёр эмэгтэй хоёулаа гадаадын цагаач ажилчны бодит амьдралыг хуваалцана. Тэд энд хандах өгүүлэгчдийн хандлага нэлээд ялгаатай мэт боловч хоёулангийнх нь дотоод ертө нцийг нэвтэлж буй яруу найргийн ухамсар бол цагаач ажилчдад ханддаг өөрийн байр суури а шүүмжлэн эргэцүүлэх явдал юм. Солонгос үндэстэн эмэгтэйн нийтийн дууг сонсоод өгүүл эгчийн дотор оволзох «уур» нь тэр эмэгтэйн амьдралын замналтай холбоотой уур хилэн, гу ниг, санагалзал, харуусал холилдсон сэтгэл юм. Түүний гунигт дуунаас колонийн үеэс өнөөг хүртэл диаспорагийн амьдралаар амьдрахаас аргагүй байсны зовлон мэдрэгдэнэ. Тэр зовл онгоосоо салж чадаагүй эмэгтэй Солонгост диаспорагийн бас нэгэн амьдралаар амьдарч б

айна. Түүний амьдралын түүхийг дагалдах тэр зовлонг өгүүлэгч арилгаж өгч чадахгүй. Хари н оволзох уурынхаа хүчээр тэдний ийм замналд өчүүхэн ч болов хувь нэмэр оруулсан бид б үхнийг өдөр тутмын амьдралдаа хатуу шүүмжлэн эргэцүүлдэг. Мөн өөрөөсөө ичиж, өөрийг өө зэмлэнэ. Солонгосчуудаас өөр аялгатай умард солонгос хүмүүсийн талаарх «тэсэхийн ар гагүй хөнгөн сониуч зан» нь солонгосын нийгэмд хамаг хүчээрээ амьдрах гэж хичээж буй хү мүүст бодит ялгаварлал болж, суурьшихыг нь улам хүндрүүлдэг гэдгийн ноцтойг өгүүлэгч у хаарна. Солонгосын нийгмийн гишүүдэд байдаг л зүйл мэт санагдах хандлага нь тус улсад ш илжин ирсэн гаднын хүмүүсийн хувьд өөрсдийг нь тэр нийгмээс ялган зааглаж, улмаар гаду урхал, ялгаварлан хандах явдлыг нийгмийн тогтолцоонд бэхжүүлж буй үзэл ойлголт болж б айгаа нь ноцтой асуудал юм.

Энэ асуудлын үүднээс Ха Жон О яруу найрагчийн тасралтгүй үргэлжилсэн яруу найргийн ту урвилыг анхаарахгүй өнгөрч болохгүй. Тэр «Хилгүй үйлдвэр» (Самчан, 2007), «Ази гаралтай солонгосчууд» (Самчан, 2007), «Хилээр орж ирэгсэд» (Санжини, 2009), «Эзэнт гүрэн» (Мүнх агдоннэ, 2011), «Өмнөд, Умардын бэлгэдэлт үгийн толь» (Шилчонмүнхагса, 2011), «Чэжү, Йе мен» (b хэвлэлийн газар, 2019) зэрэг цуврал шүлгийн түүврээрээ Солонгост шилжин ирсэн г адаад ажилчдын амьдрал, бодит байдлыг яруу найргаар тууштай эрэлхийлсэн. Үүнд амьд үлдэхийн эрхээр БНАСАУ-ыг орхисон Умардын элэг нэгтнүүд ч багтана.

Үнэндээ солонгосын нийгэм дэх гадаад ажилчдад өнгөрсөн цагт солонгос ажилчдын амссан шарх, зовлон давтагдаж байна гэхэд хэтрүүлэг болохгүй. Ардчилалд хүрэх явцад хөдөлмөрий н нөхцөл сайжирсан гэдэг ч ёроолд тунасан тунадас мэт үлдсэн олон асуудал байсаар байна. Иймээс гадаад ажилчдыг тойрсон хөдөлмөрийн элдэв асуудал солонгосын өөрийн асуудлууд тай уялдаж, шийдэхэд амаргүй болжээ. Түүнчлэн солонгосын нийгмийн дотор үйлчилж буй ул с төр, эдийн засгийн колоничлох дотоод логикийг орхигдуулж болохгүй. Солонгосоос улс төр, эдийн засгийн хувьд дор гэж үзсэн Азийн хөрш орнуудад хандах өрөөсгөл ойлголт нь дэд имп ериализмын (準帝國主義, sub-imperialism) хэлбэрээр илрэх нь бий. Үүний цаана Солонгос Азийн үндэсний улсуудын дунд ардчиллыг нутагшуулсан гэх бахархал, тэр явцад үсрэнгүй өссөн үнд эсний эдийн засаг нь хөгжиж буй орны байр сууриас хөгжингүй орны зэрэгт хүрсэн учраас Аз ийн соёл иргэншлийг манлайлна гэсэн далд ухамсар оршдог. Гэвч неолиберал бодлогоор хөд өлмөрийн зах зээлийг уян хатан болгохын хэрээр Азийн хямд ажиллах хүч Солонгост орж ирж, үүнээс үүдсэн олон асуудалд солонгосын нийгэм зохих ёсоор хариу өгч чадаагүй.

Ийм шүүмжлэлт байр сууринаас Ха Жон О цусны цэвэр угсааны үзэл, төр төвт үзэл буюу ир гэний харьяалалд тулгуурласан үндэсний үзэлд автаж буй солонгосын нийгмийн ичгүүрт та лыг нууж хаалгүй илчилж, гэрчилж, шүүмжилдэг. Нэг улсын хүрээнд хязгаарласан үзлийн ха ралган байдлаас гарахгүй бол орчин үеийн үндэсний улсын овоорсон асуудлыг давж чадахг үй. Гадаадын цагаач ажилчид шиг хүч дорой хүмүүс бүгд хамтдаа аз жаргалаа хуваалцан ам ьдрах нь л олон соёлт эрин үеийн жинхэнэ амьдрал мөн гэсэн яруу найргийн үнэнийг Ха Жо н О шүлгэлдэг байна.

Удахгүй хүүхэд төрнө / Эхнэр нь томорсон гэдсээ тэврэхэд / Нөхөр нь хараад инээмс эглэнэ / Анхны хүүхэд ч холимог угсаатай төрнө гэж / Хоёр дахь хүүхэд ч холимог угс аатай төрнө гэж / Эхнэр нь бодсонгүй / Тэд тариалангийн газрын эзэд болно гэж / Тэд удмын залгамжлагчид болно гэж / Эр нөхөр нь боджээ

— Ха Жон О, «Косиан(Korean Asian) тосгон», «Ази гаралтай солонгосчууд», Самчан, 2007. Хэсгээс.

Яг одоо / Солонгост амаржсан солонгос эх / Төрсөн ээжийнхээ чанасан далайн байца атай шөлийг ууж байна / Яг одоо / Солонгост амаржсан Вьетнам эх / Солонгост амар жсан Филиппин эх / Солонгост амаржсан Тай эх / Солонгост амаржсан Камбож эх / Х адам ээжийнхээ чанасан далайн байцаатай шөлийг ууж байна / Яг одоо / Нялх үрс иж илхэн дуугаар уйлж байна

— Ха Жон О, «Дэлхий даяарх нярайлсан эхийн асаргаа», «Эзэнт гүрэн», Мүнхагдоннэ, 2011.

Тийм ээ. Солонгосын нийгэм олон соёлт болохын шинж тэмдгийн үеийг давж, олон соёлт өд өр тутмын амьдралаар амьдарч байна. Дэлхийн өнцөг булан бүрээс ирсэн хүмүүс солонгос ын нийгмийн хүч дорой гадаадын диаспора болон амьсгаа даран амьдрах бус, бие биеийнхэ э олон соёлын үнэт зүйлийг хүндэтгэж, хамтдаа аз жаргалтай амьдрах учиртай. Тиймээс сол онгосын яруу найраг дэлхийн иргэдийн сайхан амьдралын орон зай болон шинэчлэгдэх өрг өн зорилтыг биелүүлэхийн тулд гоо зүйн ёс зүйгээ боловсронгуй болгох бүтээлч, жаргалтай шаналлыг үүрч байна.

(2) Хүүрнэл зохиол дахь диаспора

1) Гадаадын иргэдийн цагаач хөдөлмөр: «Би энэ дэлхийг үрчилж авахаар шийдсэн.»[4)]

XXI зууны солонгосын уран зохиолд гадаадын цагаач ажилчин танил бус дүр байхаа больжээ. 1980-аад оны сүүлээс солонгосын нийгэмд орж ирж эхэлсэн Азийн цагаач ажилчид «Үйлдвэ рлэлийн дадлагажигчийн тогтолцоо» (1991–1993), «Хөдөлмөр эрхлэх зөвшөөрлийн тогтолцо о» (2004–2006)-ны үеийг туулан, солонгосын нийгмийг бүрдүүлэгч бүрэн эрхт субъект болж ээ. Үүнтэй хамт олон соёлт нийгмийг бодитоор авч үзэх нийгмийн зорилт урган гарсан юм.[5)] К им Жэ Ёны «Заан» өгүүллэг («Заан», Шилчонмүнхагса, 2005), Пак Бом Шиний «Намастэ» ром ан (Хангёрэшинмүнса, 2005), И Мён Наны «Эцэг нэгт ах дүүс минь» роман (Шилчонмүнхагса,

4) Сон Хон Гю. "Ислам махны дэлгүүр". Мүнхаггважисөнса, 2010, 236-р тал.

5) Энэ талаар Пак Гён Тэ. "Цөөнх ба солонгосын нийгэм". Хүманитас, 2008, 72–75-р талыг үзнэ үү.

2005), Кон Сон Огийн «Хэсүүчлэгч гэр бүл» цуврал хүүрнэл зохиол (Шилчонмүнхагса, 2005), Сон Хон Гюгийн «Ислам махны дэлгүүр» роман (Мүнхаггважисөнса, 2010) зэрэг нь энэ асуу длыг шууд авч үзсэн анхдагч бүтээлүүдэд бүрэн нийцэх билээ.

Тэгвэл гадаадын цагаач ажилчид солонгосын нийгэмд ямар нөхцөлд амьдарч байгааг Ким Жэ Ёны «Заан» өгүүллэгийн нэг хэсгээс харъя.

«Заан» өгүүллэгт солонгос ажилчин Пил Ён, гадаад ажилчдын хоорондох ярианаас тодорхой харагдаж байгаачлан, гадаад ажилчид ялгавартай хандлагад өртдөг нь зөвхөн «гадаад хүн» г эдгээс шалтгаалахгүй. Үүний цаана 1960-аад оны хөгжлийг зорьсон дарангуйллын үеэс хойш эдийн засгийн өсөлтийг бүхнээс дээгүүр тавих харалган домогт баригдан, «ажилчин»-ы хүни й эрхийг зөрчиж ирсэн солонгосын нийгмийн ужиг асуудал давхар оршдогийг зохиол заажээ. Ажилчдын ийм асуудлыг 1970–1980-аад оны үндэстэн, ард олны уран зохиолын чиглэлийн б үтээлүүдээс олонтоо харж болох ч 1990-ээд оноос солонгосын хүүрнэл зохиолд энэ уламжла л бараг тасрахад хүрсэн. Гэвч хөдөлмөрийн орчин дахь бүтцийн хор уршиг, байдал хэлбэрий н хор уршиг шинэ хэлбэрээр оршсоор, тэр зөрчил, шударга бус байдал солонгос ажилчдад т усаж байсан шигээ гадаадын цагаач ажилчдад бүхлээрээ шилжин очиж буйг Ким Жэ Ён анха арч авч үзсэн байна. Үүний зэрэгцээ Солонгосын хөдөлмөрийн зах зээлд гадаад ажилчдыг я лгаварласан, дээд доод гэсэн шаталсан харилцаа үүсэж байгааг тод харуулна. Пил Ёны хэлсн ээр гадаад ажилчид солонгос ажилчдын хийхийг хүсдэггүй «3D салбар»-т ажилладаг тул со лонгос ажилчидтай нэг зиндааны ажилчин анги биш мэтээр далд ойлгогдож байна. Өөрөөр х элбэл, нэг ангид харьяалагддаг атлаа үндэс угсаа, арьс өнгөөр ялгаварласны улмаас тэд «ан гиас ч доогуур анги» буюу «хамгийн доод давхарга» (underclass) болж доройтож байна.[6)]

Гадаадын цагаач ажилчдыг өгүүлсэн солонгосын уран зохиолд анхаарахуйц уран сэтгэмж б ий. Ингэж гадаадын диаспорагийн амьдралд тулгарсан асуудлыг Өрнөд төвтэй орчин үеийн капиталист дэг журмын хүрээнд шийдэх үү, эсвэл орчин үеийг даван гарах тухай урьдаас яа ран өгсөн үзэл санаанд тулгуурлан шийдэх үү гэдгийг авч үзээгүй. Харин тэд өөрсдөдөө тун танил арга зам (байгалийн далд нууцлаг чанар, домгийн төсөөлөл)-д түшиглэн, харь оронд ажиллаж амьдрахын хүнд бэрхийг хэрхэн даван туулж буйг уран сэтгэмжээр дүрслэн харуу лжээ. Мэдээж, солонгосын уран зохиолд болгоомжлох зүйл бий. Энэ нь байгалийн далд нуу цлаг чанар, домгийн төсөөллөөр гадаадын цагаач ажилчдын бодит байдлыг судлан дүрслэх дээ Өрнөдийн ориентализмыг урвуулан, Ази руу хандсан Солонгосын өөр нэгэн ориенталис т харцаар Азийг харь болгон авч үзвэл өрнөд төвт орчин үеийг дотроо улам гүн шингээж мэ днэ. Гол нь ийм империалист үзэл хандлагыг шүүмжлэлтэйгээр ойлгохын зэрэгцээ байгалий н далд нууцлаг чанар, домгийн төсөөлөлд буй боломжийг ашиглан, Өрнөд төвтэй, цорын га нц загвар мэтээр ойлгогдсон орчин үеийг бүтээлчээр даван гарах «орчин үеийн өөр хувилб ар»-ыг эрэлхийлэхээс татгалзаж болохгүй юм. Тухайлбал, Пак Бом Шиний «Намастэ»-д дав

---

6) Кевин Грэй. «Солонгосын цагаач ажилчид "ангиас доогуур" анги болох нь». Жо Гэ Вон орчуулсан. "Ази судлал" (아세아연구), № 116. Корё их сургуулийн Азийн асуудал судлах хүрээлэн, 2004.

тан дүрслэгдэх Балбын нууцлаг байгаль, хиндү соёлыг төлөөлөх олон бурхан, тэдэнтэй холб огдох домгийн баялаг төсөөллийг Солонгосын капитализмын дунд шидэгдсэн цагаач ажилч ин хатуу амьдралаас хялбархан зугтах гэсэн хүүрнэл гэж тайлбарлахад учир дутагдалтай. Э дгээр нь орчин үеийн эрх зүйн тогтолцоонд хүний эрхийг баталгаажуулах гэсэн оролдлого, өөрөөр хэлбэл «иргэн» хэмээх орчин үеийн хэм хэмжээний дотор л зөвшөөрөгдөж, гадна нь зөвшөөрөгддөггүй хүний хэт явцуу байр суурийг үгүйсгэн, түүнийг шүүмжлэн эргэцүүлэх бо ломж өгдөг. Тиймээс орчин үеийн хэм хэмжээний гадна шахагдсан хүн ба байгалийн амин х олбоо, мөн амьдралын уг үндсийн тухай эргэцүүллийг шинээр нээн олсон нь солонгосын ур ан зохиол гадаадын цагаач ажилчидтай учирснаар дахин эргэцүүлж олж авсан уран зохиол ын үнэт баялаг мөн билээ.

Энэ утгаараа солонгосын уран зохиол гадаадын цагаач ажилчидтай учирсан нь бусдыг тани н судлах шинэ боломж нээсэн гэхэд хэтрүүлэг болохгүй. Сон Хон Гюгийн «Ислам махны дэл гүүр» роман солонгос хүн, гадаадын цагаач ажилчны харилцаагаар зогсохгүй, цагаач ажилч дын хоорондын харилцааг ч хамруулан, Солонгосын олон ургальч нийгмийн байдлыг өргөн өөр өгүүлдэг. Өөрөөр хэлбэл, солонгосын уран зохиол Азийн диаспорагийн хүмүүстэй ямар харилцаа тогтоох ёстой, тэр харилцаан дунд бид хэрхэн амьдрах учиртайг хүүрнэлийн үнэн ээр эргэцүүлэхэд хүргэнэ.

Зохиолын турк дүр Хасан, түүний үрчилж авсан солонгос өнчин хүү «би» хоёрын яриаг гада адын диаспораг дүрслэх солонгосын уран зохиолын ололт гэж онцолмоор байна. Шархтай х үмүүсийн чин сэтгэлийн ярианаас орчин үеийн капиталист дэг журмыг давсан, бусдын хоор онд үүсэх шинэ ёс зүйн мэдрэмж бодитой хэрэгжих шинжийг олж харсан нь солонгосын ура н зохиолын томоохон амжилт юм.

Би дуусгасан газрын зургаа Хасан ахын дэрний дэргэд тавиад, мөргөлийн цагаараа сэрэхийг нь хүлээж байлаа. Мөргөл хийхээр боссон Хасан ах миний хийсэн зургийг чимээгүйхэн ширтэв.

— Чи хүн хүнийг холбодог үл үзэгдэх утсыг олчихсон юм шиг байна.
— Тэрийг надад заасан хүн чинь та шүү дээ, ах аа. Өөрийнхөө царайг хар даа. Та ямар ч сол онгос хүнээс илүү солонгос, ямар ч турк хүнээс илүү турк харагдаж байна.
— Солонгос уу, турк үү гэдгийг ялгахын аргагүй гэсэн үг биз дээ.
— Тийм ээ. Ялгахын аргагүй болно гэдэг. Хүн бүр тийм болж чаддаггүй шүү дээ.
— Чиний зурагт бол хэн ч тийм болж чадах юм шиг байна.
— Тийм болохоор л зураг байгаа юм. Бодит амьдралд боломжгүй мөрөөдөл шиг зүйл.
— Би чамайг өөрийн мэдэх бодит амьдралыг буулгасан гэж бодлоо.
— Мэддэг байлаа гээд бодитоор байдаг гэсэн үг биш шүү дээ. Хайр, нөхөрлөл, энх тайван, э рх чөлөө... Тэр үгсийг мэддэг ч бодитоор нь харж байгаагүйтэй адил.
— Би чамд түүнийг заагаагүй. Гэхдээ чамайг ийм зүйлийг мэддэг болно гэж гадарлаж байсан. («Ислам махны дэлгүүр», 220-р тал.)

Хасаны харсан «миний» дуусгасан зураг нь дэлхийн олон орны хүмүүсийн нүүр царайгаар б үтсэн дэлхийн газрын зураг юм. Хасан тэр зургаас хүмүүс орчин үеийн улс төрийн зааг болс он хилээр хатуу тусгаарлагдахын оронд нэгэн дэлхийд аясаараа нийцэн орших, орчин үеэс цаадах ертөнцийг олж харжээ. “Би”-гийн хэлснээр ийм бодит байдал одоохондоо байхгүй ч “Хасан”, “би” хоёр тийм ертөнцийг мөрөөдөхөө зогсоохгүй байна. Дээрх яриа гадаадын цага ач ажилчдыг өгүүлсэн солонгосын уран зохиол улс төрийн төсөөллийн хүрч болох зах хязга арыг харуулсан гэхэд болно. Солонгосын уран зохиол гадаадын цагаач ажилчидтай учрахда а бусадтай шинэ харилцаа тогтоох тухай сэтгэлгээний хүрээг тэлсэн хүүрнэлийн үнэнээр да мжуулан Өрнөд төвт орчин үеийг даван гарах боломжийг олжээ.

2) Хувьсамтгай дутуу оршихуй: «Харь хүн гэдэг нь өөрчлөгдсөнгүй.»[7)]

Гадаадын диаспораг өгүүлсэн зохиолуудаас Чон Үн Ёны «Баяртай, цирк минь» роман (Мүнха гдоннэ, 2005), Со Сон Наны «Сыон» роман (Санжини, 2016), Ким Ён Сүгийн «Бүгдэд буянтай шинэ он» өгүүллэг («Дэлхийн хязгаар дахь найз бүсгүй», Мүнхагдоннэ, 2009) нь өмнө үзсэн цагаач хөдөлмөр, ажилчдыг дүрсэлсэн хүүрнэлээс өөр талыг харуулдаг. Эдгээр бүтээл гада адын диаспорагийн хохирол, зовлон төвтэй хүүрнэлийг голлохын оронд солонгос хүмүүстэй тогтоосон харилцаанд нь хүний амьдралын уг үндсийн асуудлыг хамтад нь эргэцүүлдгээрээ онцлог. Шүүмжлэлийн хувьд арай эртэдсэн дүгнэлт байж болох ч эдгээр нь солонгосын ний гэм дэх гадаадын диаспорагийн амьдралыг гадуурхан ялгаварлах үйлдэл нь хэлбэр байдлы н хор уршиг, бүтцийн хор уршгийг дүрслэх төдийд сэтгэл ханадаггүй. Солонгосын нийгэмд т одорхой хэмжээнд суурьшсан диаспорагийн улс төр, нийгмийн амьдрал тэр нийгэмтэй уулз ах явцад хүний амьдралыг илүү язгуураас нь сэтгэх гэсэн солонгосын уран зохиолын ололтт ой холбоотой юм.

Ким Ён Сүгийн «Бүгдэд буянтай шинэ он»-д энэтхэг цагаач ажилчин гардаг. Тэр Солонгост г адаадын цагаач ажилчны хэв шинжит амьдралаар амьдрах бөгөөд солонгос хэлнийхээ эмэ гтэй багшийн гэрт олон жил хөндөлгүй орхисон төгөлдөр хуурыг хөглөхөөр очно. Багшийгаа эзгүйд урьд нь уулзаж байгаагүй нөхрөөс нь төгөлдөр хууртай холбоотой түүхийг сонссоор, тэд аажмаар дотносдог. Мэдээж, энэтхэг ажилчны солонгос хэл тааруу тул нөхөртэй нь бүр эн ойлголцож чадахгүй. Гэвч хэлний саад нь чин сэтгэлээ хуваалцахад шийдвэрлэх саад бо лдоггүй. Тэд дассан хэвийн аргаар чөлөөтэй ярилцаж чадахгүй ч нөхөр нь энэ дутуу яриана ас тун чухал үнэнийг олж мэднэ. Цагаач ажилчин солонгос хэл сурах явцдаа багш Хэжиний хээ буюу нөгөө хүний эхнэрийн дотоод ертөнц туйлын ганцаардмал, эзгүй хөндий болохыг м эдэрсэн бөгөөд үүнийг алдаатай, түгдэрсэн солонгос хэлээр нөхөрт нь ярьдаг. Эхнэрийнхээ тэр дотоод байдлыг анзаарч чадаагүй нөхөр цагаач ажилчны гярхай олж харсан хүн болохы н хувийн ганцаардлыг нь ойлгон мэдэрч, хэзээнээс ч юм өөрөөс нь хөндийрч эхэлсэн эхнэр

---

7) Со Сон Нан. “Сыон”. Санжини, 2016, 18-р тал. Цаашид энэ бүтээлийн үндсэн эхээс эшлэхдээ тусгай зүүлт хийхгүй, үндсэ н бичвэрт хаалт дотор хуудасны дугаарыг тэмдэглэнэ.

ийнхээ амьдралыг эргэцүүлнэ.

Тус тусын оршихуйн ийм ганцаардал Чон Үн Ёны «Баяртай, цирк минь» романы гол дүрүүдэ д ч нийтлэг. Бага насны сэтгэлийн гэмтлээс үүдэн сэтгэцийн бэрхшээлтэй болсон ах нь Хята дын Яньбяний солонгос үндэстэн Хэхва хэмээх эмэгтэйтэй гэрлэж, аз жаргалтай гэр бүлийг хүснэ. Гэвч тэдний жаргал удаан үргэлжлэхгүй. Эхнэр нь орхиод явчих вий гэсэн айдас, хий бодлоосоо болж ах нь түүнд сэтгэлийн дарамт учруулж, хорьж цагдсантай адил шархлуулд аг. Нөхрөөсөө бүрэн авч чадаагүй жаргал, нөхрийнхөө дүүд татагдах сэтгэл, нутгаа орхисон диаспорагийн амьдралын гүнд орших харь хүний оршихуйн ганцаардал зэрэг нь холилдсоо р эцэст нь тэр нөхөр, гэр хоёроо орхин явна. Ах дүү хоёр түүнийг хайж Хятадын Яньбянь хүр тэл очсон ч олж чадалгүй, буцах усан онгоцон дээрээс ах нь далай руу үсэрдэг. Энэ зохиоло ос харагдаж байгаачлан, хятадын солонгос үндэстэн эмэгтэйн диаспорагийн амьдрал солон гос хүмүүсийн амьдралд гүн шингэнэ. Үүний эхлэл нь гэрлэлтийн шалтгаант цагаач эмэгтэй н амьдралаас үүдэлтэй. Тэр эмэгтэйн диаспорагийн амьдралын самуун Яньбянь нутгийн ут га агуулгад шингэсэн эртний Бохай улсаас эхтэй мэт. Зүүн Азийн эх газрын зах хязгаарт нэгэ н цагт «Далайн дорнодын цэцэглэн мандсан улс» хэмээн алдаршсан ч сүр жавхаа нь түүхэн д замхарч, мөр нь хэний ч анхаардаггүй уйтай балгасны үлдэгдэл болон хоцорчээ. Ийн доро йтон буй Яньбяний бодит байдал Хэхва шиг хятадын солонгос үндэстэн эмэгтэйг боломж л г арвал харь хүний элдэв бэрхшээлийг тэвчээд ч болов Солонгост диаспорагийн амьдралаар амьдрахыг хүсэхэд хүргэдэг. Энэ хүсэл нь түүнтэй холбогдсон ах дүү хоёрын амьдралын ша рхнаас ургасан оршихуйн ганцаардалтай давхцаж, солонгосын нийгмийн гүнд шингэсэн өөр өөсөө хөндийрөх асуудлыг улам нарийн эргэцүүлэхэд хүргэнэ.

Үүнтэй холбоотойгоор Со Сон Наны «Сыон» бол онцгойлон анхаарах бүтээл юм. Өнгөц хара хад Солонгосын уулын Каилли тосгонд гэрлэж ирсэн вьетнам эмэгтэй Сыон, тэндэх цагаан байшинд амьдардаг солонгос эхнэр нөхөр буюу Жан, И Рён нарын хоорондох гэр бүлээс гад уурх харилцааг өгүүлсэн мэт. Гэвч зохиолч үнэндээ Сыон, эхнэр И Рён хоёрын харилцаанд т өвлөрдөг. Гэрлэж цагаачилсан Сыон-ы гадуурхагдал, сэтгэлийн шарх И Рёны амьдралтай д авхцаж, харилцаа нь улам гүнзгий болно. Өөрөөр хэлбэл, И Рён «гол гатлан харь оронд бэр болж ирсэн гадаад эмэгтэйгээс ялгаагүй байлаа» (250-р тал). Сыоныг Каиллигийн хүмүүс а жиглан хянаж, хамт олныхоо гишүүнээр хүлээн зөвшөөрөхийн оронд нийгмийн болон орши хуйн тодорхой зай барьдагтай адил цагаан байшингийн И Рён ч тосгонд Сыонтэй ижил байд алд оршино. И Рёны нөхөр Жантайгаа таарамжгүй болсон харилцаа, хадмынхантайгаа үүсгэ сэн зөрчил нь илрэх хэлбэрээрээ өөр боловч Сыоны нөхөр, хадам эхтэйгээ зөрчилдөхтэй тө стэй. Тиймээс ч юм уу, Сыон, И Рён хоёр бие биеэ энэрэн харж, хориотой заагийг даван хай рлалцана. Сыоны хувьд И Рён нь Каилли дэх өөрийнх нь амьдрал туссан өөр нэгэн «би» бай ж мэднэ. Солонгост амжилтад хүрэх их мөрөөдөлтэй ирсэн вьетнам эмэгтэй Сыон тосгонд мөрөөдөл нь бөхөж буйг хүлээн зөвшөөрөхөөс аргагүй болдог. Үүнтэй адил нэгэн цагт нэр х үндтэй зохиолч явсан И Рён дахин гайхагдан гялалзахыг хүсэвч Каиллид шинэ бүтээл нь бич

игдэхгүй, амьдралын шарх нь үргэлжилсээр. Иймээс И Рён бол Сыоны Каиллид нүүр тулсан өөрийнх нь дүр юм. Нөгөө талаас И Рёнд Сыон нь «харь оронд бэр болж ирээд ганцаардлыг тэвчин амьдрах гэнэн эмэгтэй шиг харагдсангүй. И Рён «ид зуны нарны гэрэл шиг хурц, хүч тэйгээр харцанд нь тусах, сэтгэл татам, өдөөнгүй эмэгтэйн гоо үзэсгэлэнгээс нүүр буруулж, татгалзаж чадахгүй» (250-р тал). Сыон нь ийнхүү И Рёны эрэлхийлэхийг хүсдэг «гоо зүйн төгс зайлшгүй чанарыг бий болгож чадах оновчтой хэлэнд итгэх итгэл»-ийг (26-р тал) түүнээс ундруулан авч болох гоо зүйн объект юм. Үүнийг нягтлан бодвол И Рёны хүсэл нь явцуу утга араа Со Сон Нан хэмээх нэг зохиолч, өргөн утгаараа 2000-аад оны солонгос зохиолчдын өмнө тулгарсан диаспораг хүүрнэлээр дүрслэх асуудлыг хөндөнө. Тэгэхээр «Сыон»-оос солон госын нийгэмд шинээр анхаарах гадаадын диаспорагийн асуудал нь харь нутагт хохирол, зовлон амсахыг нь дүрслэх төдийд хязгаарлагдахгүй. Солонгосын нийгмийн өнцөг булан бүрд амьдарч буй диаспораг олон давхаргатай, гүнзгий дүрслэх асуудалтай холбогдоно.

Товчхондоо, «Сыон», «Баяртай, цирк минь», «Бүгдэд буянтай шинэ он» зохиолд оролдсоны адил, солонгосын хүүрнэл зохиол Солонгосын нийгэм дэх гадаадын диаспорагийн «тухай» хүүрнэлээр эрэл хайгуул хийхийн зэрэгцээ диаспорагийн амьдралаар жам ёсоороо «амьдрах» хүүрнэлээр судлах эрэл хайгуулыг ч эрчимтэй өрнүүлж байна. Энэ нь бүх төрлийн диаспора төдийгүй үүнтэй холбоогүй гэж үзэхэд амархан тухайн улсын нийт иргэдийг ч хамруулж, хүний «хувьсамтгай дутуу оршихуй»-д агуулагдах «харь хүн гэдэг нь өөрчлөгдсөнгүй» гэсэн санааны талаар уг үндсийг нь хөндсөн асуулт тавьж байна.

4. Дэлхийн шинэ уран зохиол болох диаспорагийн уран сайхны дүрслэл

Диаспорагийн амьдрал, бодит байдлыг авч үзэх нь дэлхийн уран зохиолын гол чиглэлүүдийн нэг юм. Учир нь диаспора дэлхий дахины капиталист тогтолцоотой маш нягт холбоотой бөгөөд зөвхөн нэг улсын хүрээнд сэтгэх үзэлд тулгуурласан үндэсний уран зохиолын уламжлалт өнцгөөс диаспорагийн «тухай» төдийгүй диаспорагийн хувиар «амьдарч буй» амьдралыг бүхэлд нь, олон талаас нь гүнзгий дүрслэх боломжгүй юм. Гэхдээ энэ нь үндэсний уран зохиолын асуудлыг олж харах, дэвшүүлэх хандлагыг бүхэлд нь үгүйсгэе гэсэн үг огт биш. Даяар шлын эринд улс орны хилээс эхлээд биет болон биет бус бүхий л зааг суларч, улс хооронды н төрөл бүрийн холбоо, улс төр, эдийн засгийн нэгдэл бий болж, өмнөх байгууллага, нэгдлүүд ганхаж, задрах үйл явцыг бид туулж байна. Гэсэн хэдий ч төр улс улс төрийн байгууллын хувьд улам бэхжиж буй олон улсын нийгэмлэгийн бодит нөхцөлд үндэсний уран зохиолын хөндөн тавих асуудлууд өөрийн гэсэн үнэ цэнтэй. Үүний зэрэгцээ огт орхигдуулж болохгүй зүйл бол дэлхийн уран зохиолын өнөөгийн байдалд сэтгэл ханан тогтсон үндэсний уран зохиолоос салж, дэлхийн шинэ уран зохиолд идэвхтэй нөлөөлж, оролцож, түүнийг бүтээлцдэг үнд

эсний уран зохиол болон шинэчлэгдэх шаардлага юм. Тиймээс зохиогч миний бие боломж г арах бүрд онцолдогчлон, Европ, Америк төвтэй үзлийг өөртөө шингээсэн дэлхийн уран зохи олын шаталсан бүтцийг бүрдүүлдэг үндэсний уран зохиолын хувьд дэлхий даяарх диаспора гийн агуулж буй «орчин үеийн өөр хувилбар»-т чиглэсэн уран зохиолын үйл ажиллагааг хэр эгжүүлэх боломж алс хол хэвээр байна. Учир нь Европ, Америк төвтэй үзэлд баригдсан үндэ сний уран зохиол диаспораг дүрслэхдээ дэлхийн тогтолцоонд бүрэн дасан зохицож чадаагү й, хоцорч үлдэгсэд, ялагдагсад, ялагдал болон дорд байдлын мэдрэмжид автсан хүмүүс гэх мэтээр нэгтгэн үздэг хүч дорой хүмүүсийн бодит байдалд анхаарлаа хандуулдаг. Гэвч ийм д үрслэл нь эцсийн дүндээ эцэсгүй муу давталт бүхий капиталист дэлхийн тогтолцоог бүрдүү лэхэд чиглэсэн уран сайхны дүрслэлийн ёс зүй болон улс төрийг дахин үйлдвэрлэхэд үйлчл эхээс төдийлөн ялгаагүй юм.

Тиймээс бидний ул суурьтай анхаарах ёстой зүйл бол ийм дэлхийн уран зохиол болон үндэ сний уран зохиолд ан цав гаргаад зогсохгүй, тэдгээрийг даван гарахын тулд соёл иргэншли йн шинэ хувилбар болох амьдралын боломжийг өөрсдөө биеэр туулж буй диаспораг хэрхэ н дүрслэх талаар нухацтай эрэл хайгуул хийх явдал юм. Өнөөг хүртэл энэ асуудлыг солонго с зохиолчдын үзэл өнцгөөс, солонгос хэлээр авч үзэж ирсэн бөгөөд цаашид ч улам өргөн, гү нзгий авч үзэх шаардлагатай. Харин цаашдаа Солонгосын нийгэм дэх гадаадын диаспораг т эдний өөрсдийн үзэл өнцгөөс, өөрсдийнх нь хэлээр дүрслэн үзүүлбэл соёл иргэншлийн шин э хувилбар болох амьдралын боломжид чиглэсэн уран зохиолын үйл ажиллагаа улам амьта й болно. Иймээс солонгосын уран зохиолд (мөн түүний зааг хүрээнд) гадаадын диаспорагий н өөрсдийн амьдралын асуудлыг ойлгож, хөндөн тавьж буй байдлыг хэрхэн дүрслэх вэ гэдэ г нь нэн чухал асуудал юм. Энэ нь мөн даяаршлын эрин дэх солонгосын уран зохиол дэлхий н шинэ уран зохиолыг бүтээлцэх боломжтой холбоотой, уран зохиолын хүрээнд хэлэлцэх го л асуудлын нэг юм. (Төгсөв.)

* Энэ өгүүллийг зохиогч уг асуудлаар өмнө хийсэн ажлуудаасаа энэхүү Солонгос–Монголын форумы н онцлогт нийцүүлэн хэсэгчлэн авч, заримыг засаж, дахин зохион байгуулан бэлтгэв. Холбогдох бүт ээлүүд: «2000-аад оны солонгос хүүрнэл зохиолд илэрсэн хуваагдлын тогтолцооны асуудлын ухамс ар», «Солонгосын уран зохиолын “модерн чанарын олон хэлбэр”: Азийн бусдыг шинээр нээх нь», “Га нхаж буй газрын хүүрнэл” (Богоса, 2016); «Гадаадын иргэдийн шилжилт хөдөлгөөнийг харах өнцгий г давсан яруу найргийн гоо зүйн ёс зүй», “Реализм бол найдвар” (Пүрынсаасан, 2015); «XXI зууны со лонгосын уран зохиол ба реализм: Эсэргүүцэл, өөрчлөн хувиргах төсөөллөөр», “Ясан цэцэг дэлгэрн э” (Кэпоийбүкс, 2009).

Ко Мён Чөл

Кван Үн их сургуулийн Солонгос хэл, уран зохиолын тэнхимийн профессор. 『Дэлхийн уран зохиолын цаана』, 『Уран зохиолын татах хүч』, 『Ясан цэцэг дэлгэрнэ』 зэрэг бүтээл туурвисан.

Хэлэлцүүлэг 6

「Даяаршлын эрин дэх солонгосын уран зохиолын хараанд буй диаспора」илтгэлийн хэлэлцүүлэг



Пак Ким Санъ Сөүлийн Шинжлэх ухаан, технологийн их сургууль

Өнөөдрийн энэ хүндэтгэлийн арга хэмжээнд илтгэлийн эхийг урьдчилан уншиж, асуулт бэлт гэх боломж олдсоныг нэр төрийн хэрэг гэж үзэж байна. Багш Та Өрнөдийн уран зохиол төвт эй дэлхийн уран зохиолын дэг журам, үзэл баримтлалыг шүүмжлэлтэйгээр эргэцүүлэн авч үзэж, уг эргэцүүллээ Өрнөдийн бус уран зохиолын шүүмжээр дамжуулан бодит ажил болгож ирсэн билээ. Энэ удаагийн «Даяаршлын эрин дэх солонгосын уран зохиолын хараанд буй ди аспора» илтгэлийг ч мөн уран зохиолын хүрээнд үзэл санаагаа бодит үйл хэрэг болгох ийм и дэвхтэй үйл ажиллагааны үр дүн хэмээн уншиж ойлголоо.

Илтгэл нийт дөрвөн бүлгээс бүрдэнэ. Бүлэг тус бүр нь «1. Диаспорагийн гишүүн өөрөө нэхэн асуух нь: “Гадаад хүн гэж ер нь хэнийг хэлээд байгаа юм бэ?”», «2. Дэлхий дахины капитали ст тогтолцоо ба Умард Солонгосоос дүрвэгсдийн диаспора», «3. Гадаадын иргэдийн шилжи лт хөдөлгөөн ба диаспора», «4. Дэлхийн шинэ уран зохиолын хувьд диаспораг дүрслэх нь» г эсэн гарчигтай. Миний ойлгосноор, энэ илтгэл нь Солонгост хэвлэгдсэн уран зохиолын бүтэ элүүдээс диаспорагийн утга учрыг эрэлхийлж, цаашдын дэлхийн уран зохиолын чиг хандла га нь диаспораг шинэ арга замаар дүрслэхэд оршино хэмээн үзсэн бичвэр юм.

Би орчин үеийн үндэсний улсын тогтолцоо баттай тогтсоноос хойших диаспораг хоёр ангил ан үзэж болно гэж бодож байна. Нэг нь улсын дотор бий болдог дотоод диаспора, нөгөө нь у лсын хил дамнасан дэлхий дахины диаспора юм. Илтгэл эдгээрээс дэлхий дахины диаспор

а, тэр дундаа Солонгост (Өмнөд Солонгост) гадаадын иргэн болж амьдарч буй диаспорагий н хүмүүст анхаарлаа хандуулжээ. Тэдэнд тулгарч буй хөдөлмөрийн бодит нөхцөл болон хоё рдугаар зэргийн иргэн хэмээн хавчигдаж буй улс төр, нийгмийн бодит байдлыг авч үзэхийн зэрэгцээ «аль хэдийн» тус улсын иргэн хэмээн хүлээн зөвшөөрөгдсөн солонгосчуудын сэтгэ л мэдрэмж, үзэл ойлголтыг шинжилсэн байна. Мөн солонгосчуудын үзэл өнцгөөс дүрслэгдс эн диаспорагийн онцлогийг нэгтгэн дүгнэсний дараа, уг дүрслэлийг диаспорагийн хүмүүсий н өөрсдийн үзэл өнцөг, өөрсдийн хэлээр бичсэн уран зохиолын бүтээлээр нөхөн баяжуулах шаардлагатай гэж үзжээ.

Таны илтгэлийн хэлэлцүүлэгчийн хувиар би дараах зүйлсийг бодлоо.

Илтгэл өөр хувилбар эрэлхийлэхэд голлон анхаарсан мэт санагдаж байна. Багш Та Хван Со г Ёны «Баридэги», Жөн До Саны «Зэрлэг сарнайн цэцэг» зохиолын шинэлэг талыг «үндэсний улсын хүрээнд хязгаарлагдан ойлгогддог үндэстний асуудал бус, дэлхий дахины капиталист тогтолцоотой нягт уялдсан бодит амьдрал дахь үндэстний асуудал хэмээн авч үзэж буйд ор шино» гэж онцолжээ. Энэ хэсэгт Та солонгосын үндэстний уран зохиолын цаашид баримтла х эерэг чиглэлийг олж харсан байна гэж би ойлголоо.

И Ын Жүний «Улсын хувийн амьдрал», Квон Ригийн «Солгой гарт ноён Ли», Ким Жэ Ёны «Заа н», Пак Бом Шиний «Намастэ», И Мён Наны «Эцэг нэгт ах дүүс минь», Кон Сон Огийн «Хэсүү члэгч гэр бүл», Сон Хон Гюгийн «Ислам махны дэлгүүр», Со Сон Наны «Сыон», Чон Үн Ёны « Баяртай, цирк минь», Ким Ён Сүгийн «Бүгдэд буянтай шинэ он», Ким Сү Ёлын «Яньбяний эмэ гтэй», Квак Хё Хваны «Умардаас дүрвэсэн гольфын туслах И Со Хи», Ха Жон Огийн «Косиан тосгон», «Дэлхий даяарх нярайлсан эхийн асаргаа» зэрэг бүтээлийг шинжилсэн хэсгээс дэл хийн иргэний ухамсартай субъектыг хүсэмжилсэн сэтгэл илэрч байна гэж ойлголоо.

Солонгос дахь диаспорагийн өвөрмөц байдал хуваагдлын нөхцөлтэй нягт холбоотой. «Умард аас дүрвэх»-ийг диаспора хэмээн утгажуулахдаа үндэстний ойлголтыг тэргүүнд тавибал дот оод диаспора, улсын ойлголтыг тэргүүнд тавибал дэлхий дахины диаспорагийн нэг салбар б олдог нь Өмнөд Солонгосын бодит байдал юм. Илтгэлд давтан онцолсон «гадаад хүн» хэмээ х ойлголт ч улсын болон үндэстний заагаас хамаарсан нэрлэн дуудах арга гэж бодож байна.

Би «Миний хуланц эмээ Польшид төрсөн. Элэнц эмээ Украинд төрсөн. Харин эмээ минь Сол онгост төрсөн. Ээж Америкт төрсөн. Би хаана төрсөн юм бол? Ээж хэлж өгдөггүй» гэсэн до гол мөрөөр эхэлдэг «Итгэл, найдвар, бас бар» романаа хэвлүүлсэн бөгөөд та уг зохиолын та йлбар өгүүллийг бичиж өгч байсан. Та энэ бүтээлийг диаспорагийн түүх хэмээн уншиж, дөр вөн үеийн эмэгтэйчүүдийн биеэр туулсан үйл явдлаар дамжуулан хүчирхийллийн үүсэл, түү

хийг дэлхийн түүхийн хам сэдэвт хүүрнэн өгүүлсэн гэж үнэлсэнтэй би гүнээ санал нийлсэн. Диаспора болон дэлхийн уран зохиол хэмээх ойлголтын талаар багш тантай уран зохиолын хүрээнд нийтлэг ойлголттой гэж хэлж болно гэж бодож байна.

Диаспора нь дэлхийн уран зохиолтой холбогдохдоо маш чухал мэт санагддаг. Дэлхийн уран зохиолыг өргөн утгаар нь дэлхийн иргэний ухамсартай субъект дэлхийн иргэдэд зориулан т уурвисан бүтээл гэж тодорхойлбол, зохиолын дүрийн бодит амьдрал улс, үндэстэн, хэлний заагт хашигдсан байлаа ч бүтээлд илэрхийлэгдэх ухамсар бодит заагийн цаана өрнөдөг гэж би бодно. Диаспора бол заагийн утга хамгийн хурцаар илэрдэг оршихуй юм.

Домгийн хүч, байгалийн далд нууцлаг чанарт түшиглэсэн төсөөллийг уран зохиолд ашиглах даа юуг зорих ёстойг тайлбарласан хэсгийг би удаан тунгаалаа. Тэр өгүүлбэрүүдийг шууд э ш татъя.

> *Гадаадын цагаач ажилчдыг өгүүлсэн солонгосын уран зохиолд анхаарахуйц уран сэт гэмж бий. Ингэж гадаадын диаспорагийн амьдралд тулгарсан асуудлыг Өрнөд төвтэ й орчин үеийн капиталист дэг журмын хүрээнд шийдэх үү, эсвэл орчин үеийг даван га рах тухай урьдаас яаран өгсөн үзэл санаанд тулгуурлан шийдэх үү гэдгийг авч үзээгү й. Харин тэд өөрсдөдөө тун танил арга зам (байгалийн далд нууцлаг чанар, домгийн т өсөөлөл)-д түшиглэн, харь оронд ажиллаж амьдрахын хүнд бэрхийг хэрхэн даван туу лж буйг уран сэтгэмжээр дүрслэн харуулжээ. Мэдээж, солонгосын уран зохиолд болг оомжлох зүйл бий. Энэ нь байгалийн далд нууцлаг чанар, домгийн төсөөллөөр гадаад ын цагаач ажилчдын бодит байдлыг судлан дүрслэхдээ Өрнөдийн ориентализмыг ур вуулан, Ази руу хандсан Солонгосын өөр нэгэн ориенталист харцаар Азийг харь болг он авч үзвэл өрнөд төвт орчин үеийг дотроо улам гүн шингээж мэднэ. Гол нь ийм имп ериалист үзэл хандлагыг шүүмжлэлтэйгээр ойлгохын зэрэгцээ байгалийн далд нууцл аг чанар, домгийн төсөөлөлд буй боломжийг ашиглан, Өрнөд төвтэй, цорын ганц загв ар мэтээр ойлгогдсон орчин үеийг бүтээлчээр даван гарах «орчин үеийн өөр хувилба р»-ыг эрэлхийлэхээс татгалзаж болохгүй юм.*

Эдгээр өгүүлбэрийг уншаад байгалийн далд нууцлаг чанар, домгийн төсөөлөл, орчин үеийн капиталист дэг журам нь дэлхий дахинд хэдийнээ удаан хугацаанд нийтлэг байсаар ирсэн г эж би ойлголоо. Тэдгээрийг уран зохиолд ашиглахдаа юуг зорих, юунаас сэрэмжлэх ёстойг та тодорхой ялгаж өгсөн байна гэж уншлаа. Тиймээс энэ хэсгийг дэлхийн уран зохиол, диас порагийн үүднээс жаахан дэлгэрүүлж, бичвэртээ бүрэн буулгаж амжаагүй бодол байвал ха мт хуваалцвал ямар вэ? Энэ нь үндэстний уран зохиол ба дэлхийн уран зохиол, үндэсний ур ан зохиол ба дэлхийн уран зохиолын харилцааг баттай ойлгох боломж, жинхэнэ дэлхийн ур

ан зохиолын эхлэл болж чадна гэж бодож байна.

Төгсгөлд нь би өөрийгөө диаспорагийн субъектын оронд тавьж, таны саналыг дахин нэг ун шъя. Баярлалаа.

Тиймээс бидний ул суурьтай анхаарах ёстой зүйл бол ийм дэлхийн уран зохиол болон үндэсний уран зохиолд ан цав гаргаад зогсохгүй, тэдгээрийг даван гарахын тулд соё л иргэншлийн шинэ хувилбар болох амьдралын боломжийг өөрсдөө биеэр туулж буй диаспораг хэрхэн дүрслэх талаар нухацтай эрэл хайгуул хийх явдал юм. Өнөөг хүртэ л энэ асуудлыг солонгос зохиолчдын үзэл өнцгөөс, солонгос хэлээр авч үзэж ирсэн б өгөөд цаашид ч улам өргөн, гүнзгий авч үзэх шаардлагатай. Харин цаашдаа Солонгос ын нийгэм дэх гадаадын диаспораг тэдний өөрсдийн үзэл өнцгөөс, өөрсдийнх нь хэлэ эр дүрслэн үзүүлбэл соёл иргэншлийн шинэ хувилбар болох амьдралын боломжид чи глэсэн уран зохиолын үйл ажиллагаа улам амьтай болно. Иймээс солонгосын уран зо хиолд (мөн түүний зааг хүрээнд) гадаадын диаспорагийн өөрсдийн амьдралын асууд лыг ойлгож, хөндөн тавьж буй байдлыг хэрхэн дүрслэх вэ гэдэг нь нэн чухал асуудал юм. Энэ нь мөн даяаршлын эрин дэх солонгосын уран зохиол дэлхийн шинэ уран зохи олыг бүтээлцэх боломжтой холбоотой, уран зохиолын хүрээнд хэлэлцэх гол асуудлы н нэг юм.

Пак Кым Санъ

Зохиолч, Сөүлийн Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн Уран зохиолын бүтээлч бичлэгийн тэн химийн профессор. 『Итгэл, найдвар, бас бар』, 『Хиймэл оюун ухааны бичсэн зохиол』, 『Эрчүүд гайхна, эсвэл айна』 зэрэг бүтээл туурвисан.

겨레말큰사전·몽골국립대학 국제학술포럼

갈라진 언어, 이어지는 숨결